

2015-2016 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН

Бүлэг 1. Удирдлага зохион байгуулалт, үндсэн нэгжийн бүтэц

2015-2016 оны хичээлийн жилд бүрэлдэхүүн 5, харьяа 2 сургууль, 1 ахлах сургууль, 38 тэнхим, 826 багш, 696 ажилтан, 24000 суралцагчтайгаар сургалт, судалгааны үйл ажиллагаа явууллаа. Тайлант онд Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль, Хууль зүйн сургуулийн тэнхмийн бүтцэд өөрчлөлт орсон. ХШУИС-ийн Хүрээлэн буй орчин судлал, химийн инженерчлэлийн тэнхмийг татан буулгаж, Хими, биологийн инженерчлэлийн тэнхим, Хүрээлэн буй орчин судлал, ойн инженерчлэлийн тэнхмийг тус тус шинээр байгуулсан. ХЗС-ийн Эрх зүй судлалын тэнхим, Төр, захиргааны эрх зүйн тэнхим, Иргэний эрх зүйн тэнхим, Эрүүгийн эрх зүйн тэнхим, Олон улсын эрх зүйн тэнхмийг татан буулгаж, Нийтийн эрх зүйн тэнхим, Хувийн эрх зүйн тэнхмийн бүтцэд шилжүүлээ.

Хүснэгт 1.1

Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн товч мэдээлэл

№	Бүрэлдэхүүн сургууль	Тэнхмийн тоо	Сургалт явуулж байгаа хөтөлбөрийн тоо /бак, маг, доктор/	Багшийн тоо	Ажилтны тоо	Оюутны тоо
1	Шинжлэх ухааны сургууль	19	63/76/29	421	143	10232
2	Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль	5	21/26/8	121	55	3699
3	Хууль зүйн сургууль	2	2/4/1	54	21	2246
4	Бизнесийн сургууль	-	9/14/1	93	69	4277
5	Олон улсын харилцаа нийтийн удирдлагын сургууль	-	3/6/2	18	16	1289
6	Завхан сургууль	5	6/7/-	25	43	656
7	Орхон сургууль	7	7/5/-	63	48	1625
8	БЭЛАС ЭБТ			21	16	
9	Хүрээлэн, төв				36	
10	Захиргаа				56	
11	Төвлөрсөн сан			10	193	
	ДҮН	38	111/132/41	826	696	24024

Хүрээлэн, төвд Монгол судлалын хүрээлэн, Багшийн хөгжлийн төв, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв; Захиргаа хэсэгт захиргааны алба, хэлтэсүүд; төвлөрсөн санд МТА, Номын сан, ХҮХ, хичээлийн болон оюутны байр, МУИС пресс, генийн инженерчлэлийн лабораториуд тус тус багтаж байгаа болно.


Нийт багш, ажилтнуудын дотор багш нарын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1 пунктээр буурч, гүйцэтгэх ажилтны эзлэх хувь 1 пунктээр өсч, удирдах болон үйлчилгээний ажилтнуудын хувьд өөрчлөлт ороогүй байна.

Багш, ажилтны тоог урьд оны мөн үетэй харьцуулан авч үзвэл багшийн тоо 46-аар, ажилтны тоо 11-ээр буурсан харагдаж байна. Энэ нь зөвлөх, гэрээт багш нарын

тоо буурсан болон тэтгэвэрт гарсан багш нартай холбоотой байна

График 1.1

Ажиллагсдын бүтэц /зэрэгцүүлсэн хичээлийн жилээр/



МУИС-ийн нийт багш нарын 49.2% нь эрдмийн зэрэг, цолтой багш нар байна. Завхан, Орхон сургууль, Байгаль-Эх лицей ахлах сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн багш нарыг хасч тооцвол нийт багш нарын 56.4% нь байгаа нь өмнөх хичээлийн жилтэй харьцуулбал 3,6 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хичээлийн жилд МУИС-д докторын зэрэгтэй 406 багш багшилсанаас үндсэн багш 320 /78,8%/, зөвлөх, гэрээт багш 86 /21,2%/ байна.

Хүснэгт 1.2


Эрдмийн зэрэгтэй багш нар /бүрэлдэхүүн сургуулиар/

№	Албан тушаал	Шинжлэх ухааны сургууль			ШУС	ХШУИС	БС	ОУХНУС	ХЭС	ОС	ЗС	Нийт дүн
		БУС	НУС	ХУС								
Үндсэн багш												
1	Доктор /Sc.D/	2	1	2	5		2					7
2	Доктор /Ph.D/	76	42	73	191	58	33	7	19	5		313
Зөвлөх багш нар												
1	Доктор /Sc.D/	2		3	5	1	1		1			8
2	Доктор /Ph.D/	8	4	15	27	7	7	3	2			46
Гэрээт багш нар												
1	Доктор /Sc.D/	1			1	1			3			5
2	Доктор /Ph.D/	5	3	4	12	8	2	1	4			27
НИЙТ		94	50	97	241	75	45	11	29	5	0	406

Эрдмийн зэрэгтэй үндсэн багш нараас 185 нь буюу 57,8% нь гадаадад, 135 буюу 42,2% нь дотоодын их дээд сургуульд докторын зэрэг хамгаалсан байна.

Сүүлийн 10 жилийн байдлаар нийт багш нарын дотор эрдмийн зэрэгтэй багшийн эзлэх хувийн жинг авч үзвэл сүүлийн жилүүдэд байнга өсөх хандлагатай явж ирсэн байна. /Энэ тоонд Орхон болон Завхан сургуулийн багш нарын тоо орсон болно./

График 1.2



2015-2016 оны хичээлийн жилд МУИС-ийн 17 багш докторын зэрэг хамгаалж /гадаадад 8, дотоодод 9/, сургуультай гэрээ байгуулан 10 багш гадаадын их, дээд сургуульд магистрантур, докторантурт суралцахаар явсан байна.

Хүснэгт 1.3


Докторын зэрэг хамгаалсан багш нар

№	Овог, нэр	Нэгж	Олгосон эрдмийн зэрэг цол	Улс	Сургууль
1	Д.Лхагвасүрэн	ШУС-БУС	Док /Ph.D/	Монгол	МУИС
2	Ц.Базарханд	ШУС-БУС	Док /Ph.D/	Монгол	МУИС
3	А.Батхишиг	ШУС-НУС	Док /Ph.D/	Австрали	Flinder University
4	Б.Мягмарсүрэн	ШУС-НУС	Док /Ph.D/	БНСУ	Korea University
5	Б.Ариун-Эрдэнэ	ШУС-НУС	Док /Ph.D/	Австрали	Үндэсний их сургууль
6	Б.Хишигдэлгэр	ШУС-ХУС	Док /Ph.D/	Монгол	МУИС
7	П.Энхжаргал	ШУС-ХУС	Док /Ph.D/	Монгол	МУИС
8	Н.Гэрэлмаа	ШУС-ХУС	Док /Ph.D/	Монгол	МУИС
9	Д.Отгонтуяа	ШУС-ХУС	Док /Ph.D/	Монгол	МУИС
10	Б.Мөнхцэцэг	ШУС-ХУС	Док /Ph.D/	Монгол	ХУИС
11	Д.Золжаргал	ШУС-ХУС	Док /Ph.D/	БНСУ	Korea University
12	Д.Оюунцэцэг	ШУС-ХУС	Док /Ph.D/	Монгол	МУИС
13	А.Бямбажаргал	ХЗС	Док /S.J.D/	БНСУ	Kookmin University
14	С.Болормаа	ХЗС	Док /Ph.D/	Монгол	МУИС
15	С.Одмаа	ХШУИС	Док /Ph.D /	Япон	University of Tokyo
16	Х.Тэгшжаргал	ХШУИС	Док /Ph.D/	Япон	Yokohama National University
17	А.Баярбаатар	ХШУИС	Док /Ph.D/	БНСУ	Gwangju Institute of Science and Technology

Эрдмийн зэрэгтэй багш нарын нийт багшид эзлэх хувийг бүрэлдэхүүн сургуулиар авч үзвэл ХШУИС, ОУХНУС-ийн нийт багш нарын 60,0-аас дээш хувь нь эрдмийн зэрэгтэй байгш нар байна.

График 1.3

Эрдмийн зэрэгтэй багшийн эзлэх хувь /бүрэлдэхүүн сургуулиар/



Өмнөх хичээлийн жилийн үзүүлэлттэй харьцуулж авч үзвэл эрдмийн зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин Хэрэглээний шинжлэх ухааны сургууль 11,1; Хууль зүйн сургууль 9,3; Бизнесийн сургууль 5,3 пунктээр тус тус өссөн бол Шинжлэх ухааны сургууль 1,9; Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль 1,4 пунктээр тус тус буурсан байна.

2015-2016 оны хичээлийн жилд МУИС-ийн Эрдмийн зөвлөлөөс 10 багшид профессор цол, 21 багшид дэд профессор цол олгож, профессор цолтой нийт 50 багш, дэд профессор цолтой нийт 106 багш ажилласан байна.

Хүснэгт 1.4

Профессор, дэд профессор цол хүртсэн багш нар

Хүснэгт оруулах

Хүснэгт 1.5

Эрдмийн цолтой багш нарын тоо

№	Албан тушаал	ШУС	ХШУИС	БС	ОУХНУС	ХЗС	Нийт дүн
---	--------------	-----	-------	----	--------	-----	----------

Үндсэн багш

1	Профессор	17	1	5			23
2	Дэд профессор	53	9	8		6	76
	Бүгд	70	10	13		6	99

Зөвлөх багш нар


1	Профессор	12	4	5		1	22
2	Дэд профессор	14	4	2	1	2	23
	Бүгд	26	8	7	1	3	45

Гэрээт багш нар

1	Академич		1				1
2	Профессор		2		1	2	5
3	Дэд профессор	3	1			3	7
	Бүгд	3	4		1	5	13

БҮГД							
1	Академич		1				1
2	Профессор	29	7	10	1	3	50
3	Дэд профессор	70	14	10	1	11	106
	Бүгд	99	22	20	2	14	157

График 1.4



Шинэ багш, ажилтны сонгон шалгаруулалт

2015-2016 оны хичээлийн жилд үндсэн болон түр хугацаагаар ажиллах ажлын байрны сонгон шалгаруулалтыг Хөдөлмөрийн дотоод журам болон МУИС-д профессор багш ажиллуулах журмын заалтын дагуу нээлттэйгээр МУИС-ийн цахим хуудас болон өдөр тутмын хэвлэлээр дамжуулан зарлалаа.

Ажилтны сонгон шалгаруулалт зарласан 23 ажлын байрны 19 орон тоонд 19 хүнийг авч ажиллууллаа.

Багшийн сонгон шалгаруулалт

МУИС-д Профессор багш ажиллуулах журмын 5.3-т заасны дагуу ЗХШҮА-наас 2015-2016 оны хичээлийн жилд 2 удаа шинэ багшийн сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулж явуулсан.

Бүрэлдэхүүн 5 сургуулиас 56 мэргэжлийн чиглэлээр 66 багшийн орон тооны санал ирсэн бөгөөд энэхүү саналд багшийн заах хичээл, багшийн албан тушаалд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагуудыг холбогдох тэнхимүүдээс зааж ирүүлсэн. Шинэ багшийн сонгон шалгаруулалтад оролцогчдыг бүртгэх ажлыг эхний удаа урьд жилүүдийн адил burtgel.num.edu.mn хаягаар цахим хэлбэрээр бүртгэсэн бол хаврын улиралд бүртгэлийн ажил ЗХШҮА дээр явагдсан бөгөөд бүртгүүлэгчдээс шаардлагатай бичиг баримтуудыг эх хувиар авч шалгаж баталгаажуулсан.

Нийт бүртгүүлсэн хүмүүсээс докторын зэрэгтэй 28 хүн байснаас гадаадад докторын зэрэг хамгаалсан 10, мөн гадаадад магистрын зэрэг хамгаалсан 21 хүн байсан нь нэг талаас багшид тавигдах шаардлагыг өндөрсгөсөн, нөгөө талаас МУИС-д багшаар ажиллах сонирхол их байгааг харуулж байна.

2015-2016 оны хичээлийн жилд 32 багш шинээр ажилд авсанаас эрдмийн зэрэгтэй багш 5 байна. Үүнээс гадаадад докторын зэрэг хамгаалсан 3 багш байна.

Хүснэгт 1.5

2015-2016 оны хичээлийн жилд шинээр авсан багш нар

№	Овог нэр	Сургууль	Тэнхим	Эрд-мийн зэрэг	Албан тушаалын зэрэглэл
1	Нэргүйн Энхтуяа	ШУС.БУС	Газар зүйн тэнхим		Дадлагажигч багш
2	Бат-Орших Эрдэнэцогт	ШУС.БУС	Геологи геофизикийн тэнхим	Доктор (Ph.D)	Дэд профессор
3	Ганболд Эрдэнэ-Очир	ШУС.БУС	Физикийн тэнхим	Доктор (Ph.D)	Ахлах багш
4	Б.Жавзандолгор	ШУС.БУС	Геологи, геофизикийн тэнхим		Дадлагажигч багш
5	Д.Ганпүрэв	ШУС.БУС	Газар зүйн тэнхим		Дадлагажигч багш
6	Т.Сувдмаа	ШУС.БУС	Биологийн тэнхим		Багш
7	Адилбиш Батхишиг	ШУС. НУС	Социологи, нийгмийн ажлын тэнхим		Багш
8	Энхтөр Оюундэлгэр	ШУС.НУС	Боловсрол, сэтгэл судлалын тэнхим		Дадлагажигч багш
9	Д.Хашбаатар	ШУС.НУС	Эдийн засгийн тэнхим		Багш
10	Дашдондог Идэржаргал	ШУС.НУС	Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхим		Дадлагажигч багш
11	Шажинбат Ариунаа	ШУС.ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим	Доктор (Ph.D)	Дэд профессор
12	Пүрэвдорж Даваапил	ШУС.ХУС	Утга зохиол, урлаг судлалын тэнхим		Дадлагажигч багш
13	Б.Арьяажав	ШУС.ХУС	Ази судлалын тэнхим		Дадлагажигч багш
14	Б.Энхсүвд	ШУС.ХУС	Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим		Дадлагажигч багш
15	Ганжуур Сарантуяа	ХШУИС	Хэрэглээний математикийн тэнхим	Доктор (Ph.D)	Ахлах багш
16	Бямбажав Дэмчигсүрэн	ХШУИС	Хэрэглээний математикийн тэнхим		Багш
17	Бямбадорж Золбоо	ХШУИС	Электроник холбооны инженерчлэлийн тэнхим		Багш
18	Хишигжаргал Тэгшжаргал	ХШУИС	Хүрээлэн буй орчин судлал химийн инженерчлэлийн тэнхим	Доктор (Ph.D)	Багш
19	Гантөмөр Дамдинсүрэн	ХШУИС	Хүрээлэн буй орчин судлал химийн инженерчлэлийн тэнхим		Багш
20	Баахүү Баяр	ХЗС	Нийтийн эрх зүйн тэнхим		Багш
21	Тогоо Золбоо	ХЗС	Нийтийн эрх зүйн тэнхим		Дадлагажигч багш
22	Энхжаргал Мөнхдаваа	ХЗС	Нийтийн эрх зүйн тэнхим		Дадлагажигч багш
23	Н.Норовсамбуу	ХЗС	Хувийн эрхзүйн тэнхим		Дадлагажигч багш
24	С.Батбаяр	ХЗС	Хувийн эрхзүйн тэнхим		Дадлагажигч багш
25	.Мөнх-Эрдэнэ,	ХЗС	Нийтийн эрхзүйн тэнхим		Дадлагажигч багш

26	С.Баяр,	ХЗС	Нийтийн эрхзүйн тэнхим		Дадлагажигч багш
27	Б.Батбаяр	ХЗС	Нийтийн эрхзүйн тэнхим		Дадлагажигч багш
28	Намсрайдорж Баттүшиг	БС	-		Ахлах багш
29	Давааням Бүдсүрэн	ОУХНУС	Олон улсын харилцааны тэнхим		Ахлах багш
30	Батжаргал Баярцэнгэл	ОУХНУС	Олон улсын харилцааны тэнхим		Дадлагажигч багш
31	Ганбат Мягмар	ОУХНУС	Нийтийн удирдлагын тэнхим		Дадлагажигч багш
32	С.Ариунбилэг	ОУХНУС	Нийтийн удирдлагын тэнхим		Дадлагажигч багш

Шагнал, тэтгэмж, урамшуулал

2015-2016 оны хичээлийн жилд МУИС-ийн дээд шагнал болох “Эрдмийн элч” шагналаар МУИС-ийн Хууль зүйн сургуулийг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан Академич Ж.Амарсанаа, Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбарын Физикийн тэнхимийн профессор С.Даваа нарыг шагналаа.

Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбарын Биологийн тэнхимийн профессор Б.Баяртогтох нийт 5 өгүүллийг Томсон Ройтерсийн Q2 категорийн эрдэм шинжилгээний сэтгүүлд нэгдүгээр болон холбоо барих зохиогчоор олон улсын түвшинд хэвлүүлсэн учир Шинжлэх ухааны нээлт, эрдэм шинжилгээний шилдэг бүтээлд олгодог захирлын нэрэмжит шагналыг хүртлээ.

МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн дээд шагнад “МУИС-ийн эмерит профессор” цолыг бий болгож, тайлант онд МУИС-ийн ахмад багш, Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч, академич Т.Дорж, ахмад багш, Монгол Улсын Гавьчат багш, Шинжлэх ухааны доктор Э.Равдан нарт олголоо.

ХШУИС-ийн профессор П.Энхбаяр Томсон Ройтерс болон Казахстан улсын Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн үндэсний төвийн “Төв Азийн мужаас шалгарсан дэлхийн судлаач” номинацийн шалгаруулалтаар 2015 оны “Шинжлэх ухааны лидер” цом, тэргүүн зэргийн дипломоор шагнагдлаа.

Дэлхийн багш нарын өдөр, Монголын багш нарын баярын өдрийг тохиолдуулан МУИС-ийн шилдэг багшийг байгалийн болон нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбар тус бүрээр Шилдэг судлаач багш, Шилдэг сурган хүмүүжүүлэгч багш, Шилдэг залуу багш гэсэн номинациар шалгаруулсан. Шалгаруулалтад 12 багш материалаа ирүүлсэнээс доорх багш нар оны шилдэг багшаар шалгарсан.

Хүснэгт 1.5

Оны шилдэг багш нар

Нэр, албан тушаал	Нэр, албан тушаал
Байгалийн ухааны салбар	Нийгэм, Хүмүүнлэгийн ухааны салбар
Шилдэг сурган хүмүүжүүлэгч багш	
Д.Сарангэрэл /ШУС.БУС. Химийн тэнхимийн дэд профессор/	Н.Нансалмаа /ШУС.ХУС. Европ судлалын тэнхим/
Шилдэг судлаач багш	
Н.Жавхлантөгс /ХШУИС. ХБОСХИТ-ийн дэд профессор/ Л.Энхтөр /ШУС. БУС. Физикийн тэнхимийн профессор/	О.Мөнхсайхан /ХЗС-ийн Нийтийн эрхзүйн тэнхимийн дэд профессор/

Шилдэг залуу багш	
П.Мөнхбаатар /ШУС.БУС. Физикийн тэнхмийн ахлах багш/	М.Эрдэнэ /БС-ийн багш/ Б.Тамир /ХЗС-ийн багш/

Тайлант хичээлийн жилд МУИС-ийн ... багш, ажилтан төрийн одон медаль, ... багш ажилтан Засгийн газрын шагнал, ... багш ажилтан МУИС-ийн шагналаар шагнагдлаа.
/Хавсралт /

Мөн Хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд заасны дагуу багш, ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмж олгожээ.

БҮЛЭГ 2. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИ, ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАЛТ

МУИС-ийг 2016-2024 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний нэгдүгээр тэргүүлэх чиглэл буюу “Судалгааны хамрах хүрээ, түвшнийг дэлхийн жишигт нийцүүлэх” зорилтын хүрээнд доорх ажлыг гүйцэтгэв. Үүнд тайлант хичээлийн жилд эрдэм шинжилгээ, судалгааны ажлын гол үр дүнг дурьдвал:

2.1. Судалгаа тогтмол хийдэг, тэргүүлэх судлаач эрдэмтдийн тоог нэмэгдүүлэх судалгааны менежмент

МУИС-ийн 2016-2024 оны стратегийн төлөвлөгөөндөө судалгааны хамрах хүрээг өргөжүүлэх, судалгааны түвшинг дэлхийн жишигт нийцүүлэхээр тэргүүлэх чиглэлээ тодорхойлж, судалгааны их сургууль болон хөгжих зорилтын хүрээнд сургуулийн бүх салбар нэгж, профессорын багууд судалгааны ажлын тэргүүлэх чиглэл, сэдэвтэй байж, сургалт-судалгааны ажлын уялдаа холбоог сайжруулан эрдэм шинжилгээний ажлыг дэмжих дотоод, гадаад хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлж байна.


Эрдэм шинжилгээ, инновацийн асуудал эрхэлсэн дэд захирлын дэргэд Эрдэм шинжилгээ, инновацийн бодлогын зөвлөл, Оюуны өмчийн хороог МУИС-ийн Захирлын тушаалаар байгуулсан. ЭШИ-ийн бодлогын зөвлөл МУИС-ийн эрдэм шинжилгээ, инновацийн хөгжлийн ерөнхий стратегийг тодорхойлох, үйл ажиллагааны чиглэлээр мөрдөх нийтлэг зохицуулалтын талаар санал, зөвлөмж боловсруулах, мэргэжлийн дүгнэлт гаргах, өндөр технологийн болон өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох, инновацийн чадавхи, нөөцийг оновчтой байршуулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор инновацийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлон ажиллах үүрэгтэй. ОӨ-ийн хороо оюуны өмчийн хөрөнгийн үнэлгээ, бүртгэл, эзэмших чиглэлд зөвлөмж боловсруулж оюуны өмчийн үр ашгийг нэмэгдүүлэх үүрэгтэй.

2011-2016 оны Скопусын хайлтаар манай судалгааны чиглэлүүдээс хөдөө аж ахуй, биологи, физик, астрономи, компьютерийн шинжлэх ухаан, математик, хүрээлэн буй орчны чиглэл тогтвортой хөгжиж ирсэн ба нийгмийн ухаан, анагаах ухаан, биохимийн чиглэлүүд тодорхой түвшинд илэрч ирж байна. Харин материалын шинжлэх ухаан, хими, хүмүүнлэгийн ухаан, фармакологи, токсикологи, эм судлал, эдийн засаг, эконометрикс, санхүү, эрчим хүч, химийн инженерчлэл, иммунологи, микробиологи, шийдвэр гаргах зэрэг чиглэлүүд сул илэрцтэй байна (Зураг 2.1). Томсон Ройтерсийн ангиллаар авч үзвэл МУИС –ийн шинжлэх ухаан, технологи, физик, амь шинжлэх ухаан, биоанагаах ухааны чиглэл илүү хөгжиж байна (Хүснэгт 2.1).

Өнөөдөр монгол судлал эрчимтэй хөгжиж зөвхөн тайлангийн хугацаанд Монгол судлалын хүрээлэн 206 сая төгрөгийн санхүүжилттэй судалгааг гүйцэтгэн дэлхийн 11 орны монголч эрдэмтдийн 11 дүгээр чуулганыг 8 сарын 15-18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сансрын инженерчлэл, электроник инженерчлэл, сэргээгдэх эрчим хүчний инженерчлэл, генетик инженерчлэл, химийн инженерчлэл, биоинженерчлэл, stem cell, big data зэрэг тодорхой тэргүүлэх судалгааны чиглэлийг хөгжүүлэх гадаад, дотоод хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлсэн.

ШУТ-ийн Фраскатын удирдамжийг БСШУЯ-ны захиалгаар орчуулан хянаж ЮНЕСКО ба ЭЗХАХБ-ын ШУТ-ийн салбарын ангиллыг үндэсний хэмжээнд нутагшуулж байна. МУИС-ийн эрдэм шинжилгээ, технологийн тэргүүлэх чиглэлүүдийг дахин нарийвчлан судалж тогтоох замаар суурь болон хэрэглээний судалгааны зохистой харьцааг сургуулийн хэмжээнд тодорхойлж хэрэгжүүлэх ажлыг БСШУЯ-ны Дээд боловсролын шинэчлэлийн “Монгол Улсын их, дээд сургуулийн эрдэм шинжилгээ,

инновацийн үндсэн бодлогын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шинэчлэлийн аргам” сэдэвт төслийн хүрээнд гүйцэтгэж байна.



Зураг 2.1. МУИС-ийн 2011-2016 оны судалгааны чиглэл(Скопус).

Хүснэгт 2.1.

МУИС-ийн сүүлийн 5 жилийн судалгааны салбарын WoS категори.

Д/Д	Шинжлэх ухааны салбарын Томсон Ройтерсийн ангилал	Эзлэх хувь, %
1.	Шинжлэх ухаан, технологи	36
2.	Физикийн шинжлэх ухаан	25
3.	Амь шинжлэх ухаан, биоанагаах ухаан	22
4.	Технологи	10.2
5.	Нийгмийн шинжлэх ухаан	6.1
6.	Хүмүүнлэгийн ухаан	0.6

Судалгааны ёс зүйн хороо (био ёсзүй, сэтгэл судлалын ёс зүй, анагаахын ёс зүй), судалгааны гүйцэтгэлийн зөрчлийг хянан магадлах явцад анхаарч луйврын сэтгүүлээс зайлсхийх мэдээлэл, ёс зүйг <http://publicationethics.org>, <http://scholarlyoa.com/> зэрэг мэдээллийн санг СиСисистемд байршуулан нэвтрүүлж судлаачдыг бүтээлийн хулгайгаас сэрэмжлүүлэхчиглэлд Харвардын ИС-ийн шинжээчидтэй хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

Судалгаа, хөгжлийн ажлын зохион байгуулалтыг дэмжих доорх багц журмыг 2015-2016 онуудад шинээр боловсруулж

- “МУИС-ийн судалгааны ажлын санхүүжилтийн журам” (2016.03.02 МУИС-ийн Захирлын А/52 тушаалын хавсралт)
- “Судалгааны санхүүжилтээс Монгол Улсын Их Сургуульд шууд бус зардлын хуримтлал бүрдүүлэхэд баримтлах журам” (2016.06.13 МУИС-ийн Захирлын А/162 тушаалын хавсралт) батлуулж
- “МУИС-ийн судалгааны лабораторийн үйл ажиллагааг зохицуулах журам”
- “МУИС-ийн судалгааны төв, хүрээлэнгийн үйл ажиллагааг зохицуулах журам”
- “Судалгааны гүйцэтгэлийн зөрчлийг хянан магадлах МУИС-ийн журам”
- “МУИС-д эрдэм шинжилгээний ажилтан ажиллуулах журам”-ын шинэчилсэн найруулга
- “МУИС-ийн магистрант, докторантыг туслахаар ажиллуулах журам”-ыг хэлэлцүүлж МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн Эрдэм шинжилгээний хороонд хэлэлцүүлэхээр хүлээлгэн өгсөн.

МУИС-ийн эрдэм шинжилгээ, инновацийн тогтолцооны үүлэн удирдлагын системийг хөгжүүлэх зорилгоор СиСи системийн эрдэм шинжилгээний өргөтгөлийн төслийг хэрэгжүүлж, демо туршилтыг гүйцэтгэсэн. Үүнд:

- МУИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хулгайг илрүүлэх, бүтээлийн хулгайгаас урьдчилан сэргийлэх бүтээлийн хулгайг илрүүлэх (PDS) системийг хөгжүүлэх
- Багшийн ажлын нэгдсэн үнэлгээний системийг хөгжүүлэх
- МУИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны төслийн бүртгэлийн системийг боловсруулах
- МУИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны төслийн менежментийн системийг боловсруулах
- МУИС-ийн Эрдэм шинжилгээний менежментийн мэдээллийн системийг хөгжүүлэх ажил.

“Б” цагийн хяналтыг боловсронгуй болгох, багш судлаачийн судалгаандаа зарцуулж буй БЦАХТШУ(Бүтэн цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утга)-ыг хянах ажлыг research@num.edu.mn Эрдэм шинжилгээний менежментийн мэдээллийн системээр гүйцэтгэх демо туршилтыг ХШУИС-ийн жишээ дээр гүйцэтгэсэн.

2016 оны 3 дугаар сарын 2-ны өдөр “МУИС-ийн судалгааны ажлын санхүүжилтийн журам” –ыг захирлын А/52 дугаар тушаалын хавсралтаар баталж мөрдөж эхэлсэн нь МУИС-ийн 2016-2024 оны стратегийн төлөвлөгөөнд судалгааны хамрах хүрээг өргөжүүлэх, судалгааны түвшинг дэлхийн жишигт нийцүүлэхээр тэргүүлэх чиглэлээ тодорхойлж, судалгааны их сургууль болон хөгжих зорилт тавин ажиллаж буйтай холбогдуулан судлаач багш нарын судалгааны үйл ажиллагааг дэмжих, эрдэм шинжилгээний бүтээлийн түвшин, эрдэм шинжилгээний гадаад, дотоод хамтын ажиллагааг нэмэгдүүлэх харилцааг зохицуулах чухал бодитой ажил болов. Тус журмаар доорх 5 шалгаруулалтыг дэмжиж байна:

1. Профессор, дэд профессор, доктор багш нарт судалгааны зардал олгох(сүүлийн 5 жил бүтээлгүй багш нар хамрагдах боломжгүй тенюршипийн хөшүүрэг оруулсан)
2. Залуу судлаачдын багт грант олгох (Монгол хэл шинжлэлтэй холбоотой залуу судлаачдыг бодлогоор дэмжсэн, судалгааны туслахыг дэмжих механизм)
3. Зочин судлаачдад судалгааны тэтгэлэг олгох (гадаадад судалгаа хийж буй судлаачдыг докторын дараах судалгаанд урьж ажиллуулах, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, улмаар өгүүллийг тоог эрс нэмэх механизм)
4. Өндөр түвшний судалгааны төслийн санхүүжилт олгох (JCR импакт фактор бүхий олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх, оюуны өмчийн хамгаалалт хийх, түүнийгээ үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилго бүхий үндсэн орон тооны профессор багш, судлаачдын дэвшүүлсэн өндөр түвшний төслийг сонгон санхүүжүүлэх)
5. Олон улсын судлаачдын хамтарсан төслийн санал боловруулах үйл ажиллагааг дэмжих (Seed grant). Хамгийн багадаа 50-150 америк долларын санхүүжилтийг босгох санаачлалыг дэмжих, улмаар төслийн санхүүжилтийг эрс өндөржүүлэх механизмыг нэвтрүүлж байна.

МУИС-ийн дотоодын санхүүжилтээр өндөр түвшний судалгаа, залуу судлаачийн грант, зочин судлаач, олон улсын судлаачдын хамтарсан төслийн санал боловсруулах үйл ажиллагааг 2015 (нийт 77 төсөлд 435 сая төгрөг), 2016 (нийт 50 төсөлд 621 сая төгрөг) онд хэрэгжүүлсэн (Хүснэгт).

МУИС-ийн дотоод төсөл.


Бүрэлдэхүүн сургууль	2015		2016			
	Өндөр түвшний судалгаа, залуу судлаачдын грант, сэтгүүлийн грант	Профессорын суурь зардал	Өндөр түвшний судалгаа, залуу судлаачдын грант	Зочин судлаач	Олон улсын төсөл	Профессорын суурь зардал
ШУС	237635.0	236,000.0				
• БУС	133 260,0	76500	153,000.00	40,000.00		79,000.00
• НУС	53, 475.0	32500	36,000.00			49,000.00
• ХУС	49, 900.0	64000	72,000.00			75,000.00
ХШУИС	168760.0	50,000.0	102,000.00	35,000.00	5,000.0	58,000.00
БС	24600.0	44,000.0	8,000.0			47,000.00
ОУХНУС	1500.0	11,000.0				9,000.00
МХ	2500.0					
ХЗС		24,000.0	8,000.00			24,000.00

2016 оны профессорын суурь зардал, өндөр түвшний судалгаа, залуу судлаачдын багийн санхүүжилтийг бодлогоор нийгэм хүмүүнлэгийн чиглэлд түлхүү чиглүүлсэн.


Бүрэлдэхүүн сургуулийн профессорын суурь зардлын тоо, санхүүжилт.

Д/Д	Бүрэлдэхүүн сургууль	Нийт санхүүжилтийн тоо	Нийт санхүүжилт, мян.төг
1	ШУС-ийн БУС	63	79,000.00
	ШУС-ийн НУС	36	49,000.00
	ШУС-ийн ХУС	58	75,000.00
2	ХШУИС	43	58,000.00
3	БС	35	47,000.00
4	ОУХНУС	7	9,000.00
5	ХЗС	18	24,000.00
6	Нийт	260	341,000.00


Бүрэлдэхүүн сургуулийн ахлах багш, дээд профессор, профессорын суурь зардлыг тоо, санхүүжилтийг харьцуулахад,



Зураг 2.2. 2016 профессорын суурь зардал авсан багш нарын тоо, ШУ-ны салбараар.



Зураг 2.3. 2016 профессорын суурь зардлын ШУ-ны салбарын харьцуулалт. Өндөр түвшний судалгаа, залуу судлаачдын багийн санхүүжилтэд 2016 онд 281 сая төгрөгийг зарцуулж байна. Санхүүжүүлж буй төслийг ШУ-ны чиглэлээр нь харьцуулахад энэ жил нийгэм, хүмүүнлэгийн чиглэлийн дэмжлэг харьцангуй сайн байна.



Зураг 2.4. 2016 өндөр түвшний судалгаа, залуу судлаачдын багийн грантын тоо.



Зураг 2.5. өндөр түвшний судалгаа, залуу судлаачдын багийн грантын санхүүжилт.

2.2. Судалгааны баг

Сургуулийн салбар, нэгж бүрт шинжлэх ухааны тодорхой асуудал, сэдвээр судалгааны багууд ажиллан судлаач багш нарыг үе шаттайгаар бэлтгэж байна. Тэргүүлэх чиглэлээр судалгааны зардалтай профессорын баг, хүрээлэн, төв, салбар дундын хамтлагийг бүрэлдүүлэх, оролцогчдын судалгаанд зарцуулж буй цаг, зардлыг ихэсгэх, холбогдох статистик мэдээг олон улсын стандартын дагуу шинэчлэх, судалгааны эко тогтолцоог үе шаттайгаар бүрэлдүүлж байна.

МУИС-ын хэмжээнд дотоод, гадаадын шинжээч оролцуусан үнэлгээний комисс томилон ажиллуулж, багаж төхөөрөмжийн өгөгдлийн сан дээр тулгуурлан дүн шинжилгээ хийх, цаашид хөгжүүлэх чиглэл, засвар үйлчилгээний бүтэц зэрэг судалгааны байгууламжийн ТЭЗҮ-г боловсруулах, гадны туршлагаас судлав.

Оношлогоо, демо туршилтын үр дүнд цаашид хөгжүүлэх шаардлагатай сургуулийн салбар, нэгж, шинжлэх ухааны тодорхой асуудал, сэдвээр судалгааны багууд ажиллах, судлаач багш нарыг үе шаттайгаар бэлтгэдэг эко нөхцлийг бүрдүүлэх судалгааг АХБ-ны санхүүжилттэй БСШУЯ-ны ДБШТ-ийн байгууллагын төслийн хүрээнд 2016-2017 онд гүйцэтгэж байна. Microsoft компанитай судалгааны цахим лабораториудыг хөгжүүлэх эко орчинг бүрдүүлэх ажлыг эхлүүлсэн.

Магистрант, докторантыг туслахаар ажиллуулах журам, механизм бүрэлдэж буй нь “А” цагаас “Б” цаг руу уян хатан хэлбэрээр шилжих, профессорын багуудын судалгаандаа зарцуулах цагийг нэмэгдүүлэх давуу талтай болов.

ИТДБ төслийн хүрээнд өндөр технологийн 10 чиглэлд 154 (монгол-103, япон-51) хүнийг хамарсан судалгааны хүний нөөц бэлтгэгдэж байна. Тайлангийн хугацаанд Япон улс руу нийт зэргийн сургалтанд - 9 оюутан, зэргийн бус сургалтанд -16 багш явуулж, шинжээчээр япон багш –30 ирж, нийт 12 их сургуультай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан байна(Хүснэгт 2.10).

2.3. Судалгааны дэд бүтэц

Сургууль сургалт, судалгааны ажлын шинэ үр дүнг үндэсний, олон улсын түвшинд сурталчилж, баталгаажуулдаг тогтолцоог байгуулах зорилтын хүрээнд судалгааны ажлын шинэ үр дүнг гаргах хард, софт, хүний нөөц бүхий дэд бүтэцэд суурилан судалгааны өндөр үр дүн гарах механизмтай байх ба гарсан үр дүнг а) үндэсний; б) олон улсын түвшинд баталгаажуулдаг тогтолцоог сайжруулж байна.

МУИС-ийн нийт 92 сургалт, судалгааны лабораторид SWOT орчлын үнэлгээг 2015-2016 онд гүйцэтгэж биологийн салбарын - 11, газарзүй, геологийн салбарын- 3, компьютер, мэдээллийн технологийн салбарын-3, физикийн салбарын-2, химийн салбарын -4, химийн инженерчлэл, материал судлалын салбарын -2, хүрээлэн буй орчин судлал-инженерчлэлийн салбарын -3, электроникийн инженерчлэлийн салбарын -1 судалгааны тэргүүлэх чиглэлийн нийт 29 лабораторийг хангалттай үнэлгээгээр сонгон холбогдох мэдээллийн санг МУИС-ийн Эрдэм шинжилгээний менежментийн цахим (research@num.edu.mn) системд оруулж танилцуулгын материалыг гаргасан.

2015 онд биохими, шинэ материал, нанотехнологи, малтимедиа, генетик инженерчлэл, экологийн чиглэлээр нийт 10 судалгааны лабораторийг АХБ-ны санхүүжилттэй БСШУЯ-ны ДБШТ-ийн хүрээнд нийт 1 тэрбум 46.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 2016 онд лабораториудыг бүрэлдэхүүн сургууль дээр суурилуулан ажиллуулж эхэлсэн.

2016-2017 оны Японы засгийн газар-БСШУЯ-ны ДБШТ-ийн 1000 ИТБДТ –өөс нийт 2,16 сая долларын инженерчлэл, хэрэглээний тэргүүлэх чиглэлийн 10 лаборатори болон дундын лабораторийн худалдан авалтыг төлөвлөсөн. Шинээр нийт 5 лабораторийг байгуулсан (Хүснэгт 2.1).

Сэтгүүлийн аттестатчиллыг гүйцэтгэж “Б” цагт тооцох сэтгүүлийн жагсаалтыг шинжлэх ухааны салбарын эрдмийн зөвлөлүүд шинэчлэн сэтгүүлийн менежментийг “МУИС Пресс” хариуцаж байна (Хүснэгт 2.3). БСШУЯ-ны АХБ-ны санхүүжилттэй ДБШТ-ийн хүрээнд байгалийн ухааны чиглэлд -1, нийгэм хүмүүнлэгийн чиглэлд -1 сэтгүүлийг Томсон Ротерсийн Journal Citation Report тайланд оруулах ажлыг эхлүүлсэн. МУИС-ийн Mongolian Journal of Biological Sciences сэтгүүл веб хуудсаа шинэчлэн

боловсруулж, өгүүллийг онлайнаар хүлээж авдаг, ревью хийдэг системд шилжүүлж Томсон Ройтерсийн мэдээллийн санд бүртгүүлж үнэлүүлэн, импакт факторын индекс авах нөхцөлийг бүрдүүлж Скопусын мэдээллийн санд бүртгүүлж үнэлүүлэн, импакт факторын индекс авах нөхцөлийг бүрдүүлж байна. Mongolian Journal of Anthropology and Archeology сэтгүүлийг онлайн системд шилжүүлэн өгүүлэл хүлээж авах, ревью хийх системийг өөрчлөх замаар уг сэтгүүлийн чанарыг сайжруулав.

2.4. Олон нийтэд судалгааны үр дүнг сурталчилах, урамшуулах механизм

2015-2016 онд МУИС-ийн судлаачдын судалгааны ажлын үр дүнг олон нийтэд түгээх, соён гэгээрүүлэх, танин мэдэхүйн үйл ажиллагааны хүрээнд МҮОНТВ-тэй хамтран тус телевизийн 1 дүгээр сувгаар “Эрдмийн хэт” цуврал нэвтрүүлгээр “Гравитацийн долгион”, “Уураг”, “Ойн модны цагираг” гэсэн 3 сэдвийг бэлтгэн гаргасан. 2015 оноос эхлэн Томсон Ройтерсийн бүртгэлтэй МУИС-ийн шилдэг өгүүллийн зохиогч, шилдэг оюуны өмчийн бүтээгч, шилдэг энтрепренёр шалгаруулж цом бүхий мөнгөн шагнал олгож урамшуулах тогтолцоог бүрдүүлж байна. “МУИС-ийн Шилдэг оюуны өмч бүтээгч”, “МУИС-ийн шилдэг энтрепренёр” шалгаруулж багш, судлаачдын оюуны өмч бүтээх, түүнийг бизнесийн эргэлтэд оруулах идэвхи санаачлагыг урамшуулж байна. Тайлангийн хугацаанд “МУИС-ийн Шилдэг оюуны өмч бүтээгч” номинацид Ж.Батхүү, Б. Энхсаруул, Ц.Эрдэнэбат, “МУИС-ийн шилдэг энтрепренёр” номинацид Д.Дэмбэрэлнямба нар тус тус шалгарсан.

Томсон Ройтерс, Томсон Инновейшн компанитай хамтын ажиллагааг хөгжүүлж байгууллагын оношлогоог хөндлөнгийн шинжээчээр хийлгэж тайланг авч байна. МУИС-ийг олон улсын түвшинд авч үзвэл гадны топ шинжээчид ямар дүгнэлт өгч байгаа, ямар нэр хүндтэй байгаа талаар байнга анхаарч, ямар арга хэмжээ авах талаар бодлогод тусгаж байна.

BIRDS төсөл Монгол, Гана, Нигери, Япон, Бангладеш, Тайланд зэрэг орны нийт 15 оюутан, Кюшүгийн технологийн институтын 4 багш, ажилтан, 1U хэмжээтэй 5 хиймэл дагуул, хиймэл дагуул хөөргөөгүй улсууд болон их сургуулиудын хувьд анхны хиймэл дагуул нь байхаар, Олон улсын сансрын станцаас 2017 онд хөөргөхөөр Кюшүгийн Технологийн Институт дээр эхлүүлэн ажиллаж байна.

МУИС-ийн Компьютер график, мультимедиа судалгааны нээлттэй лаборатори Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей болон Монголын соёлын өвийн төвтэй хамтран хийж байгаа өндөр гэгээн Занабазарын хосгүй үнэт бүтээлүүдийн 3 хэмжээст дижитал загвар, Түүх археологийн хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж байгаа Сарьдагийн хийдийн үнэт олдворуудын 3 хэмжээст дижитал загвар, манай түүх антропологийн тэнхимтэй хамтран хийж буй Монгол нутгаас олдсон хүрлийн үеийн олдвор болох хүний гавлын яснаас царайг нь сэргээх ажил, МУИС-ийн төв байрны 3 хэмжээст загвар дээр тусгасан проект маппинг, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулан бүтээсэн робот гар, виртуал орчинд бүтээсэн музей болон сансарын аялал бүхий нийт 18 орчим бүтээлүүдийн үзэсгэлэн гаргасан.БНХАУ-ын Манжуур хотод зохион байгуулагдсан Олон Улсын Шинжлэх Ухаан Технологийн үзэсгэлэнд 2016 оны 7-р сарын 3-5-ны өдрүүдэд ХШУИС-ийн Компьютер график-мультимедиа судалгааны нээлттэй лаборатори, биоорганик хими-фармакогнози болон ургамлын биотехнологийн лабораториуд нь өөрсдийн судалгааны ажлын үр дүнгээрээ оролцсон.

МУИС-ийн захирал хичээлийн шинэ жилийн нээлтийг тохиолдуулан жил бүр шинжлэх ухааны нээлт, эрдэм шинжилгээний шилдэг бүтээлд өөрийн нэрэмжит шагнал олгодог уламжлалтай бөгөөд энэ жил тус шагналыг нийт 5 өгүүллээ Томсон Ройтерсийн Q2 категорийн эрдэм шинжилгээний сэтгүүлд нэгдүгээр болон холбоо

барих зохиогчоор олон улсын түвшинд хэвлүүлэн тэргүүлсэн Шинжлэх ухааны сургуулийн Биологийн тэнхмийн профессор Б.Баяртогтоход олгосон.

2.5.Хамтарсан судалгаа, туршилт

Эрдэм шинжилгээ, судалгаа, гэрээт ажил, технологи дамжуулалт, инновацийн орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд үндэсний болоод гадаад хамтын ажиллагааны хүрээнд нийт 5 тэрбум 28 сая 486 мянган төгрөгийн өртөгтэй судалгаа, хөгжлийн тодорхой ажлыг хэрэгжүүлж байна. Үүнээс тайлангийн хугацаанд профессорын суурь зардалд - 341 сая төгрөг болон нийт 3 тэрбум 213 сая 168 мянган төгрөгийн 240 төсөл хэрэгжиж байна. Үүнд 313 сая төгрөгийн инновацийн - 9, 80 сая төгрөгийн ИТДБ-ийн - 10 хөтөлбөр, 1 тэрбум 436 сая 995 мянган төгрөгийн гадаадын байгууллагын санхүүжилттэй – 98, 853 сая 994 мянган төгрөгийн санхүүжилттэй улсын захиалгат болон аж ахуйн гэрээт - 83, 621 сая төгрөгийн дотоодын санхүүжилттэй – 50 төсөл нягтлан бүртгэлийн дансаар орсон байна. МУИС-ийн хүрээлэн төвийн 673 сая төгрөгийн санхүүжилттэй 14 судалгааны ажил байна. Судалгаа, хөгжлийн ажлын төрлийг үзвэл суурь судалгаа- 73 %, хэрэглээний судалгаа-14 %, туршилт хөгжил-13 % байна. Үүнд томоохон төслийг дурьдвал:

2015-2020 онд “Collaborative research: hierarchical patterns in macrosystem function linked to biodiversity in Mongolia and U.S. temperate steppe rivers – contrasts across continents” сэдэвт төслийг Б.Болдгив нар АНУ-ын Үндэсний Шинжлэх ухааны сангийн Биологийн Макросистемын Америкийн 9 их сургууль оролцсон нийтдээ 5 жилийн хугацаатай хөтөлбөрийг нийт 4.2 сая долларын санхүүжилтээр гүйцэтгэж байна. "Taylor Family-Asia Foundation Endowed Chair in Ecology and Conservation Biology" сангийн хандиваар нийт 78.9 сая төгрөгийг бүрдүүлэв.


Монгол-Германы хамтарсан археологийн төслийн хүрээнд У.Эрдэнэбат нар Орхоны хөндийд буй Монголын эртний нийслэл Хархорум болон Уйгурын хаант улсын нийслэл Хар балгасыг археологийн талаар шинжлэн судлаж 2000 оноос хойш 17 дахь жилдээ Германы Археологийн хүрээлэн, Монгол Улсын ШУА-тай хамтран ажиллаж, 2015 онд Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт 13-р зууны үеийн Хархорумын Бурханы шашны сүмийн үлдэцийг хамгаалах, ил үзмэр болгох ажил хийсэн. Хээрийн судалгааны ажилд жил бүр 30-60 оюутан тогтмол оролцож мэргэжлийн дадлага хийж байна.

2015-2016 онд “Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтөд зориулсан нарны зайнд суурилсан гибрид тархалттай эрчим хүчний системийг боловсруулах” сэдэвт сэргээгдэх эрчим хүчний инновацийн төслийг БНСУ-ын VJPOWER компанийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна.


1000 инженерийн ИТДБТ 2015-2016 онд инженерчлэлийн шинжлэх ухааны 10 судалгааны төсөл (нийт 160 сая төгрөг), АХБ-ны санхүүжилттэй хэрэглээний шинжлэх ухааны чиглэлд нийт 13 төслийн (нийт 364 сая төгрөг) хүрээнд хэрэглээ, өндөр технологи, инженерчлэлийн тэргүүлэх чиглэлүүдийг хөгжүүлж байна.

Пусаны ИС, Бээжингийн ИС-тай хамтран занар, байгалийн хийн инженерчлэлийн чиглэлд, АПУ, Монос компани, Мон Сүү, Эрдэнэс Монгол компанитай зорилтот бүтээгдэхүүн гаргах чиглэлд ажиллаж байна.

Төслийн үр дүнгийн баталгаажуулалтын материалд хянан магадлагаа хийх, төслийн шалгаруулалт, явцын тайланд шинжээчийн мэдээллийн сан үүсгэж хөндлөнгийн хянан магадлагааг гүйцэтгэж байна.



Зураг 2.6. МУИС-ийн 2015-2016 оны судалгааны төслийн зардал, мян.төгрөг.




Зураг 2.7. МУИС-ийн 2015-2016 оны судалгааны төслийн тоо.


2.6. Эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн хувьд гарсан ололт амжилтын гол үзүүлэлт

Судалгааны хамрах хүрээ болон түвшнийг Web of Science-д бүртгэлтэй судалгааны бүтээл, эшлэлийн тоог нэмэгдүүлэх замаар сайжруулж байна. Web of


Science –ын сүүлийн 20 болон 5 жилийн МУИС-ийн хаягтай өгүүлэл, эшлэлийн тоо огцом өсөх хандлагатай байна.



a)



б)



2015-2016 он.

2015-2016 он.

в)

Зураг 2.8. а)1997-2016; б) Сүүлийн 5 жил; в) 2015-2016 оны МУИС-ийн Томсон Ройтерсийн Web of Science –д бүртгэлтэй өгүүлэл, эшлэлийн тоо.

Тайлангийн хугацаанд Web of Science –д хэвлүүлсэн өгүүллийн Томсон Ройтерсийн ерөнхий ангиллыг авч үзвэл:

Хүснэгт

2.4.

Томсон Ройтерсийн шинжлэх ухааны ангилал

Д/Д	ШУ-ны Томсон Ройтерсийн ангилал	Эзлэх хувь, %
1.	Шинжлэх ухаан, технологи	37
2.	Физикийн шинжлэх ухаан	25.2
3.	Амь шинжлэх ухаан, биоанагаах	20.6
4.	Технологи	9.5
5.	Нийгмийн ухаан	6.9
6.	Хүмүүнлэгийн ухаан	0.8

Тайлангийн хугацаанд багш нарын хэвлүүлсэн нийт 62 JCR индекстэй өгүүлэл хэвлэн нийтлэгдсэн сэтгүүлийн JCR® категорийн Quartile* ангиллыг авч үзвэл:

Хүснэгт 2.5.

МУИС-ийн багш нарын өгүүллээ хэвлүүлсэн JCR индекстэй сэтгүүлийн ангилал

Д/Д	Сэтгүүлийн нэр	Сэтгүүлийн JCR® категори	Сэтгүүлийн Quartile Score ангилал
1	ATMOSPHERIC ENVIRONMENT	ENVIRONMENTAL SCIENCES	Q1
		METEOROLOGY & ATMOSPHERIC SCIENCES	Q1
2	X-RAY SPECTROMETRY	SPECTROSCOPY	Q3
3	PHYSICAL REVIEW C	PHYSICS, NUCLEAR	Q2
4	ENERGY ECONOMICS	ECONOMICS	Q1
5	ENVIRONMENTAL EARTH SCIENCES	ENVIRONMENTAL SCIENCES	Q2
		GEOSCIENCES, MULTIDISCIPLINARY	Q2
		WATER RESOURCES	Q2
6	EUROPEAN JOURNAL OF SOIL BIOLOGY	ECOLOGY	Q2
		SOIL SCIENCE	Q2
7	CLIMATIC CHANGE	ENVIRONMENTAL SCIENCES	Q1
		METEOROLOGY & ATMOSPHERIC SCIENCES	Q1
8	JOURNAL OF GLOBAL OPTIMIZATION	MATHEMATICS, APPLIED	Q1
		OPERATIONS RESEARCH & MANAGEMENT SCIENCE	Q3
9	GEODERMA	SOIL SCIENCE	Q1
10	LIFE SCIENCES	MEDICINE, RESEARCH & EXPERIMENTAL	Q2
		PHARMACOLOGY & PHARMACY	Q2
11	ZOOTAXA	ZOOLOGY	Q2

12	SYSTEMATIC AND APPLIED ACAROLGY	ENTOMOLOGY	Q2
13	BANACH JOURNAL OF MATHEMATICAL ANALYSIS	MATHEMATICS	Q2
		MATHEMATICS, APPLIED	Q3
14	JOURNAL OF BIOGEOGRAPHY	ECOLOGY	Q1
		GEOGRAPHY, PHYSICAL	Q1
15	ORYX	BIODIVERSITY CONSERVATION	Q2
		ECOLOGY	Q2
16	PLOS ONE	MULTIDISCIPLINARY SCIENCES	Q1
17	ENERGY & FUELS	ENERGY & FUELS	Q2
		ENGINEERING, CHEMICAL	Q1
18	AMERICAN JOURNAL OF PHYSICAL ANTHROPOLOGY	ANTHROPOLOGY	Q1
		EVOLUTIONARY BIOLOGY	Q3
19	JOURNAL OF VEGETATION SCIENCE	ECOLOGY	Q2
		FORESTRY	Q1
		PLANT SCIENCES	Q1
20	PHYSICAL REVIEW A	OPTICS	Q1
		PHYSICS, ATOMIC, MOLECULAR & CHEMICAL	Q2
21	PHYSICAL REVIEW LETTERS	PHYSICS, MULTIDISCIPLINARY	Q1
22	INTERNATIONAL REVIEW OF RESEARCH IN OPEN AND DISTRIBUTED LEARNING	EDUCATION & EDUCATIONAL RESEARCH	Q2
23	JOURNAL OF MOUNTAIN SCIENCE	ENVIRONMENTAL SCIENCES	Q4
24	OPTIMIZATION LETTERS	MATHEMATICS, APPLIED	Q2
25		OPERATIONS RESEARCH & MANAGEMENT SCIENCE	Q3
26	SCIENCE	MULTIDISCIPLINARY SCIENCES	Q1
27	MATHEMATICAL POPULATION STUDIES	DEMOGRAPHY	Q4
		MATHEMATICS, INTERDISCIPLINARY APPLICATIONS	Q4
		SOCIAL SCIENCES, MATHEMATICAL METHODS	Q4
		STATISTICS & PROBABILITY	Q4
28	LINEAR & MULTILINEAR ALGEBRA	MATHEMATICS	Q2
29	Evidence-based Complementary and Alternative Medicine	INTEGRATIVE & COMPLEMENTARY MEDICINE	Q2
30	ACAROLOGIA	ENTOMOLOGY	Q2
31	MATHEMATICA	MATHEMATICS	Q3

	SCANDINAVICA		
32	MOSCOW UNIVERSITY PHYSICS BULLETIN	PHYSICS, MULTIDISCIPLINARY	Q4
33	ZOOKEYS	ZOOLOGY	Q3
34	PHYSICS OF PARTICLES AND NUCLEI	PHYSICS, PARTICLES & FIELDS	Q4
35	JOURNAL OF MAPS	GEOGRAPHY	Q2
		GEOGRAPHY, PHYSICAL	Q3
36	JOURNAL OF INDUSTRIAL AND MANAGEMENT OPTIMIZATION	ENGINEERING, MULTIDISCIPLINARY	Q3
		MATHEMATICS, INTERDISCIPLINARY APPLICATIONS	Q3
		OPERATIONS RESEARCH & MANAGEMENT SCIENCE	Q4
37	ELECTRONIC JOURNAL OF LINEAR ALGEBRA	MATHEMATICS	Q3
38	ASTROPHYSICS AND SPACE SCIENCE	ASTRONOMY & ASTROPHYSICS	Q3
39	SOCIAL CHOICE AND WELFARE	ECONOMICS	Q3
		SOCIAL SCIENCES, MATHEMATICAL METHODS	Q4
40	NEOTROPICAL ENTOMOLOGY	ENTOMOLOGY	Q3
41	JOURNAL OF NATURAL PRODUCTS	CHEMISTRY, MEDICINAL	Q1
		PHARMACOLOGY & PHARMACY	Q1
		PLANT SCIENCES	Q1
42	APPLIED MATHEMATICS AND COMPUTATION	MATHEMATICS, APPLIED	Q1
43	PHYSICAL REVIEW C	PHYSICS, NUCLEAR	Q2
44	JOURNAL OF THE SOCIETY FOR INFORMATION DISPLAY	ENGINEERING, ELECTRICAL & ELECTRONIC	Q4
		MATERIALS SCIENCE, MULTIDISCIPLINARY	Q4
		OPTICS	Q4
		PHYSICS, APPLIED	Q4
45	JETP LETTERS	PHYSICS, MULTIDISCIPLINARY	Q3
46	JOURNAL OF MONETARY ECONOMICS	BUSINESS, FINANCE	Q1
		ECONOMICS	Q1
47	JOURNAL OF NATURAL MEDICINES	CHEMISTRY, MEDICINAL	Q3
		PHARMACOLOGY & PHARMACY	Q3
48	ACTA MATHEMATICA HUNGARICA	MATHEMATICS	Q3
49	JOURNAL OF PHYSICS B-ATOMIC MOLECULAR AND OPTICAL PHYSICS	OPTICS	Q2
		PHYSICS, ATOMIC, MOLECULAR & CHEMICAL	Q3
50	OPTICS	OPTICS	Q3

	COMMUNICATIONS		
51	PHYTOCHEMISTRY LETTERS	BIOCHEMISTRY & MOLECULAR BIOLOGY	Q4
		PLANT SCIENCES	Q2
52	GLOBAL CHANGE BIOLOGY	BIODIVERSITY CONSERVATION	Q1
		ECOLOGY	Q1
		ENVIRONMENTAL SCIENCES	Q1

Quartile Score*- Томсон Ройтерсоос сэтгүүлүүдийн чансааг шинжлэх ухааны нарийн чиглэл дотроо багцлан тогтоох шинэ үзүүлэлт.

Тайлангийн хугацаанд Томсон Ройтерсийн бүртгэлтэй өгүүллийн үр дүнг хамтран гаргасан хамтын ажиллагаатай гадаад орны судалгааг хийхэд ОХУ, АНУ, Япон, Герман, Хятад, Өмнөд Солонгос, Австрали, Канад, Их британи улстай идэвхтэй хамтын ажиллагаатай байв.

Багш нарын Web of Science –д хэвлүүлсэн өгүүллийн тайлангийн хугацааны эшлэлд дүн шинжилгээ хийхэд Болдгив.Б- 27, Баатарбилэг.Н-5, Баяртогтох.Б-5, Одсүрэн.М-4, Нарангарвуу.Д-3, Жавхлантөгс.Н-2 нар тэргүүлж байна:

1. Fraser, Lauchlan H.; Pither, Jason; Jentsch, Anke; et al.2015. Worldwide evidence of a unimodal relationship between productivity and plant species richness. **SCIENCE**349(6245):302-305. (Эшлэл-2015-2, 2016-25, нийт-27, дундаж -13.5).

2. Zhang, Jin; Tuguldur, Badamkhatan; van der Spoel, David.2015. Force Field Benchmark of Organic Liquids. 2. Gibbs Energy of Solvation. **JOURNAL OF CHEMICAL INFORMATION AND MODELING** 55(6):1192-1201. (Эшлэл-2015-3, 2016-6, нийт-9, дундаж-4.5).

3. Davi, N. K.; D'Arrigo, R.; Jacoby, G. C.; et al.2015.A long-term context (931-2005 CE) for rapid warming over Central Asia. **QUATERNARY SCIENCE REVIEWS** 121:89-97. (Эшлэл-2015-1, 2016-4, нийт-5, дундаж-2.5).

4. Ermilov, Sergey G.; Bayartogtokh, Badamdorj.2015.Systematic placement of some taxa in the family Galumnidae (Acari, Oribatida). **ZOOTAXA** 3964(4): 489-493. (Эшлэл-2015-3, 2016-2, нийт-5, дундаж-2.5)

5. Odsuren, Myagmarjav; Kikuchi, Yuma; Myo, Takayuki; et al.2015. Virtual-state character of the Be-9 1/2(+) state in the Be-9(gamma,n)Be-8 reaction. **PHYSICAL REVIEW C** 92(1) (Эшлэл-2015-2, 2016-2, нийт-4, дундаж-2).

6. Belov, Oleg V.; Krasavin, Eugene A.; Lyashko, Marina S.; et al.2015. A quantitative model of the major pathways for radiation-induced DNA double-strand break repair **JOURNAL OF THEORETICAL BIOLOGY** 366:115-130 (Эшлэл-2015-3, 2016-1, нийт-4, дундаж-4).

7. Pfeiffer, Martin; Batbayar, Gunsmaa; Hofmann, Juergen; et al.2015. Investigating arsenic (As) occurrence and sources in ground, surface, waste and drinking water in northern Mongolia.

ENVIRONMENTAL EARTH SCIENCES 73(2): 649-662 (Эшлэл-2015-4, дундаж-2).

8. Narangarvuu, Dashdondog; Oyunbileg, Jargalsaikhan; Yang, Ping-Shih; et al.2015. Distribution of Ephemeroptera, Plecoptera, and Trichoptera assemblages in relation to environmental variables in headwater streams of Mongolia. **ENVIRONMENTAL EARTH SCIENCES** 73(2): 835-847. (Эшлэл-2015-1, 2016-2, нийт-3, дундаж-1.5).

9. Orlov, Andrei V.; Strekalovsky, Alexander S.; Batbileg, S.2016. On computational search for Nash equilibrium in hexamatrix games. **OPTIMIZATION LETTERS** 10 (2):369-381.(Эшлэл-2015-1, 2016-1, нийт-2, дундаж-2).

10. Nagao, Takashi; Mishima, Daisuke; Javkhlantugs, Namsrai; et al. 2015. Structure and orientation of antibiotic peptide alamethicin in phospholipid bilayers as revealed by chemical shift oscillation analysis of solid state nuclear magnetic resonance and molecular dynamics. **BIOCHIMICA ET BIOPHYSICA ACTA-BIOMEMBRANES**1848 (11): 2789-2798. (Эшлэл-2016-2, нийт-2, дундаж-1).

МУИС-ийн судалгааны ажлын хүрсэн түвшин, чанарыг Шинжлэх Ухааны Академи (ШУА), Шинжлэх Ухаан, Технологийн Их сургууль (ШУТИС), Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль (АШУҮИС), Хөдөө Аж Ахуйн Их Сургууль (ХААИС), Монгол Улсын Боловсролын Их Сургуультай харьцуулах зорилгоор эдгээр байгууллагуудын 2014-2015 онд хэвлүүлсэн Томсон Ройтерсийн мэдээллийн санд бүртгэлтэй тоог шүүн үзэхэд,

Хүснэгт 2.6.

2015-2016 Web of Science-ын үндэсний үзүүлэлт.

№	Байгууллагын нэр	Эзлэх хувь (%)
1	МУИС	33.9
2	ШУА	23.0
3	АШУҮИС	20.8
4	ШУТИС	12.0
5	ХААИС	7.1
6	УБ ИС	2.2
7	МУБИС	1.1

Байв. (Хүснэгт 2.6). Манай улсад хийгдэж байгаа судалгааны гүйцэтгэлийн 33.9 хувийг МУИС дангаараа, 43.2 хувийг бусад төрийн өмчийн их сургуулиуд, 23 хувийг ШУА гүйцэтгэж байгааг дээрх хүснэгтээс харж болох юм. Судалгааны ажил хийх материал, санхүү, хүний нөөц төрийн өмчийн их сургуулиуд, ялангуяа, МУИС нь Монгол улсын хамгийн чухал судалгааны байгууллага гэдэг нь тодорхой ба цаашид судалгааны чанар, дэд бүтцийг сайжруулахын тулд өнөөгийн оюутны сургалтын төлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр нь хангалтгүй байгаа тул Монгол улсын засгийн газраас нэмэлт санхүүжилт зайлшгүй шаардлагатай.

2.7. Олон улсын хэмжээний эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн мэдээллийн санг ашигладаг байдал

Эрдэм шинжилгээний гүйцэтгэлийн олон улсын хянан магадлагааг гүйцэтгэхдээ 2011 оноос эхлэн Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын ARDI +AGORA+HINARI+OARE, ASPI хөтөлбөр, Томсон Ройтерс компанийн Web of Science, Journal Citation Report, Томсон Инновейшн компанийн Core Patents зэрэг бүтээгдэхүүнийг хянан магадлагаанд ашиглаж, Томсон Ройтерсийн шинжээчдийн дүгнэлттэй танилцах, багш, оюутныг хуурамч, луйврын эрдэм шинжилгээний сэтгүүлд (<http://scholarlyoa.com>) хэвлүүлэх үйлдлээс зайлсхийх сэрэмжлүүлэг бүхий хянан магадлагааг гүйцэтгэж байна. SPRINGER, JSTOR, EBSCO, ROYAL SOCIETY, PNAS, SPIE, MATHSCINET, POLICY PRESS, ANNUAL REVIEWS, ECOLOGICAL SOCIETY OF AMERICA, <http://oaspa.org> эрдэм шинжилгээний санг 2015-2016 онд нээв. Бусад нээлттэй мэдээллийн санг дурьдвал:

- open-access.net/de-en/homepage/ нээлттэй эш сэтгүүлийн сан
- <http://www.jst.go.jp/global/english/>
- EduDonor Index (www.EduDonorIndex.com)

- http://www.euraxess.de/portal/funding_database_in.html
- <http://www.jst.go.jp/global/english/>
- www.doaj.org - DOAJ
- www.jstage.jst.go.jp - J-STAGE
- www.scielo.br - SciELO
- www.arxiv.org -arXiv
- www.jhudatascience.org
- www.software-carpentry.org
- <http://publicationethics.org>
- <http://scholarlyoa.com/>
- <http://oaspa.org>
- <https://project.num.edu.mn/#/post>
- project.edu.mn
- <http://31.184.194.81/> Sci-Hub

Томсон Ройтерс компанийн Web of Science, Journal Citation Report, Томсон Инновейшн компанийн Core Patents зэрэг бүтээгдэхүүний богино хугацааны туршилтын лицензийг нэвтрүүлж COS-PIVOT, Scival Funding олон улсын төслийн зарлалын системийг түр хугацаагаар жил бүр нээж мэдээллийн сангаа бүрдүүлж нээлттэй мэдээллийг Европын холбооны HORIZON 2020 хөтөлбөрөөс авч байна.

2.8.Технологи дамжуулах

Инновацийн хөгжлийг хурдасгах, технологийг үйлдвэрлэлд амжилттай нэвтрүүлэхэд оюуны өмчийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилтын хүрээнд оюуны өмчийн “Оюуны өмчийн тогтолцоо: Монгол улсад ба олон улсад”, “Шинжлэх ухааны болон бизнесийн салбарт оюуны өмчийн мэдээллийг ашиглах, түүний ач холбогдол” , “ДООБ-ын TISC, ARDI, ASPI хөтөлбөрүүд”, “Аж үйлдвэрийн өмчийн эрхзүйн зохицуулалт” сэдэвтэй цуврал сургалтыг зохион байгуулсан.

“Оюуны өмчийн тогтолцоог хөгжүүлэх үндэсний стратеги”-ийн зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд оюуны өмчийг үнэлэхэд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, бодлогын түвшинд гарах шийдвэрийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор “Оюуны өмчийн үнэлгээ нь оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах арга зам болох нь” сэдэвт хэлэлцүүлгийг Оюуны өмчийн газар, Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан.

Технологи дамжуулалтыг эрчимжүүлэх, их сургууль- аж үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Судалгаа-туршилт-үйлдвэрлэл” хэлэлцүүлэг, Сүү ХК-тай хамтарсан “Технологийн форум”, Монос групптэй хамтарсан “Түншлэлийн хөгжил” хамтын ажиллагааны уулзалтуудыг тус тус зохион байгуулсан.

Монгол Улсын мэдлэгт суурилсан эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, талуудын хөгжлийн бодлого ба стратеги, урт ба дунд хугацааны зорилтуудад тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа боловсруулалт, технологи дамжуулалт, сургалтын хүрээнд буюу их сургууль-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор Монхимо ХХК, Сүү ХК-тай “Хамтын ажиллагааны санамж бичиг” болон Эрдэнэс Монгол ХХК-тай “Хамтын ажиллагааны ерөнхий гэрээ” тус тус байгуулсан ба энэ хүрээнд хамтарсан төсөл санаачилсан.

МУЗГ-аас “Оюуны өмчийн тогтолцоог хөгжүүлэх үндэсний стратеги”, “Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үр дүнд бий болсон

оюуны өмчийг өмчлүүлэх, эзэмшүүлэх журам” зэрэг батлагдсан, нөгөө талаас нийгэм, эдийн засгийн орчинд гарч буй өөрчлөлт, технологийн шинэчлэл зэрэг хурдацтай өөрчлөгдөж буй гадаад хүчин зүйлүүдийн нөлөөллийг харгалзан үзэж МУИС-ийн хүрээнд баримтлах бодлого журмуудыг шинэчлэж байна.

ДОАБ, МУОӨГ, БНСУ-ын ОӨГ-ын дэмжлэгтэйгээр зохион байгуулж байгаа “Инновацийн шийдэл-бидний амьдралд 2015” уралдаанд судлаачдын 4 төслийг эмхэтгэж бүртгүүлсэн. Тус уралдаанд Б.Батжаргал, Б.Очирхуяг, Ж.Сүхдолгор нарын “Сүүний үйлдвэрийн хаягдал шар сүүг ашиглан антиоксидант идэвхтэй ундаа үйлдвэрлэх арга” сэдэвтэй шийдэл хоёрдугаар байр эзэлж ДОӨБ-ын медаль хүртсэн.

2015 оны 12 дугаар сараас АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр БСШУЯ-наас хэрэгжүүлж байгаа ДБШТ-ийн хүрээнд “Технологи дамжуулалт ба технологи шингээх чадварыг тодорхойлох судалгаа” сэдэвт судалгааны төслийг хэрэгжүүлж байна.

2014 оноос хэрэгжүүлж байгаа ХБНГУ-ын Мартин Лютерийн нэрэмжит Халле-Виттенбэргийн Их Сургууль, БНСУ-ын Ханбатын Үндэсний Их Сургуулиудтай хамтран Германы Эрдмийн Солилцооны Албаны (DAAD) санхүүжилтээр “Судалгаа болон технологи дамжуулалт-МУИС-д технологи дамжуулах төв байгуулах” сэдэвт төсөл хэрэгжиж ХБНГУ-ын Мартин Лютерийн нэрэмжит Халле-Виттенбэргийн Их Сургууль, БНСУ-ын Ханбатын Үндэсний Их Сургуулийн инноваци ба технологи дамжуулалтыг хариуцсан албадуудын мэргэжилтнүүдтэй хамтран ажилласан. Үүнд:

МУИС-ийн хүрээнд баримтлах оюуны өмч, технологи дамжуулалтын бодлого, журмуудын шинэчлэх ажилд өөрийн сургуулийн багш судлаачдын санал, зөвлөмжийг тусгахаас гадна тус төслийн хамтрагч хоёр сургуулийн инноваци ба технологи дамжуулалтыг хариуцсан албадуудын мэргэжилтнүүд, ДОӨБ-ын зөвлөхүүд зэрэг олон мэргэжлийн хүмүүстэй энэ асуудлаар зөвлөмж авав.

Энэ оны 05 дугаар сарын 30-наас 06 дугаар сарын 03-ны хооронд тус төслийн удирдлагууд болон багийн гишүүдийн нэгдсэн уулзалтыг МУИС зохион байгуулсан. Энэ уулзалтын үеэр манай дэд зорилтын хүрээнд ажлын хэсгийн хамтарсан 4 удаагийн уулзалт, ярилцлага болох ба төгсгөлд нь өмнө хийсэн ажлуудын үр дүнг нэгтгэх, дараагийн ажлыг төлөвлөх нэгдсэн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн энэ ажлын хүрээнд 2016 оны 05 дугаар сарын 31-ний өдөр “Establishment and implementation of a center of innovation and technology transfer” уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

“TISC” МУ-д технологи ба инновацийг дэмжих сүлжээ байгуулах хөтөлбөрийн хүрээнд дотоодын гишүүн байгуулагын дунд болон ДОӨБ, ОӨГазрын удирдлагуудын оролцоотой нийт хоёр удаагийн семинар, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

БҮЛЭГ 3. СУРГАХ, СУРАЛЦАХ ҮЙЛ ЯВЦ

МУИС-ийг 2016-2024 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний “Сургах ба сурах үйл явцыг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэх” тэргүүлэх чиглэлийн хүрээнд элсэлтийн бодлогыг дорвитой өөрчилж, Монгол улсын өнцөг булан бүрээс шилдэг суралцагчийг гэлсүүлэх, улсын лаборатори ахлах сургуулиудтай хамтарч ажиллах, хос болон хавсарга хөтөлбөрийг боловсруулж мөрдөх эрх зүйн орчныг тус хичээлийн жилд бүрдүүлэн хэрэгжүүлж ажиллалаа. Түүнчлэн, МУИС-ийн захирлын 2015 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/203 тоот тушаалаар батлагдсан Сургалтын журмыг 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлсэн тул сургалтын бодлогын хүрээнд журманд тусгагдсан шинэ заалтууд мөрдөгдөж эхэлсэн.

МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2015 онд оюутан элсүүлэх журмыг шинэчлэн боловсруулж Захирлын 2015 оны 03-р сарын 11-ний өдрийн А/70 тоот тушаалаар батлуулсан. Уг журамд орсон томоохон өөрчлөлт нь хөдөө орон нутгийн элсэлтийн үйл ажиллагааг МИДСК-ын журмын дагуу хамтран зохион байгуулдаг уламжлалыг халж МУИС элсэлтийн үйл ажиллагаагаа бие даан орон даяар цахим системээр, ил тод, шударга явуулах хяналттай системийг бүрдүүлсэн. Түүнчлэн, олон улсын болон үндэсний хэмжээний олимпиад, уралдаанд амжилт гаргасан болон элсэлтийн ерөнхий шалгалтын өндөр оноо авсан элсэгчдийг татах бодлогын хүрээнд холбогдох зүйл, заалтуудыг оруулж нийт улсын олимпиадад оролцож амжилт гаргасан 23 суралцагчийг элсүүлсэн.

Элсэлтийг цоо шинэ хувилбараар зохион байгуулах болсонтой холбогду улантаниулах үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

- БСШУЯ-аар дамжуулан элсэлтийн сурталчилгааг аймаг, дүүргийн боловсролын газартай хамтран зохион байгуулсан. 2015 оны хичээлийн жилийн элсэлт, түүний онцлогийг сурталчлах зорилгоор Сургалтын нэгдсэн албаны дарга, мэргэжилтэн, бүрэлдэхүүн сургуулийн захирал, дэд захирал, багш, сургалтын албаны эрхлэгч, мэргэжилтний бүрэлдэхүүнтэй багхөдөө орон нутагт хүрч ажилласан.
- МУИС-ийн элсэлтийн үйл ажиллагааны тухай сэтгүүл, сонин, видео шторк зэрэг материалыг бэлтгэж Монгол улсын 21 аймаг, 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид хүргэсэн.
- Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран боловсролын үзэсгэлэн яармагуудад идэвхтэй оролсон.
- Монголын Сурагчдын Холбоотой хамтран МУИС-тай танилцах аялал зохион байгуулсан. Үүнд Нийслэлийн болон орон нутгийн ахлах сургуулиудын ахлах ангийн шилдэг сурагчдын төлөөлөл 1000 гаруй сурагчид хамрагдсан.
- МУИС-ийн цахим хуудас, сошиал орчинд элсэлтийн танилцуулга, видео шторк, мэдээ мэдээллийг түгээсэн. Үүнд “Монгол улсын их сургууль”, “Сургалтын нэгдсэн алба”, “МУИС-Элсэлт 2015” гэсэн мэдээллийн хуудсыг ажиллуулж эхэлсэн бөгөөд аймаг, дүүргүүдийн цахим хуудсанд элсэлтийн танилцуулга мэдээллийг байршуулсан.

Шилдэг суралцагчийг элсүүлэхийн тулд олон улс, үндэсний олимпиадад оролцсон элсэгчийг хөнгөлөлттэй нөхцөлөөр элсүүлж, олимпиадад эхний 3 байр эзэлсэн элсэгчдэд тэтгэлэг олгох, ШУС-ийн БУ-ны салбар, ХШУИС-д элсэгчдийн

элсэлтийн ерөнхий шалгалт 650-аас дээш оноотой бол сургалтын төлбөрийн 50%-ийг хөнгөлсөн.

МУИС-ийн захирлын 2015 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/203 тоот тушаалаар батлагдсан Сургалтын журам тус хичээлийн жилээс хэрэгжиж эхэлсэн ба сургалтын бодлогын хүрээнд орсон шинэ заалтуудын нэг болох 4.6.11.8-ын дагуу Монгол улсад Кембрижийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй Ерөнхий боловсролын сургуулиудтай хамтын ажиллагааг эхлүүлэх харилцан ойлголцлын санамж бичигт 2016 оны 07 дугаар сарын 01-ны өдөр гарын үсэг зурсан. Хамтын ажиллагааны хүрээнд “Орчлон” олон улсын дунд сургууль, БСШУЯ-ны харьяа олон улсын хөтөлбөрийн сургалттай “Шинэ эхлэл”, “Шинэ эрин”, “Монгол тэмлүүлэл” лаборатори сургуулиудыг төгсч МУИС-д элссэн оюутнуудын А болон АS түвшинд судалсан хичээлийг МУИС-ийн Ерөнхий суурийн хичээлтэй багц цаг дүйцүүлэн тооцохоор тогтсон бөгөөд Захирлын 2016 оны 07 дугаар сарын 08-ны А/199 тушаалаар батлагдсан. Энэхүү үйл ажиллагаа нь МУИС болон шилдэг Ерөнхий боловсролын сургуулиудын хамтын ажиллагааг эхлүүлэх, цаашид шилдэг суралцагч элсүүлэхэд өндөр ач холбогдолтой.

Тус хичээлийн жил бакалаврын түвшний элсэлт хэт бага байгаа нь ахлах сургууль төгсөгчдийн тоо цөөн байсантай холбоотой. Өмнөх онуудад жилд 40,000 орчим сурагч ерөнхий боловсролын сургуулийг төгсөж их, дээд сургуульд элсэн суралцдаг байсан бол энэ жил 19,735 сурагч төгсч элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн байна. МУИС-д элсэхээр 5,765 иргэн бүртгүүлсэнээс 2,573-ийг элсүүлсэн. Үүнийг БСШУЯ-аас баталсан элсэлтийн хяналтын тоотой харьцуулбал 73,5 хувьтай байна. Элсэгчдийн дундаж оноо хотод 604, хөдөө орон нутагт 638 нийт МУИС-ийн хэмжээнд 619 болж өмнөх хичээлийн жилийнхээс буурсан бөгөөд энэ нь ЕБС төгсөгчдийн тоо буурсантай холбоотой(Хүснэгт 3.9.1).

Бакалаврын орой, эчнээ хөтөлбөрийн ангид оюутан элсүүлэх журмыг шинэчлэн боловсруулж Захирлын 2015 оны 11 дүгээр сарын 13-ны А/334 дугаар тушаалаар батлуулсан. Орой, эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх журмыг жил бүр шинэчлэн батлуулдаг байсан уламжлалыг халж элсэлт авах хөтөлбөр, хяналтын тоог жил бүрэлдэхүүн сургуулиас ирсэн саналын дагуу тогтоож байхаар шийдвэрлэсэн. Тус хичээлийн жилд бакалаврын оройн хөтөлбөрт 101, эчнээ хөтөлбөрт 139 оюутан тус тус элссэн байна. (Хүснэгт 3.9).

Магистр, докторын түвшний элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахдаа Захирлын 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/220 дугаар тушаалаар батлагдсан “Магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам”-ын дагуу, ХЕХ-ны хурлаар баталсан мэргэжлийн, судалгааны, магистрын нөхцөлт хөтөлбөрөөр элсэлт авсан. 2015-2016 оны хичээлийн жилд магистрын хөтөлбөртнийг 853 магистрант элсэн орсноос судалгааны хөтөлбөрт 367, мэргэжлийн хөтөлбөрт 231, нөхцөлт хөтөлбөрт 146, нөхцөлт хөтөлбөрөөс үндсэн хөтөлбөрт 84, докторын хөтөлбөрт нийт 133 докторант элсэн орсноос өдрийн хөтөлбөрт 105, эчнээ хөтөлбөрт 12, нөхцөлт хөтөлбөрт 3 докторант элсэн орсон байна. Мөн гадаад суралцагчдаас магистрын хөтөлбөрт 25, докторын хөтөлбөрт 13 элссэн. (Хүснэгт 3.10).

Сургалтын хөтөлбөр

МУИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хороо нь тус хичээлийн жилд бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хорооноос ирсэн саналыг үндэслэн ХШУИС-ийн Электроник, Компьютерийн сүлжээ, БС-ийн Хөрөнгийн үнэлгээ, Гадаад худалдаа, гаалийн удирдлага нэр бүхий магистрын 6 хөтөлбөрийг 4 индексээр, ХШУИС-ийн

Компьютерийн ухаан, Програм хангамж, Мэдээллийн технологинэр бүхий докторын 3 хөтөлбөрийг 3 индексээр тус тус хэлэлцэж МУИС-ийн Захирлын 2016 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн А/186 тоот “Магистр, докторын хөтөлбөр батлах тухай” тушаалаар баталгаажуулсан болно. (Хүснэгт 3.1).

Хөтөлбөрийн ерөнхий хороо 2015-2016 оны хичээлийн жилд нийт 8 удаа хуралдаж дээрхи хөтөлбөрүүдийг хэлэлцэхээс гадна “ХЕХ-ны түр журам” шинэчлэх, хавсарга хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам болонтус журмаар сургалт явуулах хавсарга хөтөлбөрүүдийг баталлаа.

Хөтөлбөрийн ерөнхий хороо, дэд хороодын гишүүд, бүрэлдэхүүн сургуулийн захирал, сургалтын албаны эрхлэгч нарыг хамруулсан нэг өдрийн өргөтгөсөн хэлэлцүүлэг, сургалт семинар зохион байгуулсан (Хүснэгт 3.4-3.5).

Хөтөлбөрүүдийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэлд хамруулах ажлын хүрээнд ШУС-ийн БУ-ны салбарын 8 хөтөлбөр (физик, математик, газар зүй, газар зохион байгуулалт, шатах ашигт малтмал, биологи, биотехнологи, экологи), ХШУИС-ийн 2 хөтөлбөр (мэдээллийн технологи, электрон системийн автоматжуулалт), олон улсын ASIIN магадлан итгэмжлэлийн байгууллагад ШУС-ийн Хими, ХШУИС-ийн Програм хангамжийн хөтөлбөрийг тус тус магадлан итгэмжлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна. Эдгээр хөтөлбөрүүдийг дотоодын болон олон улсын магадлан итгэмжлэлд хамруулахад Азийн хөгжлийн банкнаас дэмжлэг авч байгаа. (Хүснэгт 3.3).

2015-2016 оны хичээлийн жилд шинээр магистрын 5 (ШУС-ийн Байгалийн нөөцийн менежмент, жендер судлал, сансар судлал, ХШУИС-ийн компьютерийн ухаан, ОУХНУС-ийн олон улсын эдийн засгийн харилцаа), докторын 2 (ХШУИС-ийн мэдээллийн технологи, ОУХНУС-ийн нийтийн удирдлага) хөтөлбөрөөр сургалт явуулахаар БСШУЯ-наас тусгай зөвшөөрөл аваад байна.

Хамтарсан хөтөлбөр

Бизнесийн сургуульд Английн NCC боловсрол олон улсын байгууллагатай хамтарсан “Бизнесийн удирдлага”-ын хөтөлбөрийг 2008 оноос хойш хэрэгжүүлсээр байна. 2015-2016 оны хичээлийн жилд тус хөтөлбөрт нийт 7 оюутан элсэн суралцсаныг түвшин тус бүрээр авч үзвэл: олон улсын бэлтгэл түвшин (IFY)-д 2, бизнесийн дипломын дөрөвдүгээр түвшин (L4DB)-д 3, бизнесийн дипломын тавдугаар түвшин (L5DB)-д 2, бизнес менежментийн дипломын долоодугаар түвшин (L7DBM)-д 1 оюутан тус тус элсэн суралцаж байна. 2015-2016 оны хичээлийн жилд 5 оюутан хөтөлбөрөө амжилттай дүүргэж сертификат хүртсэн.

Хууль зүйн сургууль нь 2006 онд Япон улсын Нагоягийн их сургууль, 2011 онд БНСУ-ын Күүкманий их сургуулийн Хуулийн сургуультай хамтын ажиллагааны гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Уг гэрээний дагуу ХЗС дээр Японы эрх зүйн боловсрол, судалгааны төв, Солонгосын эрх зүйн боловсрол, судалгааны төв үйл ажиллагаа явуулдаг. Японы эрх зүйн хөтөлбөр хэрэжиж эхэлснээс хойш тус хичээлийн жил нийт 6 дахь удаагийн төгсөлт хийж нийт 41 оюутан төгсөөд байна. Солонгосын эрх зүйн хөтөлбөрөөр 2015-2016 онд анх удаагийн төгсөлт хийж 8 оюутан төгссөн.

Олон улсын харилцаа нийтийн сургуулийн хувьд Олон улсын эдийн засгийн харилцааны хөтөлбөрийг ШУС-ийн Эдийн засгийн тэнхимтэй хамтран салбар дундын хөтөлбөр болгон боловсруулж бүрэлдэхүүн сургуулиудын хөтөлбөрийн хороогоор батлуулсан. ОУХ, улс төр, эдийн засаг, бизнес, олон улсын эрх зүй зэрэг шинжлэх ухааны чиглэлүүдийг хамарсан салбар дундын онцлогтой хөтөлбөрийг хөгжүүлэх нь МУИС-ийн стратегийн зорилтуудын нэг юм.

Хавсарга болон хос хөтөлбөр

МУИС-ийн суралцагчид өргөн сонголт олгож хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх боломжийг бий болгох, нийгмийн эрэлт хэрэгцээтэй шинжлэх ухааны салбаруудаар системтэй мэдлэг, ур чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн “Хавсарга хөтөлбөрийн журам”-ыг боловсруулан Захирлын А/53 тоот тушаалаар баталгаажууллаа. Үүний дагуу тус хичээлийн жил Хөтөлбөрийн ерөнхий хороо ШУС-ийн 29, БС-ийн 7, ХЗС-ийн 1, ОУХНУС-ийн 2 нийт 39 “Хавсарга хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд эдгээр нь 2016-2017 оны хичээлийн жилээс хэрэгжих бүрэн боломжтой болсон. (Хүснэгт 3.2).

Хавсарга хөтөлбөрөөр суралцахаар ШУС-ийн 6 оюутан, ШУС-ийн хөтөлбөрт3, ШУС, ХШУИС-ийн хөтөлбөрт 2, ШУС, БС-ийн хөтөлбөрт 2, ШУС, ХЗС-ийн хөтөлбөрт 1, БС-ийн хөтөлбөрт 1 нийт 9 суралцагч хос мэргэжлээр суралцах хүсэлтээ тус тус гаргаж 2016-2017 оны хичээлийн жилээс хос болон хавсарга мэргэжлээр суралцахаар шийдвэрлүүлсэн юм.

Мэргэжлийн хөтөлбөр сонголт

МУИС-ийн “2015-2016 оны хичээлийн жилд элссэн бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам”-ыг сайжруулан боловсруулж Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурлаар хэлэлцүүлэн Захирлын 2016 оны 1 дүгээр сарын 18–ны өдрийн А/14 дүгээр тушаалаар баталгаажуулав.

Хөтөлбөр сурталчлах үйл ажиллагааг сургалтын алба, тэнхимүүд хамтран намар, хаврын улиралд мэргэжлийн хөтөлбөрийн тандалтын судалгаа авахаас өмнө давтамжтайгаар зохион байгуулж оюутан, тэдний эцэг эхчүүдэд мэргэжлийн хөтөлбөр, ажлын байрны талаарх мэдээлэл зөвлөгөөг өгч “2015-2016 оны хичээлийн жилд элссэн бакалаврын түвшний оюутны мэргэжил сонгох журам”-ыг дэлгэрэнгүй танилцуулж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа. Мөн зарим сургуулиуд дээр ажил олгогч нар хамтарч ажилласан. (Хүснэгт 3.6).

Тус хичээлийн жил мэргэжлийн хөтөлбөр сонгох болзол хангасан нийт 2,545 оюутнаас 2,102 оюутан сонголтоо хийж баталгаажуулсан байна. ШУС-ийн НУС-аас хамгийн эрэлттэй байгаа хөтөлбөр эдийн засаг, цөөн оюутан сонгосон хөтөлбөр антропологи, археологи, харин БУС-ын хамгийн эрэлттэй хөтөлбөр хот ба бүс нутаг төлөвлөлт, газар зохион байгуулалт, хамгийн бага сонголттой хөтөлбөр физик, оюутан огт сонгоогүй хөтөлбөр багш, байгалийн ухааны боловсрол/физик/, ХУС-ын хамгийн эрэлттэй хөтөлбөр багш монгол хэл уран зохиолын боловсрол, багш гадаад хэлний боловсрол /англи/, цөөн оюутан сонгосон хөтөлбөр шашин судлал, олон улс орон судлал /испани, турк/, оюутан огт сонгоогүй хөтөлбөр нь олон улс, орон судлал /польш, чех/, ХШУИС-ийн эрэлттэй хөтөлбөр програм хангамж, статистик, цөөн оюутан сонгосон хөтөлбөр ус судлал, материал судлал, ойн үйлдвэрлэлийн техник технологи зэрэг байна (Хүснэгт 3.7-3.8, График 3.1-3.2).

Тус хичээлийн жилийн оюутны мэргэжил сонголтын дүнг 2014-2015 оны хичээлийн жилийнхтэй харьцуулан үзэхэд хамгийн их оюутан сонгосон хөтөлбөр ШУС-ийн эдийн засаг, ХШУИС-ийн програм хангамж, хамгийн бага оюутан сонгосон ШУС-ийн орон судлал /испани, польш/, антропологи, археологи, шашин судлал, ХШУИС-ийн ойн үйлдвэрлэлийн техник технологи, ус судлал, материал судлалын хөтөлбөрүүд дахин давтагдаж байгаа нь хамгийн ихээр анхаарлаа хандуулах шаардлагатайг харуулж байна. Иймд цөөн оюутан /1-4/ сонгосон болон огт сонгоогүй хөтөлбөрүүдийг цаашид хэрхэн хэрэгжүүлэх талаар бүрэлдэхүүн сургуулийн удирдлагууд, хөтөлбөрийн дэд

хороо хэлэлцэж тэнхмээс санал болгож буй ерөнхий суурийн хичээлийн чанарыг сайжруулах, оюутнуудад мэргэжлийн сурталчилгааг сайн хийх, тэнхмийн багш-оюутны хамтын ажиллагааг чанаржуулах зэрэг ажлуудыг зохион байгуулж, удирдлагаар хангах шаардлагатай байна. Зарим тэнхмийн хувьд хичээлийн хөтөлбөрөө өөрчлөн, сайжруулах ажлыг эхлүүлээд байгаа.

Сургалтын чанар

МУИС тус хичээлийн жилийг “Оюутны жил” болгон зарласантай холбогдон сургалтын чанартонцгойлон анхаарч ажиллаа.

2015-2016 оны хичээлийн жилийн сургах суралцах үйл ажиллагааны онцлог нь МУИС-ийн захирлын 2015 оны 6 сарын 30 өдрийн А/203 тоот тушаалаар батлагдсан “Монгол улсын их сургуулийн сургалтын журам”-ыг хэрэгжүүлж эхэлсэн жил юм. Уг журмын дагуусуралцагчидадзөвлөх багштомилон ажиллуулж сургалтын журам болон хичээл сонголт, бүртгүүлэлт, баталгаажуулалт, хөтөлбөр сонголтын талаар зөвөлгөө өгч байгаа. Хичээлд бүртгүүлэх, баталгаажуулах үйл ажиллагаанд оюутны идэвхи оролцоо өмнөх жилүүдийг бодвол харьцангуй сайжирсан нь Сургалтын мэдээллийн системийн хөгжүүлэлт болон оюутнуудын сиси системийн ашиглалт сайжирсантай холбоотой. Өмнөх хичээлийн жилүүдтэй харьцуулахад хичээлд бүртгүүлэх баталгаажуулах үйл ажиллагаанд магистр, докторын суралцагчдын идэвхи нэмэгдсэн.

Шинэчилсэн сургалтын журмаар явцын шалгалтын долоо хоногийг бий болгосон нь оюутнуудын зүгээс хичээлийн үзсэн сэдвүүдээ бүхэлд нь дүгнэх, давтлага авах, шалгалтандаа бэлтгэх, багш нарын зүгээс оюутнуудтайгаа ажиллах, зөвлөгөө өгөх боломжийг бий болгосноороо ихээхэн ач холбогдолтой байв.

БСШУЯ, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй дээд боловсролын шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд МУИС академик менежментийг сайжруулах төслийн Сургалтын чанарыг сайжруулах дэд зорилтын дагуу СНА, багш нарын бүрэлдэхүүнтэй баг ажиллаж эхэлсэн. Уг төслийн хүрээнд Сургалтын чанарын алба байгуулах хэрэгцээ шаардлага, уг албаны хариуцах ажлыг тодорхойлж МУИС-ийн Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулсан бөгөөд 2016-2017 оны хичээлийн жилд төслийн үр дүн нь бүрэн гарах төлөвлөгөөтэй.

Багш нарын заах арга зүй, сургалтын хөтөлбөрийг улам сайжруулах зорилгоор дээд боловсролын шинэчлэлийн хөтөлбөрийн нэг хэсэг болсон CDIO тогтолцоог Монгол улсын их, дээд сургуулиудын инженерийн хөтөлбөрүүдэд нэвтрүүлэх дэд төсөлд ХШУИС-ийн багш нар оролцсон. Энэ төслийн хүрээнд олон шатлалтайсургалтанд 30 хүртэл тооны багш нар хамрагдаад байна.

МУИС-ийн батлагдсан хөтөлбөрийнг, залгамж холбоог харуулсан“мод”-ынхамтсургалтын мэдээлийн систем, цахим хуудсуудад байршуулсанаар оюутнууд суралцаж буй хөтөлбөрийн хичээлүүдийн уялдаа хамаарлыг ойлгож хичээл сонголтоо зөв хийх боломж бүрдсэн. Цаашид хичээл тус бүрийн тухай мэдээллийг ил тод болгох ажил хийхээр төлөвлөж байна.

Тодорхой хичээл дээр жил бүр оюутнууд олноор амжилтгүй дүн үзүүлэн дараагийн уялдаа холбоотой хичээлийг судалж чадахгүйгээс үүдэн төгсөлт хойшлох явдал олон тохиолдож буй хөтөлбөрүүдийг судалсан. Энэ хүндрэлээс гарах зорилгоор зарим хичээлийг зуны улиралд зохион байгууллаа.

Сургалтын мэдээллийн системд хуримтлагдсан хэрэгжүүлэхээ больсон хуучин хөтөлбөр, хичээлийг цэгцэлж “Архивлагдсан” төлөвт оруулсан.

Ерөнхий суурийн 94 хичээлийг 8 бүлэгт хуваан оюутнуудад санал болгож байгаа бөгөөд хичээл сонгосон байдлыг авч үзэхэд байгалийн ухаан, хүмүүнлэгийн ухаан,

нийгмийн ухаан, судалгаа шинжилгээний арга зүй, биеийн тамир, эрүүл ахуйн бүлгийн хичээлүүдийг оюутнууд намрын улиралд түлхүү сонгосон бол иргэний боловсрол, яриа, бичгийн чадвар, англи хэл болон бусад хэлний хичээлүүдийг хаврын улиралд түлхүү сонгон суралцсан бол өмнөх хичээлийн жилд оюутнууд байгалийн ухаан, нийгмийн ухаан, иргэний боловсрол, судалгаа шинжилгээний арга зүй бүлгийн хичээлүүдээс намрын улиралд сонголт их хийсэн байгаа нь төдийлөн өөрчлөлт ороогүйг харуулж байна (Хүснэгт 3.12).

2015-2016 оны хичээлийн жилд нийт 3,795 оюутан танхимын сургалтаар эзэмшсэн онолын мэдлэг, чадвараа практик үйл ажиллагаатай холбон бататгах, ажиглалт, судалгаа, боловсруулалт хийх чадвар, дадал эзэмших, өөрийн мэргэжлийн салбарт тавигдаж буй зорилт, тулгамдсан асуудлын талаар тодорхой мэдээлэл олж авах, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ур чадваруудыг эзэмших зорилготойгоор дадлага хийсэн (Хүснэгт 3.14).

МУИС-ийн хичээлийн жилд хичээлийн 7 байрны анги, танхим, лабораторит сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулсан бөгөөд суудлын тоо (биеийн тамирын заал ороогүй болно) 16,105 байлаа. Үүнийгидэвхитэй төлөвт суралцсан бакалаврын 12,158, магистрын 1220, докторын 289 буюу нийт 13,667 суралцагчид тооцволанги танхимын ээлж ашиглалтын коэффициент 1.18 байв (Хүснэгт 3.14а).

Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа

2015-2016 оны хичээлийн жилд хичээл заасан багшид оюутны зүгээс өгсөн сэтгэл ханамжийн судалгааны багшийн талаарх асуумжийн бүлгийн дүн МУИС-ийн хэмжээнд 2.51% байна. Үүнээс "Багш хичээлийг логик дэс дараатай, ойлгомжтой, сонирхолтой заадаг" гэсэн хэсэгт хамгийн өндөр үнэлгээ буюу 2.57%, хамгийн бага үнэлгээг "Багш И-сургалтын арга, хэрэгсэл ашигладаг, Хичээл сургалтын материалаа онлайнд байршуулдаг, оюутанд хүртээмжтэй өгдөг", "Багш хичээлийн бус цагаар тогтсон хуваарийн дагуу оюутанд зөвлөгөө өгөх мөн оюутны бие даан суралцах, өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд анхаардаг", "Дараагийн улиралд энэ багш өөр хичээл заасан тохиолдолд дахин сонгоно" гэсэн хэсэгт хамгийн бага буюу 2.47% үнэлгээг тус тус өгчээ. Харин сургалтын орчны талаарх бүлгийн дундаж оноо 2.50% байна. Үүнээс "Анги танхимын суудлын тоо хүрэлцээтэй байдаг" гэсэн хэсэг нь хамгийн өндөр буюу 2.53%, "Анги, танхим тохилог дулаан, гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай, цэвэр байдаг" гэсэн хэсэгт хамгийн бага буюу 2.46% гэсэн үнэлгээг тус тус өгсөн байна. Хичээлийн талаарх бүлгийн дундаж оноо 2.49% байна. "Хичээл хөтөлбөрт тусгагдсан агуулгын дагуу явагддаг" гэсэн хэсэгт энэ бүлгийн хамгийн өндөр үнэлгээг буюу 2.53% гэж үнэлсэн бол "Хичээлд хэрэглэх ном, сурах бичиг, гарын авлага, сургалтын материалын олдоц сайн байдаг" гэсэн хэсэгт хамгийн бага үнэлгээг буюу 2.44% -ийг тус тус өгчээ (Хүснэгт 3.31).

Цаашид суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааны арга зүйг сайжруулах, судалгааг авах хугацаа, судалгааг авч буй захиргааны арга (сиси-д хичээл тандалттай холбож өгснөөр заавал бөглөх шаардлагатай) зэргийг өөрчлөх шаардлагатай эсэхийг судлах хэрэгцээтэй байна.

Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаа, суралцагчидаас ирсэн гомдол, саналд үндэслэн дараах үйл ажиллагааг СА-ны мэргэжилтнүүдийн хүрээнд зохион байгуулсан. Үүнд:

- Гомдол, саналын дагуу "Монгол хэлний зөв бичгийн дүрэм", "Сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийн уялдаа холбоог харуулсан мод зурах туршлага",

“Чанарын удирдлага”, “Багаар ажиллах ур чадвар, харилцааны соёл” сэдвүүдийн хүрээнд сургалт зохион байгуулсан.

- ХШУИС, ХЗС-ийн сургалтын албаны өрөөг камержуулж дүрс, дуугаар бичлэг хийдэг болсон.

Сурлагын дүнгийн шинжилгээ

2015-2016 оны хичээлийн жилийн хаврын улирлын байдлаар бакалаврын хөтөлбөрт суралцагчдын сурлага 1-р түвшнийх 67.5 хувь, 2-р түвшнийх 90.3 хувь, 3-р түвшнийх 97.4 хувь, 4-р түвшнийх 100 хувь, 5-р түвшнийх (ХЗС хувьд) 100 хувийн амжилттай байна. МУИС-ийн хэмжээнд сурлагын хэмжээнд сурлагын амжилт 2013-2014 онд 94.1 хувь, 2014-2015 оны хичээлийн жилд 95.2 хувь, 2015-2016 онд хичээлийн жилд 91.9 хувь болж өмнөх жилүүдээс буурсан нь “Сургалтын журам”-нд WF үсгэн үнэлгээг байхгүй болгосонтой холбоотой юм. 1-р түвшний оюутнуудын сурлагын амжилт 67,5 буюу бусад түвшний оюутнуудынхаас харьцангуй бага байгааг бүрэлдэхүүн сургуулийн захиргаа анхаарч ерөнхий суурь хичээлийн хөтөлбөр, хөтөлбөрийн шаардлага, хичээл сонголт, баталгаажуулалтын талаар болон холбогдох журмыг таниулах, суралцагчид зөвлөх багшаар дамжуулан сургалтын үйл явцтай холбоотой зөвлөгөө өгөх, хичээл зааж буй багш зөвлөгөө өгөх цагтаа суралцагчидыг өргөнөөр хамруулж хэвшүүлэх шаардлагатай байна.

Бакалаврын хөтөлбөрт суралцагчдын хувьд А, А-, В, В-, С, С-, D, D-, F дүнтэй суралцагчийн хувийн жинг суралцаж буй түвшнээр нь харвал А, А-, В, В- дүнтэй суралцагчдын тоо 1-4 түвшинд өндөр, D, D-, F дүнтэй суралцагчдын тоо 1-3 түвшинд өндөр хувьтай байна.

Тус хичээлийн жилд МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт суралцагчдын голч дүн 2.3 байгаа нь 2014-2015 оны хичээлийн жилийн голч дүнгээс 0.1 хувиар буурсан, магистрын хөтөлбөрт суралцагчдын голч дүн 3.13 байгаа нь өмнөх жилийнхээс 0.1 хувиар өссөн, докторын хөтөлбөрт суралцагчдын голч дүн 3.59 байгаа нь өмнөх хичээлийн жилээс 0.9 хувиар буурсан байна.

2015-2016 оны хичээлийн жилд магистрын хөтөлбөрт суралцагчдын сурлагын амжилт 98.2 хувь, докторын хөтөлбөрт суралцагчдын сурлагын амжилт 97.5 хувь байна. Магистр, докторын суралцагчдын сурлагын амжилт, голч дүнг сургалтын мэдээллийн системээр хоёр дахь жилдээ гаргалаа(Хүснэгт 3.15-3.20, График 3.3).

МУИС-ийн хэмжээнд W үнэлгээ авсан суралцагчдын тоо 9,264, R үнэлгээ тавиулсан суралцагчдын тоо 160 байгаа байна. 2014-2015 оны хичээлийн жилд W үнэлгээ авсан суралцагчдын тоо 8,484 (48.2%), WF үнэлгээ авсан суралцагчдын тоо 6,941 (39.5%) байсан(Хүснэгт 3.21) тул тус хичээлийн жилд өөрчилөлт ороогүйг харуулж байна.

Суралцагчдын бүртгэл, шилжилт хөдөлгөөн

2015-2016 оны хичээлийн жилд МУИС-ийн сургалтын мэдээллийн системд бакалаврын түвшний оюутны тоо нийт 17,956, үүнээс идэвхтэй суралцагч 13,182, идэвхгүй суралцагч 3,269, чөлөө авсан 1,505 байна. Магистрын хөтөлбөрт нийт 3,917 суралцагчид байгаагаас идэвхтэй суралцагч 1,220, идэвхгүй суралцагч 2,430, чөлөө авсан 267 суралцагч, докторын хөтөлбөрт нийт 1,016 суралцагч бүртгэлтэй байгаагаас 289 идэвхтэй суралцаж байгаа, 678 идэвхгүй суралцагч, 49 нь чөлөө авсан байна.Өмнөх хичээлийн жилтэй харьцуулан үзвэл бакалаврын түвшинд идэвхитэй суралцагчид 4.7 хувиар буурсан бол магистрын түвшинд 2.3 хувиар, докторын түвшинд

8.2-иар нэмэгдсэн, харин идэвхигүй төлөвт суралцагчид бакалаврын түвшнийх 4.6 хувиар өссөн, магистрын түвшнийх 0.6 хувь, докторын түвшнийх 6.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна(Хүснэгт 3.22).

Суралцагчийн тоог сүүлийн 5 жилийн хугацаанд харьцуулж үзэхэд 2011-2012 оны хичээлийн жилд бакалаврын суралцагчид 83 хувь буюу хамгийн их, харин 2012-2013, 2013-2014, 2014-2015 оны хичээлийн жилд 80 хувь, тайлант хичээлийн жилд 79 хувь болж буурсан. Магистрын суралцагчдын эзлэх хувь өнгөрсөн хичээлийн жилд 16 хувь хамгийн их, докторын суралцагчдын хувьд 2011-2012 оны хичээлийн жилд 3.9 хувь буюу хамгийн бага бусад хичээлийн жилд суралцагчийн тоо тогтмол өөрчлөлтгүй байна(Хүснэгт 3.22а). Ахисан түвшний оюутны нийт оюутанд эзлэх хувийн 20,7 .

Багш суралцагчийн харьцааг сүүлийн 5 жилээр харьцуулвал 2011-2012, 2012-2013, 2013-2014 оны хичээлийн жилд 1 багшид 17 оюутан, харин сүүлийн 2 жил 1 багшид 25 оюутан ноогдож байна. Энэ харьцаа сүүлийн 2 жил нэмэгдсэн нь багшийн тоо буурсантай холбоотой (Хүснэгт 3.22б).

Тус хичээлийн жилд Захирлын 2015 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/10 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан “Суралцагч шилжүүлэн суралцуулах журам”-ын дагуу шилжилтийн үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулсан. 2015-2016 оны хичээлийн жилд шилжин ирсэн суралцагчдын тоо бакалаврын хөтөлбөрт 320, магистрын хөтөлбөрт 7, докторын хөтөлбөрт 5 байгаань 2014-2015 оны хичээлийн жилтэй харьцуулахад 63 /бүх түвшинг хамруулаад/-аар нэмэгдсэн(Хүснэгт 3.23-3.24).

Төгсөлт

2015-2016 оны хичээлийн жилд бакалаврын хөтөлбөрийг эхний хагас жилд 1,094 оюутан төгсөхөөр төлөвлөж байснаас 52 хувь нь буюу 565, сүүлийн хагас жилд 2,929 оюутан төгсөхөөр төлөвлөж байснаас 83 хувь буюу 2,418 оюутан бакалаврын зэрэгтэй төгслөө. Төгсөгчдийн тоог нь өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 10 хувиар буурсан. Төгсөхөөр төлөвлөж байсан оюутнууд улирлын болон төгсөлтийн шалгалтанд хангалтгүй үнэлгээ авсан тул төгсөлт хойшилсон. Бакалаврын зэргээр төгсөгчдийн 90 хувь нь өдрөөр, 4 хувь нь оройгоор, үлдсэн 6 хувь нь эчнээгээр суралцаж төгссөн байна. Бакалаврын түвшний төгсөгчдийн голч дүн өмнөх жилийн голч дүн 2.8-тай ижил байв.

Төгсөгчдийн багц цагийн судалгаанд тухайн бүрэлдэхүүн сургуулийг өдөр, эчнээ, оройн хөтөлбөрийг төгссөн бакалаврын түвшний оюутнуудын судалсан багц цагийг дэлгэрэнгүйгээр харуулсан бөгөөд өмнө оны төгсөгчдийн багц цагийн судалгаатай харьцуулахад онц өөрчлөлт ороогүй байна (Хүснэгт 3.29)

Магистрын зэрэгтэй төгсөгчдийн тоо тус хичээлийн жилд 508 байгаа нь өмнөх хичээлийн жилээс 17 хувиар өссөн бөгөөд Бизнесийн сургуулийн санхүү, банк, даатгал, Шинжлэх ухааны сургуулийн улс төр судлал, сэтгэл судлал, Хууль зүйн сургуулийн эрх зүйн хөтөлбөрөөр хамгийн их суралцаж төгссөн байна. Магистрын зэрэгтэй төгсөгчдийн голч дүн МУИС-ийн хэмжээнд 3.5 байна. Магистрын төгсөгчдийг өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 2015-2016 оны хичээлийн жилд магистрын төгсөлт 17%-иар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь мэргэжлийн магистрхөтөлбөр нь мэргэжлийн дадлага хийж дадлагын тайлан бичиж хамгаалдаг болсон ба магистрантуудын хувьд хугацаандаа магистрын зэргээ хамгаалах боломж нөхцлийг бүрдүүлж өгч байгаатай холбоотой юм. 2014-2015 оны хичээлийн жилд магистрын төгсөлт хойшилсон тоо 117 байсан. Үүнийг энэ жилийнхтэй харьцуулахад 72 магистрант ба 62%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Докторын зэргээр төгсөгчдийн тоо нийт 27 байгаагийн 14 нь өдрийн, 13 нь эчнээ хөтөлбөрөөр сурч төгссөн(Хүснэгт 3.25-3.30). Энэ тоо өнгөрсөн хичээлийн жилээс 44,4 хувиар өссөн байна.

БҮЛЭГ 4. ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

Оюутны албанаас 2015-2016 оны хичээлийн жилд оюутны үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилготой “МУИС-ийн үйлчилгээний нэгдсэн стандарт”-ыг боловсруулан, МУИС-ийн Захирлын 2015 оны 5 сарын 20-ны А/33 дугаар тушаалаар, “Оюутны дотуур байрны журам”-ыг шинэчлэн боловсруулж 2016 оны 6 сарын 24-ны өдрийн А/187 тушаалаар батлуулсан.

2015-2016 оны хичээлийн жилд оюутны байранд нийт 1446 оюутан амьдарч байгаагаас 22.0% нь их засвар хийгдсэн оюутны 1 ба 3 дугаар байранд амьдарч байна. Энэ хичээлийн жилийн хувьд байранд орох хүсэлт гаргасан оюутнууд 100% хамрагдаж чадсан.

Оюутны зарим үйлчилгээг сайжруулах, цахимжуулах ажлын хүрээнд хийсэн бас нэг үйлчилгээ нь оюутны дотуур байрны бүртгэл, баталгаажуулалт, хуваарилалтыг цахим байдлаар шийдсэн нь оюутны эрэлт хэрэгцээнд нийцсэн, тэдэнд хүрэх үйлчилгээг хялбар, түргэн шуурхай зохион байгуулах сайн туршлага болж байна. Энэ үйлчилгээг цахимжуулснаар дараах үр дүн гарч байна. Үүнд:

- Оюутан амьдрах өрөө, давхар, байр, хамт амьдрах оюутнаа өөрөө сонгох
- Оюутан амьдрах өрөө, давхар, байр, хамт амьдрах оюутнаа өөрөө сонгох боломж бүрдүүлсэн нь оюутны хувьд чөлөөт сонголтыг санал болгосон шийдэл бөгөөд дотуур байрны хуваарилалттай холбоотой элдэв маргаан, бэрхшээл багассан
- Сонголтыг оюутанд олгосноор байр, өрөө хооронд шилжилт хөдөлгөөн багассан
- Дотуур байртай холбоотой захиргааны үйл ажиллагааны процесс, шат дамжлага эрс багасан систем дээрх оюутны мэдээлэлд тулгуурлан оюутнуудаас давхардсан мэдээлэл, бичиг баримт шаардахгүй болсон
- Магистр, докторын түвшний оюутнууд байранд амьдрах боломжтой болсон
- МУИС-ийн оюутны байгууллагын төлөөлөл дотуур байрны үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг бүрдүүлснээр дотуур байртай холбоотой аливаа зөрчлийг арилгахад оюутнуудын оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлсэн.

Сургалтыг журмын шинэчлэлтэй холбоотойгоор оюутны хөтөлбөр соёлохтой холбоотой мэргэжил сурталчлах өдөрлөгийг бүрэлдэхүү сургуулиудын сургалтын албадтай хамтран зохион байгууллаа. /Хавсралт 4.1/

Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд чадавхжуулах сургалт, семинаруудыг зохион байгуулсан. /Хавсралт 4.2/ Тухайлбал: Бизнесийн сургуулийн багш нартай хамтран 2015 оны 11 дүгээр сарын 27-оос 12 дугаар сарын 4 хүртэл, 4 дүгээр сарын 7-оос 4 сарын 14-ны хооронд “Оюутан суралцагчдыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэж чадавхжуулах вэ?”, “CV хэрхэн бичих вэ?”, “Ажлын ярилцлагад орох зөвлөмж”, “Дадлага яаж хийдэг вэ, интерншип гэж юу вэ” гэсэн үндсэн сэдвүүдээр бүрэлдэхүүн сургууль тус бүр дээр тодорхой хуваарийн дагуу хийсэн. 11 сарын сургалтад 300-гаад оюутан хамрагдсанаас 150 оюутнаас хөдөлмөр эрхлэлтийн талаар санал асуулга авсан.

Төгсөх курсын оюутнуудыг ажил олгогчтой холбох, туршлага судлах, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, дадлага хийх, төгсөөд ажиллах боломжоор хангах зорилгоор үндэсний томоохон ажил олгогч байгууллагуудтай танилцах аялалыг JCI Монголия ТББ-тай хамтран зохион байгуулсан ба энэхүү аялалын хүрээнд 2016 оны 4, 5 сард Монгол Ай Ди ХХК /мэдээлэл технологийн компани, “Шинэ эхлэл “ олон улсын лаборатори сургууль, Витафит үйлдвэр, Өгөөж ХХК, НВЦ ХХК-тай тус тус очиж танилцсан. Бизнесийн сургууль төгсөх ангийн оюутнуудад зориулсан танилцах

аялалыг Гааль Татварын Газар, ТЭСО корпорацийн Айсмарк ХХК, Милко ХХК тай 4-р сард тус тус зохион байгуулсан.

Голомт банктай хамтран Хөдөлмөр эрхлэлтийн Голомт-Оюутан 2016 өдөрлөг-уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад МУИС-ийн 2009 оны төгсөгч Голомт банкны Байгууллагын банкны газрын захирал Д.Бадрал, 2008 оны төгсөгч Ерөнхий аудитын хэлтсийн захирал Б.Баатар нар хүрэлцэн ирж, амжилтад хүрсэн туршлагаасаа хуваалцсан. Мөн Голомт банкны хүний нөөцийн ажилтан зөвлөгөө мэдээлэл өглөө. Мөн Голомт банктай хамтран 2016 оны 3 сарын 7-нд харилцагчийн өдөрлөгийг зохион байгуулж сургалтын тэтгэлэгт карт үнэ төлбөргүй нээсэн.

2016 оны 3 сараас Нийслэлийн Хөдөлмөрийн Газартай хамтран ажиллах гэрээ байгуулан бүрэлдэхүүн сургууль тус бүр дээр туслах ажилтан оюутанг шалгаруулан ажиллуулсан.

ОУХНУС-дээр "Өөрчлөлтийг чиглүүлэгч Төв" ТББ-иас их дээд сургууль төгсч байгаа оюутнуудад зориулж гаргасан гарын авлагын дагуу МУИС-ийн ОУХНУС-ийн 3-4 дүгээр ангийн оюутнуудад зориулан "Ирээдүйгээ төлөвлөхүй", Ажлын ертөнц рүү алхан орохуй- ажлын ярилцлагад хэрхэн бэлтгэх", "Ажилдаа эзэн болохуй" сэдэвт цуврал сургалт зохион байгуулсан. Уг сургалтад хамрагдсан 45 оюутанд 3 цуврал номыг гарын авлага болгон тараан өгсөн.

Бизнесийн сургууль WWW.OYUTAN-AJIL.MN вэбсайтын танилцуулга хийн, посторыг байнга байрлуулан ажиллаж байна.

Оюутны тэтгэлэгт хөтөлбөр, оюутан солилцоо

Тайлант онд МУИС-ийн 288 оюутан гадаад, дотоодын их, дээд сургууль, байгууллага, сангийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагджээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгт 6, МУИС-ийн нэрэмжит тэтгэлэгт 160, гадаадын их, дээд сургууль, сангийн тэтгэлэгт 111 оюутан хамрагдсан байна. /Хавсралт 4.3/

МУИС-ийн шилдэг оюутнуудын сурах, боловсрох, хөгжих үйлсэд бодитой хувь нэмэр оруулан тасралтгүй дэмжлэг үзүүлж ирсэн, гадаад, дотоодын 19 байгууллага, санд МУИС болон тэтгэлэг хүлээн авагч оюутнуудын зүгээс "Талархал илэрхийлэх ёслол"-ын үйл ажиллагааг 2015 оны 12 сарын 22-нд зохион байгуулав. Энэхүү арга хэмжээний үеэр Оюутны албанаас байгууллагуудын тэтгэлгийн танилцуулгыг хийж, тэтгэлэгт хамрагдсан оюутнууд өөрсдийн туршлагаас хуваалцсан нь тэтгэлэг олгогч, хандивлагч байгууллагуудыг урамшуулан, тэтгэлгийн хүрээг өргөжүүлэхэд ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Хамтын ажиллагааны гэрээ бүхий гадаадын их дээд сургуульд МУИС-ийн 22 оюутан оюутан солилцоогоор суралцжээ. Орон нутгийн оюутнуудыг төв сургууль дээр танхимын сургалтад суулгах, сурах арга барил, сургалтын үйл ажиллагаанд оролцуулж туршлага судлуулах, идэвхжүүлэх зорилготой дотоодын оюутан солилцоогоор Орхон, Завхан сургуулийн оюутнууд МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд дээр ирж, оюутны байгууллага, клубүүдтэй хамтарсан уулзалт хийж, харилцан туршлага солилцсон. /Хавсралт 4.4/

Зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээ

Оюутнуудын гадаад хэлний мэдлэг чадвараа дээшлүүлэх мотиваци бий болгох зорилгоор Гадаад хэлний төв, ИБАСТ-тэй хамтарч хэд хэдэн лекц, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. /Хавсралт 4.5/

- “Англи хэл сурах арга туршлагаас” сургалтыг 2 удаа зохион байгуулсан бөгөөд Социологи-Нийгмийн ажлын тэнхмийн багш доктор А.Батхишиг, Антропологи-Археологийн тэнхмийн багш Ж.Лхагвадэмчиг нар өөрсдийн англи хэл сурсан туршлагаас хаваалцсан.
- “Challenges for Students at NUM” /Open Discussion/ нээлттэй хэлэлцүүлэг зохиов.
- “Англи хэл дээр уншсан номын тухай” унших дадал болон ур чадварын талаар ярилцлага зохион байгуулж, ГХТ-ийн багш Л.Үүлэнсолонго, Х.Нуржан багш нар оролцож, IELTS болон TOEFL шалгалтын талаарх өөрсдийн туршлагаа хуваалцсан.

БСШУЯ-аас Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд оюутны багаас санаачилсан бүтээлч санал, санаачилгыг дэмжих төслийн тэтгэлэгт уралдаанд оролцож, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулсан. Энэ сургалтаар ШУС-ийн багш Доктор А.Батхишиг төсөлд оролцох сонирхолтой клубын гишүүд, оюутнуудад зөвлөгөө өгсөн. “Оюутны хөгжлийн жил”-ийн хүрээнд хийхээр төлөвлөсөн ажлыг их сургуулийн нийт багш, ажилтан, оюутан суралцагчдад мэдээлэх, тэдний оролцоог хангахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулав. Энэхүү арга хэмжээний үеэр Оюутны алба оюутнуудад зориулсан дараах үйлчилгээнүүдийг зохион байгуулсан.

- ЭМДаатгалын үйлчилгээ, мэдээлэл өгөх
- Витаминжуулалтын аян
- Оюутны үнэмлэхийг үнэгүй хэвлэж өгөх
- Төрийн сангийн зээл, Үндэсний тэтгэлэг, бусад тэтгэлгийн талаар мэдээлэл өгөх
- Оюутны албаны талаарх мэдээлэл өгөх Оюутан солилцооны талаар мэдээлэл өгөх
- Хямдралтай номын худалдаа
- Клубуудын танилцуулга

Бүрэлдэхүүн сургууль тус бүр дээр оюутан, зөвлөх багш нарын уулзалтыг зохион байгуулсан бөгөөд уулзалтын үеэр оюутны хөгжил хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал О.Мөнхбат Оюутны албаны үндсэн үйл ажиллагаа, чиглэлийн талаар танилцуулсан. Уулзалтаар оюутны сурах, хөгжих үйл ажиллагааг дэмжихэд үйлчилгээнд оролцогч талуудын чиг үүрэг, хамтын ажиллагааг боловсронгуй болгох, зөвлөх багшийн оролцоог идэвхжүүлэх талаар мэдээлэл хийж, санал бодлоо солилцсон. Зөвлөх багш нарын зүгээс оюутны нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, оюутны хөгжлийг дэмжих ажилд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаарх үнэтэй санал санаачилгыг гаргасан байна.

“Сонирхолтой номоо солилцоогоор-Хэрэгцээтэй номоо хэрэгцээгээрээ” өдөрлөг. Энэхүү өдөрлөг нь багш оюутнууд өөрсдийн хэрэглээнд байгаа илүү номыг бусадтай солилцох, өөрт хэрэгтэй номыг хямд үнээр болон үнэгүй авах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн юм. Өдөрлөгийн үеэр:

- МУИС-ийн Номын санд авах нэн шаардлагатай номын судалгаа авах
- МУИС-ийн номын санд 2014-2015 онд ирсэн шинэ номын танилцуулга
- “Шилдэг уншигч” шалгаруулах /5 сургууль тус бүрээс 1 оюутан/
- “Чөлөөт сонголттой номын уншлагын танхим ба оюутан бидний ёс суртахуун” гэсэн сэдвийн дор эссэ бичлэгийн тэмцээн
- Шилдэг эссэг сургуулийн болон номын сангийн вэб-д байршуулж уншигчдын

- хүртээл болгож дурсгалын зүйл гардуулах
- Актлагдсан хуучин номын худалдаа, бэлэглэх үйл ажиллагаа
- Ном солилцоо

зэрэг арга хэмжээнүүд болж, зохиолч Б.Ариунтуяагийн “Егөөтэй 99 тайлбар” шинэ номын танилцуулга хийв.

АСЕМ-ийн 11 дэх удаагийн дээд хэмжээний чуулга уулзалт болох гэж байгаатай холбогдон их дээд сургуулиудын оюутнуудыг чуулга уулзалтын бэлтгэл ажил, үйл ажиллагааны зохион байгуулалт зэрэгт туслах сайн дурын ажилд хамтран орохыг урьсан. Энэхүү сайн дурын хөдөлгөөнд хамрагдахыг сонирхсон, сайн дураар ажиллах сонирхолтой МУИС-ийн 170 гаруй оюутан залуусыг бүрэлдэхүүн сургуулийн мэргэжилтнүүдтэй хамтран бүртгэн зарыг орчуулан гаргах, бүртгэсэн оюутнуудын материалыг АСЕМ-ын ажлын алба руу явуулж ажиллууллаа.

Монгол улсын анхны хиймэл дагуулыг 2017 онд хөөргөх болсонтой холбогдуулж оюутнуудад болон нийгэм рүү чиглэсэн анхны хиймэл дагуулын ач холбогдол, зорилгыг тэдэнд ойлгуулж ухуулан сурталчлах үйл ажиллагаануудыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. Үүнд хиймэл дагуулын ач холбогдлын тухай лекц 3 удаа, МУИС-ийн Хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн, МУИС-ийн МБМ Шонхрууд болон Алянс Тех Харцагууд багуудын нөхөрсөг сагсан бөмбөгийн тэмцээн, МУИС-ийн Оюутны холбооны бүтэц бүрэлдэхүүн доторх нөхөрсөг Спорт өдөрлөг зохион байгуулж, Эх үрсийн баяраар худалдаа арилжаа хийж хүүхдүүдэд хиймэл дагуулаа сурталчиллаа.

Монголын Улаан Загалмайн Нийгэмлэгээс өвөлжилт хүндэрсэн, цагаан зудтай 18 аймгийн 98 сумдад мөнгөн болон эд зүйлсийн туслалцаа хүргэх ажлыг орон даяар эхлүүлэн хамтран ажиллахыг МУИС-ийн захиргаанд хүссэн билээ. Энэ хүсэлтийн дагуу Оюутны албанаас санаачлан оюутны байгууллага, клубүүдтэй хамтран хандивын аяныг бүрэлдэхүүн сургуулиудын захиргаа, тэнхим бүрээр зохион байгуулж, 03 дугаар сарын 17-ны өдөр албан ёсоор МУЗН-ийн хамт олонд 3,0 сая төгрөг хүлээлгэн өгсөн.

Оюутанд үзүүлсэн нийгмийн үйлчилгээ /Хавсралт 4.6/

СБД-ийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэргэжилтнүүдтэй хамтран МУИС-ийн гадаад оюутнуудад зориулан Монгол улсын ЭМД тогтолцооны талаар мэдээлэл хийж, энэ ажлын хүрээнд гадаад оюутанд нэгдсэн журмаар ЭМД-ын дэвтэр олгох ажлыг зохион байгуулж, гадаад оюутан ЭМД-тай гэрээ бүхий эмнэлгээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх, эмийн үнийн хөнгөлөлт эдлэх боломжтой болсон.

МУИС-ийн эмнэлэг ХӨСҮТөв, СБД-ийн ЭМН, Оюутны албатай хамтран Улаан бурхан өвчний вакцинжуулалтын аяныг зохион байгуулж, 5250 оюутныг хамруулсан. Оюутны эрүүл мэндийг дэмжих аяны хүрээнд оюутнуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 2015 оны 12-р сарын 28 ны өдөр АШУҮИС-ийн “Эрхэс” поликлиниктэй хамтран МУИС-ийн оюутны таван байранд хийлээ. HBsAg (Гепатит В вирус), Anti-HCV(Гепатит С вирус), H.Pylori (Ходоодны бактер), Glucosa (сахар), UA (шээсний шинжилгээ) гэсэн 7 төрлийн үзлэгт оюутнуудыг хамруулсан бөгөөд үзлэгт 5972 оюутан хамрагдсан.

Оюутны спорт, урлаг соёлын арга хэмжээ /Хавсралт 4.7-4.10/

“Оюутны Урлагийн Их Наадам 2016”-г Улаанбаатар чуулгын их танхимд амжилттай зохион байгуулсан ба энэхүү наадамд МУИС-ийн ОУХНУС, ХШУИС, БС, ШУС, Орхон сургуулийн 300 гаруй авьяаслаг оюутан залуус оролцож авхаалж самбаа, авьяас чадвараараа өрсөлдлөө.

Монгол болон гадаадын оюутнуудын мэндчилгээний өдөрлөгийг зохион байгуулсан бөгөөд өдөрлөгийн үеэр 180 гаруй оюутан өөрсдийн орны дуу, бүжгээр мэндчиллээ.

МУИС-ийн индэр хөтөлбөр. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Г.Занданшатар, Д.Ганбат, Майкл Гуриевич, БНХАУ-аас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Шин Хаймин нар илтгэл тавьж, оюутнууд, багш судлаачидтай санал бодлоо солилцлоо. Тайлбар:

Оюутны албанаас 2015-2016 оны хичээлийн жилийн хаврын улиралд хэрэгжүүлэх, оюутан залууст үр өгөөжтэй, хүртээмжтэй, оюутны өөрийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээг үзүүлэх замаар оюутны хөгжлийг дэмжих, тэднийг нийгмийн идэвхтэй гишүүн болгон хөгжүүлэхэд оюутны байгууллага, клубын оролцоог хангахад чиглэсэн төслийн шалгаруулалт явуулсан. Төсөл шалгаруулахын өмнө бичил төсөл, хөтөлбөр боловсруулахад зориулсан зөвлөмжийг оюутны клубүүд, оюутнуудад хүргэн, МУИС-ийн оюутны байгууллага, клубүүд хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтад бэлтгэх талаар төслийн танилцуулга уулзалтыг зохион байгуулж, Оюутны хөгжил, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал О.Мөнхбат клубүүдийг төлөөлөн ирсэн оюутнуудад төсөл, хөтөлбөр хэрхэн боловсруулах талаар зөвлөгөө өгсөн. 2015-2016 оны оны хичээлийн жилд Оюутны албанаас хэрэгжүүлэх төслийн уралдаанд оюутны 22 клуб шалгарч санхүүжилт авахаар боллоо. /Хавсралт 4.11/

2015-2016 оны хичээлийн жилд “Оюутны хөгжлийг дэмжих” үйл ажиллагааны хүрээнд МУИС-ийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй клубүүдэд хичээлийн бус цагаар бүрэлдэхүүн сургуулийн анги танхимыг клубын зориулалтаар ашиглах боломжийг олгосон. Энэ арга хэмжээний дагуу оюутны 24 клуб үйл ажиллагаагаа тогтмол явуулах боломжоор хангагдсан болно. /хавсралт 4.12 /

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас Азийн Хөгжлийн Банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй Дээд боловсролын шинэчлэлийн төсөл (ДБШТ)-ийн хүрээнд их, дээд сургуулийн оюутнуудын дунд төслийн тэтгэлэгт уралдаанд 9 төсөл шалгарч батламжаа гардан авсан.

Шалгарсан төслүүд:

№	Төслийн нэр	Төслийн чиглэл ¹	Оюутны багийн ахлагчийн нэр	Сургууль	Төсөв /төгрөг/
1	Green mind 2	Т.2	М.Оюунгэрэл	ХШИУС	3 000 000
2	Био-Ирээдүй	Т.1	Г.Дариймаа	ШУС-БУС	3 000 000
3	Таатай орчин-Таны ирээдүй	Т.2	Б.Оюун-Эрдэнэ	ШУС-БС	3 000 000
4	Миний сонголт-Миний ирээдүй	Т.1	Э.Лхам-Осоржин	ШУС-НУС	2 035 500
5	Оюутны хөнгөлт	Т.5	Я.Энхзул	ШУС-БУС	3 000 000
6	Оюутны дуу хоолой /Нийгмийн чадварыг инженер технологийн	Т.3	Ч.Мөнхдэлгэр	ХШУИС	2 880 800

	мэдлэгтэй хослуулах нь/				
7	Сонсдог ном	Т.2	И.Халиунаа	ШУС-БУС	3 000 000
8	Green mind-2	Т.3	Т.Цэнд-Аюуш	ХШУИС	3 000 000
9	Эрүүл монгол оюутан-Унадаг дугуйтай МУИС	Т.1	Н.Бямбадорж	ХШУИС	3 000 000
Нийт төсөв					25 916 300

БҮЛЭГ 5. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

2015-2016 оны хичээлийн жилд Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс нь гадаад хамтын ажиллагааг бодитой хөгжүүлэх хүрээнд хамтын ажиллагааны гэрээ байгуулах, гадаадын зочид, төлөөлөгчдийн айлчлалыг захиргааны түвшинд зохион байгуулж, МУИС-ийг гадаадад сурталчлах замаар ажиллалаа.

Шинээр байгуулсан болон сунгасан гэрээ

2015-2016 оны хичээлийн жилд 9 орны 18 их, дээд сургууль, байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ шинээр байгуулсан нь 2014-2015 онд байгуулсан гэрээний тоо (9)-той харьцуулахад 2 дахин нэмэгдсэн байна. Харин 2 орны 3 их, дээд сургуультай байгуулсан гэрээний хугацааг сунгасан бөгөөд хугацаа сунгасан гэрээний тоог өнгөрсөн онтой харьцуулахад 4-өөр багассан байна. /Хавсралт 5.1/

Шинээр гэрээ байгуулахдаа гадаад харилцаа, хамтын ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, профессор болон сургууль, тэнхим хооронд хэрэгжиж байгаа бодит хамтын ажиллагаан дээр үндэслэн “Хамтын ажиллагааны гэрээ байгуулах журмыг” баримталж ажилласан. Шинээр гэрээ байгуулах болон хугацааг нь сунгах гэрээний төслийг илүү тодорхой, бодитой биелэх үндэслэлийг харгалзан бэлтгэж, захиргааны зөвлөлийн гишүүдэд танилцуулан, гэрээ байгуулагдсан тухай бүрт мэдээллийг МУИС-ийн вэб хуудсанд байршуулж байв.

Бүрэлдэхүүн сургуулиудын хэмжээнд 24 орны 37 их, дээд сургууль, байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийг шинээр байгуулсан болон сунгасан байна. /Хавсралт 5.2/

МУИС-ийн салбар сургуулиудын удирдлагууд хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр, санамж бичиг байгуулах тал дээр ГХХАХ-тэй журмын дагуу хамтран ажиллаж, санал солилцох тал дээр идэвх нэмэгдсэн нь сайшаалтай.

Мөн ректоратын хурлын шийдвэрийн талаарх болон хамтын ажиллагааны гэрээ байгуулагдсан талаарх мэдээлэл МУИС-ийн вэбсайт дээр тухай бүрд байршуулдаг болсон нь гадаад хамтын ажиллагааны гэрээ болон хамтын ажиллагааны талаар мэдээллийг МУИС-ийн багш, судлаач, оюутнуудад түргэн шуурхай хүргэдэг боллоо.

Хамтын ажиллагааны гэрээг байгуулсанаар шууд үр дүнд хүрнэ гэсэн үг биш бөгөөд гэрээний хэрэгжилтийг хангах үүднээс ГХХАХ болон салбар сургууль хоорондын уялдаа холбоог илүү сайжруулах шаардлагатай байна.

Хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, санамж бичиг байгуулахад тухайн баримт бичгийн хэрэгжилтийг хангах албан тушаалтныг томилон гэрээнд тусгаж өгөх нь илүү үр дүнтэй байх магадлалтай. МУИС-ийн гадаад болон дотоод хамтын ажиллагааны гэрээ хэлцэл болон бусад үйл ажиллагааны талаар мэдээллийн нэгдсэн талбар бий болгох хэрэгцээ байгаа бөгөөд энэхүү нэгдсэн мэдээллийн сангийн ач холбогдол нь гадаад арга хэмжээний талаар мэдээлэл нийтэд тэгш хүрэх боломжийг бий болгоно.

Гадаад томилолт, айлчлал

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс үйл ажиллагааныхаа хүрээнд захиргааны гадаад томилолтын төлөвлөгөөг гаргаж, зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.

Тайлант онд МУИС-ийн захиргаанаас давхардсан тоогоор 27 удирдах болон захиргааны ажилтан гадаадад албан томилолтоор ажилласан бөгөөд томилолтын зардалд 13,6 сая төгрөг, 9900 ам доллар зарцуулсан байна. /Хавсралт 5.3/

Цаашид “МУИС-ийн гадаад томилолтын зардлыг төлөвлөх, санхүүжүүлэх,

тайлагнах” журмын дагуу захиргааны удирдлага болон харьяа сургуулиудын захирлуудын гадаад томилолтын тайланг авч нэгтгэх ажлыг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсээс цаг тухай бүрт нь зохион байгуулах шаардлагатай байна. Мөн захирал, дэд захирлуудын гадаад, дотоод томилолтыг урьдчилан төлөвлөж холбогдох зардлыг гадаад арга хэмжээний төсөвт тодорхой тусгах нь үр ашиггүй зардал гаргах эрсдлийг бууруулах сайн талтай.

Тайлант хугацаанд сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээ байгуулах, сунгах, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, багш, оюутан солилцоог бий болгох, нэмэгдүүлэх зорилгоор МУИС-д гадаадын 59 их, дээд сургууль, байгууллагын 198 зочин төлөөлөгч айлчилсан байна. /Хавсралт 5.4/

МУИС-тай хамтын ажиллагаа эхлүүлэх, хамтын ажиллагааг эрчимжүүлэх болон тодорхой салбарт төсөл судалгаа хэрэгжүүлэх саналтай гадаадын их дээд сургууль, байгууллагын тоо өсч байгаа нь сайшаалтай. Үүнтэй уялдуулан гадаадын их дээд сургуулиудаас ирсэн зочин төлөөлөгчдийн айлчлалыг зохион байгуулах, тэдэнтэй хийсэн уулзалт, яриаг ажил хэрэг болгох тал дээр ГХХАХ МУИС-ийн холбогдох харьяа сургуулиуд болон багш, судлаачидтай нягт хамтран ажиллах нь илүү үр дүнтэй байх болно.

Олон улсын төсөл, хөтөлбөрүүд

1. ХБНГУ-ын Халлегийн их сургууль, БНСУ-ын Ханбатын их сургуультай хамтарсан DIES төсөл

2014 оноос Монгол Улсын Их Сургууль, ХБНГУ-ын Халлегийн Их Сургууль, БНСУ-ын Ханбатын Их Сургууль хамтран Германы Эрдмийн Солилцооны Албаны (DAAD) санхүүжилтээр хэрэгжиж буй DIES төслийн хүрээнд Ханбатын их сургуульд дадлагажуулахаар ШУС-ийн Биологийн тэнхмийн профессор Б.Очирхуяг Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтсийн мэргэжилтэн Б.Лхагвасүрэн нарыг 2016 оны 05 дугаар сарын 01-16-ны өдрүүдэд, ЗХШҮА-ны ахлах мэргэжилтэн Т.Амартунгалаг, МТА-ны мэргэжилтэн Б.Оюунмин нар 2016 оны 05 дугаар сарын 01-нээс 28-ны өдрүүдэд ажиллууллаа.

Төслийн гишүүдийн хамтарсан 3 дахь удаагийн уулзалт хэлэлцүүлэг Улаанбаатар хотноо 2016 оны 05 дугаар сарын дүгээр сарын 29-ний өдрөөс 06 дугаар сарын 03-ний өдрүүдэд амжилттай явагдлаа.

Уулзалт, семинарын хүрээнд 4 дэд зорилт бүрээр МУИС-д хэрэгжиж буй холбоотой төслүүдийн танилцуулга, мөн бусад их сургуулиудад хэрэгжиж буй ажлуудын талаар хэлэлцүүлэг явуулсан бөгөөд тухайлбал 1-р зорилтын хувьд МУИС-ийн 2016-2024 он хүртэл хэрэгжүүлэх стратегийн төлөвлөгөөг танилцуулж, стратегийн зорилтын талаар чанарын баталгаажилтын асуудал (quality assurance) их сургуулийн дотоод процесстэй (сургалт) хэрхэн холбогддог талаар хэлэлцүүлэг, сургалт семинар, 2 дугаар дэд зорилтын хүрээнд Халлегийн их сургуулийн интерпренершип, инновацийн соёл, германы их дээд сургуулиудын стартап лаборатори, компаниудын үйл ажиллагааны бодлогын зохицуулалт болон санхүүжилтийн талаар болон Ханбатын их сургуулийн технологи дамжуулах төвийн үйл ажиллагаа, БНСУ-ын аж үйлдвэр, их сургуулийн хоорондын хамтын ажиллагааны талаар танилцуулга, семинар, 3 дугаар дэд зорилтын хүрээнд МУИС-ийн магистр, докторын журмын талаар танилцуулах, холбогдох санал, зөвлөмж авах, СНА-ны оролцож буй төслийн нэг хэсэгтэй уялдуулан холбох, тухайн төслийн гишүүдийг Халлегийн их сургуулийн төлөөлөгчидтэй санал солилцох уулзалт, 4 дүгээр дэд зорилтын хүрээнд өмнөх 2 жилийн үйл ажиллагаагаа дүгнэж, цахим сургалт явуулах, 2 сургуулийн дотоод сүлжээний дэд бүтцийн талаар санал тус тус

солилцож, Ханбатын их сургуульд дадлага хийсэн тайлангаа төслийн гишүүдэд тавьсан.

2. Эрасмус Мундус ИМПАКТ хөтөлбөр

МУИС-д хэрэгждэг Европын Холбооны санхүүжилттэй Эрасмус Мундус багш, ажилтан, оюутан солилцооны AREAS, SAT, GATE хөтөлбөрүүдийн хугацаа дууссан бөгөөд 2018 он хүртэл үргэлжлэх ИМПАКТ хөтөлбөр одоогийн байдлаар хэрэгжиж байна. ИМПАКТ хөтөлбөрийн дагуу 2015-2016 оны хичээлийн жилд өнгөрсөн хичээлийн жилийн адил 8 багш, оюутан Европын их дээд, сургуулиудад бүтэн тэтгэлэгээр суралцах боломжтой болсон.

Хүснэгт 5.6

№	Нэр	Харъяа сургууль	Хамрагдсан түвшин, хугацаа, сургуулийн нэр, улс
1	И. Бямбабаатар	ШУС-ийн Антропологи, Археологийн докторант	Докторын солилцоо (10 сар) Портогийн их сургууль, Португал
2	З. Дөл	ОУХНУС-ийн оюутан	Бакалаврын солилцоо (10 сар) Гентийн их сургууль, Бельги
3	А. Дулмаа	ШУС-ийн Физикийн тэнхмийн багш	Докторын солилцоо(10 сар) Гентийн их сургууль, Бельги
4	Н. Энхжаргал	ШУС-ийн Физикийн тэнхмийн багш	Докторын солилцоо (10 сар) Гентийн их сургууль, Бельги
5	Б. Нарантуяа	ШУС-ийн докторант	Докторын солилцоо(10 сар) Гентийн их сургууль, Бельги
6	Ч.Тамир	ШУС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхмийн багш	Докторын солилцоо(10 сар) Портогийн их сургууль, Португал
7	А.Тэнүүнжаргал	ШУС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим, магистрант	Магистрын хөтөлбөр (10 сар) Руаны их сургууль, БНФУ
8	О.Юмжирдулам	БС-ийн магистрант	Магистрын солилцоо(10 сар) Чечиний их сургууль, БНПУ

3. Их дээд сургуулийн чадамжийг дээшлүүлэх Эрасмус+ ТАСТИС төсөл

БНЧУ-ын Мазарикийн их сургуулийн гол зохицуулагчаар, МУИС-ийн хамтран зохицуулагчаар оролцдог 2018 он хүртэл хэрэгжих Эрасмус+ ТАСТИС төсөл 2 дахь жилдээ үргэлжлэн хэрэгжиж байгаа бөгөөд төслийн зорилт, зорилгыг биелүүлэх зорилгоор 4 ажлын хэсэг байгуулагдсан.

1 дүгээр ажлын хэсэг төслийн гишүүн сургуулиудын удирдлагын бүтэц, зохион байгуулалт, шийдвэр гаргадаг тогтолцоо, шийдвэрийг гаргахад оролцдог гишүүдийн эрх үүрэг, захиргааны менежментийн тогтолцоо зэргийг судлах зорилгоор санал асуулга бэлдэж гишүүн сургуулиудад түгээсэн. Энэ санал асуулга нь төслийн roadmap болох бөгөөд үүн дээр үндэслэн гишүүн сургуулиудын менежментийг захиргааны аль хэлтэс, албанд сайжруулах, хүний нөөцийг хэрхэн чадавхжуулах талаар европын экспертүүд азийн гишүүн сургуулиудад зочлон ирж сургалт явуулах юм. Төслийн гишүүдийн 2 дахь уулзалт Камбожд явагдана.

Олон улсын хөтөлбөрийн талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Эрасмус Мундус, Евроази-ЮНИНЕТ хөтөлбөрүүд нь МУИС дээр хэрэгжээд харьцангуй олон жил дараалан явагдаж байгаа бөгөөд багш, оюутнуудын хувьд танил бөгөөд багш, оюутан солилцооны хөтөлбөрөөс гадна эдгээр хөтөлбөрүүдийн хүрээнд

бий болсон түншлэлийн хүрээнд өөр бусад төрлийн хөтөлбөр хэрэгжүүлэх хамтын ажиллагааны өөр бусад чиглэлүүд хөгжих боломжтой бөгөөд үүний тод жишээ нь их сургуулийн менежментэд анализ хийж сайжруулах боломжийг нээн илэрхийлэх зорилготой Эрасмус Мундус TACTIC хөтөлбөр юм. Түүнчлэн DIES төсөл нь мөн их сургуулийн менежментийг сайжруулахтай холбоотой тул эдгээр хөтөлбөрүүдийн үр дүнг МУИС-ийн менежментийг сайжруулах нэгдсэн зохион байгуулалттай үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулах нь зүйтэй.

ГХХАХ-ээс зохион байгуулсан арга хэмжээний хураангуй

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс гадаадын их дээд сургууль, МУИС-ийн салбар сургуулийн багш, тэнхмүүд болон монгол дахь ЭСЯ, олон улсын байгууллагуудтай хамтран оюутан багш нарт зориулсан арга хэмжээг хамтран зохион байгууллаа. /Хавсралт 5.5/ Цаашид гадаад, дотоод хамтын үйл ажиллагааны хүрээнд олон төрөлт хамтын ажиллагааг багш, оюутнуудын эрэлт хэрэгцээг харгалзан сонирхолтой бүтээлч байдлаар явуулбал илүү үр дүнтэй бөгөөд хамрагдах хүрээг бодитой хамрах боломжтой.

Гадаадын багш, мэргэжилтэн, судлаачид

МУИС-нь өнгөрсөн хичээлийн жилүүдэд дэлхийн түвшний, судалгааны их сургууль болох зорилт тавьж, судалгааны ажлын хамрах хүрээг өргөжүүлж, түвшинг дэлхийн жишигт хүргэх, сургах ба суралцах үйл явцыг дэлхийн түвшинтэй нийцүүлэх зорилгоор өндөр хөгжилтэй орнуудын их, дээд сургуулиудаас чадварлаг багш, судлаачдыг урин авч ирж ажиллуулсаар байгаа билээ.Өнгөрсөн хичээлийн жилд гадаадын томоохон их, дээд сургуулиудаас нийт 31 мэргэжилтэн багш МУИС-ийн урилгаар, хувийн хүсэлтээр болон ХБНГУ-ын ДААД, Турк улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яам, БНПУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу ирж ажилласан байна. Эдгээрийг улсаар нь авч үзвэл: ИБУИНВУ-1, Франц-1, ХБНГУ-4, Япон-8, БНСУ-6, БНПУ-1, БНХАУ-8, Турк-1, Этопи-1 байна.

2015-2016 оны хичээлийн жилд МУИС-д 10 орны 38 судлаач ирж урт, богино хугацааны судалгааны ажил хийсэн бөгөөд эдгээр нь АНУ-5, ИБУИНВУ-2, БНХАУ-7, БНЧУ-13, ХБНГУ-3, Франц-1, Австрали-3, Швед-1, Унгар-1, Польш- 2 иргэн байна. Тэднийг судалгааны чиглэлээр нь авч үзвэл: Монгол судлал-6, Монгол хэл соёл -6, Археологи-антропологи, соёлын антропологи-20, Экологи-1, Шашин судлал-1, Түүх-1, Хүрээлэн буй орчин-1,Газар зүй-1, Олон улсын харилцаа-1 байна.

Дотоод хамтын ажиллагаа

МУИС нь Их сургууль-аж үйлдвэрийн хамтын ажиллагааг дэмжсээр ирсэн бөгөөд улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд өөрсдийн зохих хувь нэмрийг оруулсаар ирсэн.

Төрийн өмчийн их их сургууль, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааг эрчимжүүлэх, дээд боловсролын байгууллагын хөгжилд үлгэр дууриал болохуйц үйл ажиллагааг хэрэгжүүлэх, суурь шинжлэх ухааны салбаруудын судалгаа, сургалтын орчин нөхцлийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, МУИС-ийн тэргүүлэх салбаруудыг дэмжих зорилгоор Чингис империал клубтэй 2015 оны 08 дугаар сарын 26-нд хамтран ажиллах гэрээг үзэглэсэн.

Мөн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн (ШШҮХ)-тэй хамтран ажиллах гэрээг байгуулсан ба энэ гэрээний хүрээнд Шинжлэх ухаан , технологи, Хууль сахиулах байгууллагатай холбоотой хууль тогтоомж, бодлогын чанартай баримт бичиг боловсруулахад талуудын Эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, судлаачдын

багийг оролцуулан хамтран боловсруулах; хамтарсан төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх; ШШҮХ-гийн боловсруулсан төсөл, хөтөлбөрийг МУИС-ийг түшиглэн турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх; МУИС-ийн боловсруулсан бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх; хамтарсан эрдэм шинжилгээний бага хурал, уулзалт, ярилцлагыг зохион байгуулах; албан хаагчдыг сургах; харилцан тус тусын лабораториудад техник, тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлэх г.м олон чиглэлээр хамтран ажиллахар тохирсон.

Түүнчлэн Күнзийн институттэй хамтын ажиллагааны гэрээг шинэчлэн байгуулж Монголын хятад хэлний багш нарыг давтан сургах, мэргэшүүлэх, МУИС-ийн хятад хэлний салбарын сургалтыг бүх талаар дэмжин багшлах мэргэжилтэн болон сурах бичгээр хангах, сургалтын орчинг сайжруулах, шаардлагатай судалгааны төслийг санхүүжүүлэх, Шандуны их сургуультай хамтарсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтарсан эрдэм шинжилгээний хурал, хэл соёлын уралдаан тэмцээнийг зохион байгуулахаар болсон. Күнзийн институт нь МУИС-ийн сургалтын орчин, нөхцлийг сайжруулахад жил бүр санхүүгийн дэмжлэг үзүүлж ирсэн.

Үүнээс гадна Солонгосын хөрөнгө оруулалттай E-Mart, Скай Хайпермаркет ХХК, Монгол Улаанбаатар соёлын төвтэй хамтран ажиллахаар болж тэд МУИС-д 50 мянган ам. долларын өртөг бүхий орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон “E-mart Foreign language center”-ийг иж бүрнээр тохижуулан байгуулж өгсөн.

МУИС, “Монос” группийн хооронд судалгаа-сургалт-үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх чиглэлээр үйлдвэрлэлд нэвтрүүлсэн “Зуу наслаарай” – ургамлын цай болон “Есөн Од фууд Интернэшнл” ХХК-тай хамтран МУИС брэндийн “Алтан Говь” шоколадыг үйлдвэрлэн гадаад, дотоодын зочдын гарын бэлгэнд нийлүүлж байна.

Түүнээс гадна Premier–Туушин зочид буудал, “Дун Өргөө” ХХК-ний Өргөө зочид буудал, “Эдмаркет” ХХК, “Сэлэнгэпресс” ХХК, “Есөн Од фууд Интернэшнл” ХХК, “Номадс Резиденс” ХХК-ний “Hotel nine” зочид буудал, Пума-Империал” ХХК, зэрэг үйлчилгээний байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулснаар үйлчилгээний төлбөрөөс тодорхой хэмжээний хөнгөлөлт эдлэх боломжтой болсон.

Зуны сургалт

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсээс Монгол улсаа сурталчлан таниулах, монгол хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэх, МУИС-ыг сурталчлах зорилгоор жил бүр уламжлал болгон “Зуны сургалт”-ыг зохион байгуулж ирсэн бөгөөд 2015-2016 оны хичээлийн жилийн зуны сургалтыг 2016 оны 06 дугаар сарын 22-ноос 2016 оны 07 дугаар сарын 14-ны хооронд 3 долоо хоногийн хугацаагаар зохион явууллаа. Уг сургалт нь Монгол хэл соёл, Археологи-антропологи гэсэн 2 чиглэлээр явагдсан ба сургалтанд Макао улсын 3 оюутан, Сингапур улсын 4 оюутан, Тайван улсын 2 оюутан, АНУ-ын 1 оюутан, Голланд улсын 2 оюутан тус тус оролцсон. Зуны сургалтын сурталчилгааг сургуулийн вэб сайт, сургуулийн танилцуулга болон албаныхаа гаднах самбараар мөн хамтран ажилладаг гадаадын их сургууль, байгууллагууд руу электрон шуудангаар явуулах г.м олон хэлбэрийг ашиглан явуулсан. Монгол хэл- соёлын сургалт УБ-Тэрэлж-Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум–Тэрэлж-УБ; Археологи-антропологиин сургалт УБ-Сүхбаатар аймаг-Түвшинширээ- Дэлгэрхаан уул- УБ гэсэн чиглэлээр зохион байгуулагдсан.

“Монгол хэл-соёл”-ын сургалт Улаанбаатар хоттой танилцах, Байгалийн цогцолбор газарт явуулах монгол хэлний эрчимжүүлсэн сургалт, Монгол наадам, малчин айлд байрлаж монгол ахуйтай танилцах гэсэн үндсэн 4 хэсгээс бүрдсэн ба Улаанбаатар хот, Тэрэлж, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын нутагт малчин айлд

зохион байгуулагдсан. Монгол хэлний эрчимжүүлсэн сургалт нь байгаль дээр болон монгол гэрт дүрэм, бичгийн хэл, үгсийн сан, харилцан яриа, орон нутаг судлал гэсэн агуулгатайгаар явагдсан. Мөн сургалтанд оролцогсод монгол орны түүх, соёл, нүүдэлчин ардын ахуй амьдрал, зан заншил, байгалийн үзэсгэлэнт газруудтай танилцсан. Монгол хэлний хичээлийг ШУС-ийн ХУС-ын Монгол хэлний тэнхимийн багш Б.Баяртуул явуулсан.

Археологи антропологиин зуны сургалтын гол хэсэг буюу “Хээрийн малтлага-судалгаа”-ны ажил Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын орчимд явагдсан. Сургалтыг ШУС-ийн ХУС-ын Археологи антропологиин тэнхимийн эрхлэгч доктор Ц.Цэцэгжаргал удирдан явуулсан. Сургалт нь оролцогсод онол, практикийн мэдлэг олгохоос гадна малтлагад биечлэн оролцох боломж олгодог. Мөн түүнчлэн тухайн орон нутгийн малчин айлуудад зочлон, монгол ахуй амьдралтай танилцах, судалгаанд оролцож буй монгол оюутнуудтай ойртож танилцах, монгол хэл сурах зэргээр цагийг үр ашигтай, сонирхолтой өнгөрүүлэх боломж бий болгодог.

Дүгнэлт

Өнөөгийн байдлаар Монгол Улсын Их Сургууль гадаадын 32 орны 260 орчим их дээд сургуулиудтай сургууль хоорондын хамтын ажиллагааны ерөнхий гэрээтэй ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд МУИС-тай хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх бодит хамтын ажиллагаа эхлүүлэх, хамтарсан төсөлд оролцох, судалгаа явуулах, урт болон богино хугацааны багш, оюутан солилцоо явуулах, хамтарсан болон давхар зэргийн хөтөлбөрүүд явуулах санал цаашид нэмэгдэх хандлага байна.

Гадаад хамтын ажиллагааны гэрээний ихэнх хувийг буюу 60 гаруй хувийг Азийн их дээд сургуулиудтай байгуулсан гэрээ эзэлж байна.

Шинээр батлагдсан 2016-2024 стратегийн төлөвлөгөөний дагуу ГХХАХ гадаадын их дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг бий болгох, гадаадын шилдэг эрдэмтэн багш нарыг урьж ажиллуулах, дэлхийн шилдэг их дээд сургуулиудтай хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэх, салбар хоорондын болон, профессор хоорондын бодит хамтын ажиллагаа, хамтарсан судалгаа төсөл эхлүүлэх болон үргэлжлүүлэхэд хувь нэмрээ оруулан ажиллах болно.

БҮЛЭГ 6 САНХҮҮ ЭДИЙН ЗАСАГ, МАТЕРИАЛЛАГ БААЗЫН БЭХЖИЛТ

6.1 Санхүү, эдийн засаг

2016 оны төсвийг Төсвийн тухай хууль, МУИС-ийн дүрэм, холбогдох дүрэм, журмуудад нийцүүлэн МУИС-ийн стратегийн төлөвлөгөөний дунд хугацааны бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаж батлагдсан хөтөлбөр арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх зарчмыг баримтлан төлөвлөж батлуулан, хэрэгжүүллээ.

МУИС-ийн 2015-2016 оны хичээлийн жилийн эрдэм шинжилгээ, сургалт, аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн стандарт, батлагдсан журмын дагуу бүрэлдэхүүний 23 нэгжийн нэгтгэсэн дүнгээр тайлагнаж байна.

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд тус сургуулийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг “Акпар-Аудит” компанийн ахлах аудитор Ж.Амаржаргалаар удирдуулсан аудитын баг хийж хэрэгжүүллээ.

Аудитаас “МУИС-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна” гэсэн **зөрчилгүй санал дүгнэлт** ирүүлсэн.

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, шилэн дансны нэгдсэн /www.shilendans.gov.mn/ цахим хуудсанд 2015 оны 2015 онд МУИС-ийн нэгдсэн болон, бүрэлдэхүүний 20 нэгжийн мэдээлийг журамд заасны дагуу оруулсан. Мөн өөрийн сургуулийн /www.num.edu.mn/ цахим хуудсанд “Шилэн данс” цэс шинээр нээн мэдээллийг оруулах, цэсийг шинэчлэн сайжруулах ажлыг хийлээ. Шилэн дансны мэдээллийг нэгжүүдийн самбараар цаасаар мэдээлж байна.

2016 оны эхнээс шилэн дансны нэгдсэн /www.shilendans.gov.mn/ цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбоотой тус сургуулийн бүрэлдэхүүний нэгж бүр тусдаа эрхтэйгээр журамд заасан мэдээллийг хуулийн хугацаанд /7 хоног, сар, улирал, хагас жил, бүтэн жил/ оруулж мэдээлж байна.

“Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай” хууль, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой Засгийн газрын 348 тоот тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын А/102 тоот “Хуулийн хэрэгжилтийг хангах тухай” тушаалын дагуу МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн нийт багш, ажилтан нарт мэдээллийг хүргэж, сурталчилж ажилласан ба хуулийн хугацаанд 337 багш, ажилтан 46,8 сая.төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн төлөлт хийлгэсэн байна. Эдгээрийн 154 багш, ажилтан нар нь 23,7 сая.төгрөг хувиараа төлсөн байна.

2014-2015 оны хичээлийн жилд эхлүүлсэн СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ болох зорилгыг 2015-2016 оны хичээлийн жилд үргэлжлүүлэн үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийг дэмжих хөрөнгө санхүүжилтийг нэмэгдүүлэх, зардлыг санхүүжүүлэх, судалгаа, сургалтын лабораторийн хөрөнгө оруулалтыг татах,

нээлттэй судалгааны лабораториудыг тохижуулах, нэмж байгуулах, хөтөлбөрийн шинэчлэлийн ажлуудыг санхүүжүүлэх, мэдээллийн технологийн орчныг сайжруулах, санхүүгийн бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэх, шинэ бүтэц зохион байгуулалтын дагуу бүрэлдэхүүний сургууль, нэгжийн байр тасалгааг засах, тохижуулах, нүүлгэн шилжүүлэх, багш ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлуудыг хэрэгжүүлж ажиллалаа.

Тайлант хугацаанд төсвийн зардлыг хэтрүүлэхгүй зарцуулах, орлого бүрэн төвлөрүүлээгүй хэсгийн зардлыг болон төсөвт тусгагдаагүй зардлыг санхүүжүүлэхгүй байх, шаардлагагүй зардлыг хязгаарлах, тэвчих, сар бүрийн мөнгөний урсгалыг хянаж ажиллах удирдамж, чиглэл өгч ажилласанаар багш, ажилтны цалин, цагийн хөлс, илүү цагийн хөлс, сургалтын болон бусад төлөвлөгдсөн зардлуудыг цаг хугацаанд нь санхүүжүүлж ирсэн ба бүрэлдэхүүний сургуулиуд тайлант жилийн орлогоороо зардлаа бүрэн санхүүжүүлэх зорилгоо хэрэгжүүлж ажиллалаа.

Тайлангийн хугацаанд МУИС-ийн бүтцийн Улаанбаатар сургууль нь Засгийн Газрын 2015 оны 358 дугаар тогтоол, ТӨХ-ний 2015 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн 3/3494 тоот зөвшөөрлөөр МУИС-ийн бүтцээс салсан ба нийт 3,646.7 сая төгрөгийн хичээлийн байр, эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүгийн тайлангаас Эдийн засгийн хүрээлэнг МУИС-ийн нэгдсэн тайланд нэгтгэх ажлыг зохион байгууллаа.

Тус сургууль 2015-2016 оны хичээлийн жилд 46,456.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 46,727.7 сая төгрөгийг сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, аж ахуйн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна. Тайлант хугацааны нийт орлого өмнөх тайлангийн хугацааны орлогоос 3,101.0 сая төгрөгөөр буюу 7.2 хувиар өссөн байна. Үүнд туслах үйл ажиллагааны орлого 990.1 сая төгрөг буюу 15.4 хувиар, сургалтын төлбөрийн орлого 4,583.7 сая төгрөг буюу 14.1 хувиар өссөн, улсын төсвийн санхүүжилт 2,472.7 сая төгрөг буюу 54.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант хугацааны орлогод эзлэх зардлын гүйцэтгэл 100.6 хувьтай байгаа ба, тайлант хугацааны зардал орлогоос давсан нь номын сангийн барилгын санхүүжилттэй холбоотой юм.

Хүснэгт 4.1.1

Төсвийн орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/

Орлогын төрөл	2014-2015 гүйцэтгэл		2015-2016 гүйцэтгэл		Өөрчлөлт өмнөх оноос	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Улсын төсвийн санхүүжилт	4,505.2	10.4	2,032.5	2.7	(2,472.7)	(54.9)
Сургалтын төлбөр	32,424.2	74.8	37,007.9	79.8	4,583.7	14.1
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	6,425.8	14.8	7,415.9	17.5	990.1	15.4
ДҮН	43,355.2	100.0	46,456.2	100.0	3,101.1	7.2

Улсын төсвөөс байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, барилга, байгууламжийн их засварын зардал, лицей сургуулийн болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагчдын хувьсах зардалд авсан санхүүжилт 2015-2016 оны хичээлийн жилийн өмнөх тайлангийн хугацаанд авсан санхүүжилтээс 2,472.7 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Үүнд, байр

ашиглалтын тогтмол зардал 416.0 сая төгрөгөөр, их засвар хөрөнгө оруулалтын зардал 2,753.9 сая төгрөгөөр тус тус буурсан, “Байгаль-эх” лицей ахлах сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн /МСҮТ/ сурагчдын хувьсах зардал 29.0 сая төгрөгөөр өссөн, бодлогын дэмжлэгийн санхүүжилт 668.2 сая төгрөгөөр өссөн байна. Тайлангийн улсын төсвөөс хугацаанд дээрх зардлуудад нийт 2,032.5 сая төгрөгийн санхүүжилт авлаа.

Төсвийн санхүүжилтийн орлогыг санхүүжүүлсэн зардлын төрлөөр харуулбал:

Хүснэгт 4.1.2

Төсвийн орлогын гүйцэтгэл /өмнөх онтой харьцуулсан/

/сая төгрөг/

1	Санхүүжилтийн төрөл	2014-2015 оны хичээлийн жилийн гүйцэтгэл		2015-2016 оны хичээлийн жилийн гүйцэтгэл		Өөрчлөлт /өмнөх оноос/	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Ашиглалтын зардлын санхүүжилт	1,016.0	22.6	600.0	29.5	(416.0)	(40.9)
2	Их засвар, хөрөнгө оруулалтын санхүүжилт	3,306.8	73.4	552.9	27.2	(2,753.9)	(83.3)
3	Бодлогын дэмжлэгийн санхүүжилт	-	-	668.2	32.9	668.2	100.0
4	Хувьсах зардлын санхүүжилт	182.4	4.0	211.4	10.4	29.0	15.9
	ДҮН	4,505.2	100.0	2,032.5	100.0	(3,240.5)	(71.9)

Тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт өмнөх тайлангийн хугацаанаас 2.7 тэрбум төгрөгөөр буурсан байна. Улсын төсвөөс байр ашиглалтын зардлыг бүрэн санхүүжүүлээгүйгээс 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тогтмол зардлын санхүүжилтийн 887.0 сая төгрөгийн авлагатай гарлаа. Хичээлийн жилийн хугацаанд тогтмол зардлын санхүүжилтэнд 600.0 төгрөг авсан ч 2016 оны ашиглалтын зардлууд нэмэгдсэнээр энэ хичээлийн жилийн эцэст тогтмол зардлын 416.0 сая төгрөгийн авлагатай байна.

Төсвийн санхүүжилт: “Е-номын сангийн барилга, хичээлийн 4-р байрны өргөтгөлийн барилга”-ын ажлын санхүүжилтэнд 2016 оны улсын төсөв, БСШУ-ны сайдын багцаас 658.7 сая төгрөгийн санхүүжилт авахаар батлуулсанаас тайлант хичээлийн жилд барилгын ажлын гүйцэтгэлд 136.8 сая төгрөгийн санхүүжилт авлаа. Хичээлийн жилийн тайлант хугацааны эцэст төсвийн санхүүжилтийн аваагүй үлдэгдэл 495.5 сая төгрөг байна. Тайлант хугацаанд Азийн хөгжлийн банкны дээд боловсролын “Дээд боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд төсвийн санхүүжилтээр сургалтын 4 лаборатори шинээр байгуулж, лабораторийн тоног төхөөрөмжийн санхүүжилтэнд 416,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.

Хүснэгт 4.1.3

Төсвийн санхүүжилтээр хийгдсэн лабораториуд

/сая төгрөг/

№	Лабораторийн нэр	Санхүүжилт
1	Шинэ материалын хими технологийн лаборатори	228.41
2	Хими технологийн лаборатори	61.37
3	Шинжлэх ухаан инженерчлэлийн тооцооллын төв	26.20
4	Мультимедиа лаборатори	100.10
	ДҮН	416.10

Азийн хөгжлийн банкны санхүүжилттэйгээр БСШУСЯ-ны хэрэгжүүлж буй Дээд боловсролын шинэчлэл төслөөс дээд боловсролын байгууллагын хөгжлийг дэмжих төслүүдийг хэрэгжүүлэх, тус сургуулийн хөтөлбөрүүдийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэлд хамруулах ажлын хүрээнд 10 хөтөлбөр (Физик, Математик, Газар зүй, Газар зохион байгуулалт, Шатах ашигт малтмал, Биологи, Биотехнологи, Экологи, Мэдээллийн технологи, Электрон системийн автоматжуулалт), олон улсын ASIIN магадлан итгэмжлэлийн байгууллагад Хими, Програм хангамжийн хөтөлбөрийг тус тус магадлан итгэмжлүүлэх бэлтгэл ажлыг хангах, эдгээр хөтөлбөрүүдийг дотоодын болон олон улсын магадлан итгэмжлэлд хамруулахад нийт 310.2 сая төгрөг, эрдэм шинжилгээ, судалгааны 22 төслийг санхүүжүүлэхэд 357,9 сая төгрөг улсын төсвийн санхүүжилт олгож дэмжлэг үзүүлсэн байна.

Хүснэгт 4.1.4

Хэрэгжүүлсэн "Дээд боловсролын байгууллагын хөгжлийг дэмжих" төслүүд

/мянган төгрөг/

№	Төслийн нэр, удирдагчийн нэр	Мөнгөн дүн
1	МУИС-ийн академик менежментийг сайжруулах /Г.Баярмагнай, О.Мөнхбат, Ч.Ундрам, Б.Батжаргал/	35,000.0
2	Монгол улсын их дээд сургуулийн ЭШИ-ийн үндсэн бодлогын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шинэчлэлийн арга зам /Б.Болдгив, Б.Баяртогтох, Б.Доржнамжирмаа, П.Энхбаяр, М.Золжаргал, Б.Очирхуяг, Д.Лхагвасүрэн, Ц.Пүрэвсүрэн/	38,000.0
3	МУИС-д хичээлийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх тогтолцоог бий болгох нь /Ц.Амартайван/	35,000.0
4	МУИС-ийн засаглал, удирдлага, үйл явцыг сайжруулах замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нь /Ч.Нарантуяа/	35,000.0
5	Олон улсын хянах магадлалтай монгол судлалын сэтгүүлийг бий болгох зорилгоор англи хэлээр гардаг бие даасан сэтгүүл бий болгох	10,500.0
6	Дэлхийн Монгол судлалын төвүүдэд үндсэн орон тоогоор ажиллаж буй монгол судлаач багш нарын сургалт семинарыг Монгол ахуй орчинд зохион байгуулах	14,000.0
7	Монгол Судлалын Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	14,000.0
8	Оюутны санаачлагыг дэмжих төсөл хэрэгжүүлэх	14,445.3
9	Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх	88,283.8
10	"Монголын нууц товчоо" каталоги бүтээх төсөл /Д.Заяабаатар/	16,000.0
11	"Монголын эртний түүх" таван боть ном бүтээх төсөл /Д.Заяабаатар/	10,000.0
	Мөнгөн дүн	310,229.1

Хүснэгт 4.1.5

Хэрэгжүүлсэн эрдэм шинжилгээний төслүүд

/мянган төгрөг/

дд	Төслийн нэр, удирдагчийн нэр	Мөнгөн дүн
1	ЕБС-ийн X-XII ангийн математик, байгалийн ухааны сургалтын хөтөлбөр шинэчлэн боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулах, хянах төсөл /М.Итгэл/	48,951.0

2	Сансрын инженерчлэлийн хөтөлбөр, /Р.Цолмон/	8,000.0
3	Монгол орны залуу хүрэн нүүрсийг ашиглах цэвэр ба үр ашигтай технологийг бий болгох, /Б.Энхсаруул/	8,000.0
4	Монгол орны эрдэс материалд тулгуурласан хүрээлэн буй орчны инженерчлэл, цемент бэхжүүлэгч, хөвүүлэн баяжуулагчийн судалгаа, /О.Алтансүх/	8,000.0
5	Монгол орны ургамал, микроорганизмаас биологийн идэвхит нэгдэл болон ашигтай генийг илрүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх, /Ж.Батхүү/	8,000.0
6	Цогц процессын загварчлал, оновчлол ба симуляци /А.Энхбаяр/	8,000.0
7	Чадлын электроник ба үйлдвэрлэлийн автоматжуулалтын судалгаа хөгжүүлэлт /Д.Баясгалан/	8,000.0
8	Үндэсний ойн тооллогын үр дүнд математик боловсруулалт хийх загварчлал гаргах /Б.Оюунсанаа/	3,000.0
9	Ойжуулах шаардлагатай талбай болон мод үржүүлгийн газрын хөрсний бүтцийг сайжруулан био нүүрс гаргаж авах /Н.Баатарбилэг/	7,500.0
10	Г.Занабазарын хосгүй үнэт бүтээлүүдийн дижитал загваруудыг математикийн аргаар судлах нь /А.Энхбаяр/	17,640.0
11	Хил орчмын бүс нутгийн шороон замын эвдрэлийн судалгаа /Д.Даваадорж /	19,600.0
12	Технологи дамжуулалт ба технологи шингээх чадварыг тодорхойлох /Д.Лхагвасүрэн/	19,600.0
13	Хорт хавдар үүсгэгч болон дэлгэрүүлэгч генүүдийн сүлжээг илрүүлэх оптимизацид суурилсан аргууд /А.Баярбаатар/	19,600.0
14	Сургалтанд Ашиглах Хүртэхүйн Туршилтын Инженерчлэлийн Хөгжүүлэлт /С.Нямлхагва/	19,516.0
15	Г.Занабазарын хосгүй үнэт бүтээлүүдийн дижитал загваруудыг математикийн аргаар судлах нь /А.Галтбаяр/	19,600.0
16	Хөхтөн амьтдын генетик баркодын өгөгдлийн сан бүрдүүлэх /Д.Баярлхагва /	19,600.0
17	Хөнгөн цөмийн энергийн спектр /М.Одсүрэн/	18,760.0
18	Монгол хэлийг ойлгохуй /Ч.Алтангэрэл/	18,900.0
19	Цэвдэгтэй бүсийн гадаргын болон газрын доорх усны хөдлөл зүйг изотопын аргаар тооцох нь /Э.Мөнхцэцэг/	18,900.0
20	Нефтийн атмосфер нэрлэгийн үлдэгдлийг гидрокрекинг процессоор боловсруулахад хэрэглэгдэх катализатор гарган /Ц.Төгсөө/	19,600.0
21	Гурван хэмжээст цэгэн гэрэл үүсгэгч дэлгэцийн харагдах өнцгийг ихэсгэх /Б.Ганбат/	19,562.2
22	Зэс суурьтай шинэ төрлийн наноккомпозит материал гарган авах, түүний хэрэглээний судалгаа /Б.Очирхуяг/	19,600.0
	ДҮН	357,929.20

Сургалтын төлбөр, орлого

Удирдах зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 03-ний өдрийн хурлаар тус сургуулийн 2015-2016 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлбөр, оюутны байрны төлбөрийн хэмжээг оруулж батлууллаа.

2015-2016 оны хичээлийн жилд МУИС-ийн Удирдах зөвлөл сургалтын төлбөрийн хэмжээг өмнөх хичээлийн жилийнхээс 12 хувиар өсгөж, шинээр элсэгч оюутнуудын хувьд төлбөрийн хэмжээг шинээр тогтоосон. Сургалтын төлбөрийн хэмжээг нийт оюутанд үзүүлдэг үйлчилгээний зардлыг илэрхийлсэн суурь төлбөр, сургууль, хөтөлбөрийн түвшинээр ялгаатай тогтоосон судлах хичээлийн багц цагийн төлбөрийн хэмжээгээр илэрхийлсэн. Тус сургуулийн сургалтын төлбөрийн хэмжээг адилтгах түвшний хөтөлбөр бүхий гадаадын сургуулиудтай харьцуулахад олон дахин бага, Монгол Улсад бараа, ажил үйлчилгээний үнэ тариф тэдгээр орныхоос төдийлэн багагүй байгаа атал тэдэнтэй харьцуулах түвшний чанартай үйлчилгээ үзүүлэх шаардлагатай тулгарч байгаа билээ.

Сургалтын төлбөрийг шинэчлэн тогтооходоо төсвийн орлогын дийлэнхи хэсгийг сургалтын төлбөрөөр бүрдүүлж байгаа, сургалтын чанарын баталгаа, хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотой өөрчлөлтүүд, хөтөлбөрүүдийн олон улсад магадлан итгэмжлэгдсэн байдал, зах зээлийн эрэлт хэрэгцээ, ижил төстэй хөтөлбөрүүдийн өрсөлдөх чадвар, төлбөрийн судалгаа, хөтөлбөрийн үр ашиг, инфляцийн түвшин зэргийг тооцсон. Энэ хичээлийн жилд сургалтын төлбөрөөс орсон орлогыг сургалтын түвшингөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 4.1.6

Сургалтын төлбөрийн орлогын бүтэц, өөрчлөлт

(сая төгрөг)

1	Орлогын нэр төрөл	2014-2015 оны хичээлийн жилийн гүйцэтгэл		2015-2016 оны хичээлийн жилийн гүйцэтгэл		Өөрчлөлт /өмнөх оноос/	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Бакалавр	28,719.8	88.6	32,209.6	87.0	3,489.8	12.2
2	Магистр	1,916.7	5.9	2,148.8	5.8	232.1	12.1
3	Доктор	442.6	1.4	545.6	1.5	103.0	23.3
4	Гадаад оюутан	756.4	2.3	1,341.6	3.6	585.2	77.4
5	Түр сургалт	168.7	0.5	-	-	(168.7)	(100.0)
6	Лицей, МСҮТ	420.1	1.3	762.3	2.1	342.2	81.5
	ДҮН	32,424.3	100.0	37,007.9	100.0	4,583.6	14.1

Тайлангийн хугацаанд сургалтын төлбөрөөс нийт 37,007.9 сая төгрөгийн орлого хуримтлуулсан нь өмнөх оноос 4,583.6 сая төгрөгөөр буюу 14.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Сургалтын төлбөрийн нийт орлогын 87.0 хувийг бакалаврын сургалтын төлбөрийн орлогоор, 7.3 хувийг магистр, докторын ахисан түвшний сургалтын орлогоор бүрдүүлсэн байна.

Сургалтын төлбөрийн орлогын өсөлтийг сургалтын түвшингээр нь өмнөх онтой харьцуулан үзэхэд бакалаврын сургалтын төлбөрийн орлого 12.2 хувиар, магистрантын сургалтын төлбөрийн орлого 12.1 хувиар, докторантын сургалтын төлбөрийн орлого 23.3 хувиар, гадаад оюутны сургалтын төлбөрийн орлого 77.4 хувиар, Лицей сургууль, МСҮТ-ийн сургалтын төлбөр 81.5 хувиар тус тус өссөн байна. 2016 оны төсвийн орлогын бүрдүүлэлтэнд түр сургалтын орлогыг төлөвлөлөхгүй болсонтой холбоотой түр сургалтын орлогын гүйцэтгэл гараагүй.

Сургалтын төлбөрийн санхүүжилтийн бүтэц

(сая төгрөг)

№	Санхүүжилт	2014-2015 оны хичээлийн жилд		2015-2016 оны хичээлийн жилд		Өөрчлөлт /өмнөх оноос/	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Хувийн төлбөр	30,957.5	95.5	35,698.2	96.5	4,740.7	15.3
2	Сургалтын төрийн сан	1,466.8	4.5	1,309.7	3.5	(157.1)	(10.7)
	ДҮН	32,424.3	100.0	37,007.9	100.0	4,583.6	14.1

Тайлант хугацааны сургалтын төлбөрийн нийт орлого 37,007.9 сая төгрөг байгаагаас нийт орлогын 96.5 хувийг суралцагчийн хувийн төлбөрийн орлогоор, 3.5 хувийг сургалтын төрийн сангийн хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтийн орлогоор бүрдүүлсэн байна.

2015-2016 оны хичээлийн жилд Сургалтын төрийн сангаас Төрийн албан хаагчийн хүүхдийн сургалтын төлбөр, хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламжаар суралцагч оюутны сургалтын зээл, гадаад оюутны сургалтын төлбөр, тэтгэлэгт нийт 866 оюутан хамрагдаж, тэдгээрийн санхүүжилтэнд 1,309.7 ₮-ыг авахаар батлагдсан нь өмнөх оныхоос зээлд хамрагдсан оюутны тоо 1043 оюутнаар буурсан, сургалтын төрийн сангаас авах санхүүжилтийн орлого 157.1 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Сургалтын төрийн сангийн санхүүжилт авч байгаа оюутны тоо, санхүүжилтийг төрлөөр нь харуулбал:

Сургалтын төрийн сангийн санхүүжилтийн бүтэц

(сая төгрөг)

№	Санхүүжилт	2014-2015 оны хичээлийн жил		2015-2016 оны хичээлийн жил		Өөрчлөлт /өмнөх оноос/	
		Оюутны тоо	Санхүүжилт	Оюутны тоо	Санхүүжилт	Оюутны тоо	Санхүүжилт
1	Төрийн албан хаагч	527	216.8	45	16.5	(482)	(200.3)
2	192-р тогтоол	1,275	936.6	736	991.2	(539)	54.6
3	Гадаад оюутан	107	313.3	85	302.0	(22)	(11.4)
4	Магистр, доктор	-	-	-	-	-	-
	ДҮН	1,909	1,466.8	866	1,309.7	(1043)	(157.1)

Тус хичээлийн жилд сургалтын төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжинд хамрагдаж сургалтын төрийн сангаас санхүүжилт авсан оюутны тоо, батлагдсан санхүүжилтийг бүрэлдэхүүний сургуулиудаар задалж харуулбал:

Хүснэгт 4.1.9

**Сургалтын төрийн сангийн зээлд хамрагдсан оюутны тоо, санхүүжилт
/бүрэлдэхүүний сургууль тус бүрээр/**

(сая төгрөгөөр)

№	Бүрэлдэхүүн сургуулийн нэр	ТАХ		ЗГ-ын 192 тоот тогтоол /буцалтгүй, хөнгөлттэй зээл/		СТСангийн нийт санхүүжилт	
		Тоо	Төлбөр	Тоо	Төлбөр	Тоо	Төлбөр
1	ХШУИС	-	-	92	156.7	92	157
2	ШУС	12	5.0	361	480.7	373	486
3	БС	6	1.9	130	155.0	136	157
4	ХЗС	22	7.5	50	69.7	72	77
5	ОУХНУС	2	0.7	33	45.9	35	47
6	ЗАВХАН			26	30.2	26	30
7	ОРХОН	3	1.2	44	53.2	47	54
	Дүн	45	16	736	991.4	781	1,008
8	Гадаад оюутан СТөлбөр					858	169
9	Гадаад оюутан Тэтгэлэг					72	133
	Нийт дүн	45	16	736	991.4	938	1,309.7

Тайлант хугацаанд сургалтын төрийн сангаас санхүүжүүлэхээр батлагдсан санхүүжилтээс 503.8 сая сая төгрөгийн санхүүжилт авч 2016 оны 6 дугаар сарын 30-ны тайлангаар 805.9 сая төгрөгийн сургалтын төрийн сангийн авлагатай байна. 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн сургалтын төрийн сангийн санхүүжилтийг тайлант хугацаанд бүрэн санхүүжүүлээгүй, дараагийн хичээлийн жил дамжуулан олгож байснаас сургалтын төрийн сангийн буцалтгүй тусламжинд хамрагдсан оюутнууд судлахаар сонгосон хичээлээ баталгаажуулахад төлбөр төлөгдөөгүй асуудал үүсч байлаа. Энэхүү асуудлыг сургуулийн захиргаа тухай бүр шийдвэрлэж ирлээ. Тухайлбал, сургалтын төрийн сангийн буцалтгүй тусламжаар суралцахаар гэрээ байгуулах эрх нь үүссэн шинээр элсэгчид, өмнөх хичээлийн жилд сургалтын төрийн сангийн зээлээр суралцаж байсан оюутнуудыг цаашид гэрээг үргэлжлүүлэн сунгана гэж үзээд дээрх оюутнуудын судлах хичээлийн төлбөрийг системд урьдчилан оруулж, сонгосон хичээлийг нь баталгаажуулах, гадаад оюутны тэтгэлэгийг сургуулийн бусад орлогын эх үүсвэрээс урьдчилан олгох зэргээр оюутнуудын асуудлыг зохицуулж ирлээ. Харин зээлээр суралцагч оюутнууд сургалтын төлбөрөө өөрсдөө төлж хичээл сонголтгоо баталгаажуулж, сургалтын төрийн сангийн санхүүжилт орсон даруй оюутнуудад төлбөрийн буцаан олголтыг хийж байна.

Хичээлийн жилийн хугацаанд туслах үйл ажиллагааны орлогоос нийт 7,415.8 сая төгрөгийн орлого орсон нь өмнөх тайлангийн үетэй харьцуулбал 990.0 сая төгрөгөөр буюу 15.4 хувиар өссөн байна. Дээрх орлогын нийт өсөлтийн 629.4 сая төгрөг нь хадгаламжийн хүүгийн орлогоос орсон байна.

Туслах үйл ажиллагааны орлогыг орлогын төрлөөр харуулбал:

Туслах үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл

(сая төгрөг)

1	Орлогын нэр төрөл	2014-2015 оны хичээлийн жил		2015-2016 оны хичээлийн жил		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Оюутны байрын төлбөрийн орлого	802.4	10.7	1,353.2	18.2	550.8	68.6
2	ЭШ гэрээт ажил төслийн орлого	2,266.7	30.3	1,869.1	25.2	(397.6)	(17.5)
3	Ромбо, диплом, үнэмлэхний орлого	97.1	1.5	106.3	1.4	9.2	9.4
4	Түрээсийн орлого	11□.4	1.8	88.3	1.2	(29.1)	(24.8)
5	Хэвлэх үйлдвэрийн орлого	184.4	2.9	150.8	2.0	(33.6)	(18.2)
7	Шилжилтийн төлбөрийн орлого	49.3	0.8	-	-	(49.3)	(100.0)
8	Харилцах дансны хүүгийн орлого	1,581.4	24.6	2,210.8	27.2	629.4	39.8
9	60 айлын байрын төлбөрийн орлого	64.5	1.0	-	-	(64.5)	(100.0)
10	Хандив тусламжийн мөнгөн орлого	239.9	3.7	276.8	3.7	36.9	15.4
11	Туслах үйл ажиллагааны бус	201.2	3.1	517.4	6.4	316.2	157.2
12	Зуны болон түр сургалтын орлого	28.4	0.4	127.7	1.7	99.3	349.6
13	Бусад орлого	793.1	12.3	715.4	9.6	(77.7)	(9.8)
	ДҮН	6,425.8	100.0	7,415.9	100.0	990.1	15.4

Туслах үйл ажиллагааны нийт орлогын өсөлтийн 58.9 хувийг эрдэм шинжилгээний гэрээт ажил, төсөл, хөтөлбөрийн орлого, хадгаламжийн хүүгийн орлого, хандив тусламжийн орлогоор бүрдүүлсэн байна.

Хандив, тусламж: Хандивын орлогыг нэмэгдүүлэх, хандивлагчдыг татах ажлыг сүүлийн 2 хичээлийн жилд албан ёсны үйл ажиллагаа болгон зохион байгуулах, хандивлагчдыг татах арга хэмжээнүүд тухайлбал спортын үзүүлэх тоглолт хийх, сургуулийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зэрэг ажлыг хийж байна. Тухайлбал, Олон улсын сансрын станцаас 2017 онд хөөргөхөөр Кюүшүгийн Технологийн Институт дээр эхлүүлэн ажиллаж байгаа BIRDS төслийг дэмжиж 2016 оны төсөвт 100.0 төгрөг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тусгасан байсан ба үлдэх 160.0 сая төгрөгийг хандив, тусламжаар бүрдүүлэхээр ажиллаж, тайлант хугацаанд зорилтоо бүрэн биелүүллээ. Энэхүү төслийг дэмжигч нийт 286 байгууллага иргэдээс 169.8 сая төгрөг цугларсанаас хичээлийн жилд 13.7 сая төгрөг нь энэ орсон.

Тайлант хугацаанд дараах байгууллага, иргэдээс хандивын орлого орсон байна. Үүнд:

Хандивлагчийн мэдээлэл, хандивын орлогын дүн

/мянган төгрөг/

№	Хандив хүлээн авагч	Ханливллагч	Зориулалт	Мөнгөн дүн
1	МУИС-Төвлөрсөн сан	Ц.Мянганбаяр /Монгол газар Д.Улам-Оргих /МУИС-ийн багш/ П.Сайнзаяа, Гантулга /иргэн/ Ж.Гүррагчаа / Сансрын нисгэгч/ Завхан сургууль З.Батжаргал /иргэн/ Тоглолтын орлого сурагч, оюутан, иргэд 279 ОБЕГ 150.0 сая төгрөг*	2017 онд хөөргөх хиймэл дагуул	1,000.0 1,000.0 1,000.0 1,995.0 1,000.0 1,000.0 1,085.3 5,597.2
		Торгоны замын их сургуулиудын сүлжээ байгууллага Silk- road Universities Network (SUN)-с сургуулийн цахим номын сангийн хөгжилд 100 сая вон Санхүүжилт: 1. 2016.07.05 42.945\$ 2. 2016.12.02 33.900\$ 3. 2016.12.13 <u>11.029\$</u> 87.874\$	Е-Номын сангийн лекцийн том дэлгэц, төхөөрөмж авахад	85,701.9
		Монгол УБ Культур Е-Март /49990 ам.дол/	Гадаад хэлний төвийн лаборатори байгуулах	97,336.5
		Хаан банк	Номын санд тохижилт	16,999.5
		Күнзийн Институт	Оюутны үйл ажиллагаанд	10,000.0
2	ШУС	Дэвид	Их британи, америк судлалын тэнхмийн оюутнуудын сургалтын төлбөрийн тэтгэлэгт	7,924.2
3	БС	Монголын эмнэсти ХХК Шевцарийн хөгжлийн агентлаг Төрийн банк Хаан банк	Энтерпрегеруудын чуулганд	4,000.0 10,000.0 3,000.0 5,000.0
4	ОУХНУС	JAN ZIEKOW /1000.0 евро/	Ном, сурах бичиг авахад	2,154.0
5	Завхан	МУИС МО-ны спортын холбоо Завхан аймгийн ЗДТГ	Баруун бүсийн оюутны урлаг, спортын наадамд	10,000.0 9,000.0 1,000.0
6	Монгол Япон төв	Япон сан	Шатахууны зардалд	1,000
Тайлант хугацааны хандивын орлогын дүн				276,793.6
*Тайлангийн хугацааны дараа мөнгө нь орсон				

Оюутнуудын гаргасан санал, хүсэлт, Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу 2015 оны зуны их засвараар оюутны байруудад давхар бүрээр хэсэгчилсэн засвар хийхээр төлөвлөж байсныг өөрчилж, оюутны нэг болон гуравдугаар байрны доторхи өрөөнүүдийн их засварыг иж бүрнээр, бусад байруудад хэсэгчилсэн гаднах болон доторхи их засварын ажлыг хийлээ. Оюутны байруудад доторхи их засварын ажлыг иж бүрэн хийгдсэн, хэсэгчлэн хийгдсэнийг харгалзан тайлант жилд оюутны дотуур байранд амьдран суух төлбөрийг байр бүрээр ялгавартайгаар тогтоосон. Өмнөх тайлангийн хугацаанд оюутны байранд нилээдгүй хэмжээний өртөгтэй их ба урсгал засвар хийсэн, нэг өрөөнд байх оюутны тоог цөөрүүлэх, оюутны амьдрах орчин нөхцлийг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг авсан. Эдгээр арга хэмжээнүүдийг авсан боловч зарим байруудад өрөө дүүргэлт хангалтгүй байлаа. Энэ тайлангийн

хугацаанд дээрх зохицуулалтанд өөрчлөлт оруулсан, дотуур байрны төлбөрийг засварын зардлын хэмжээнд нэмэгдүүлэн тогтоосноор тайлант хугацааны орлого өмнөх тайлангийн хугацаанаас 550.8 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

МУИС-ийн багш нар 2015-2016 оны хичээлийн жилд дотоод, гадаадын байгууллагын санхүүжилттэй төсөл хөтөлбөр, гэрээт ажил, ШУТСангийн санхүүжилттэй 134 сэдэвт ажилд оролцож, 2.8 тэрбум төгрөгийн эрдэм шинжилгээ, судалгааны санхүүжилт татаж, ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 4.1.12

Эрдэм шинжилгээний төсөл, хөтөлбөрийн орлогын гүйцэтгэл

(сая төгрөг)

№	Санхүүжүүлэгч	Төслийн тоо	Мөнгөн дүн
1	ШУТСангийн санхүүжилттэй сэдэвт ажил, төслүүд	42	1,114.21
2	Гадаадын байгууллага, хамтарсан сангийн санхүүжилттэй төсөл хөтөлбөр	20	743.94
3	Дотоодын байгууллагын аж ахуйн гэрээт ажил	52	849.39
4	Азийн судалгааны төвийн санхүүжилтээр хийсэн ажлууд	20	159.3
	ДҮН	134	2,866.84

-МУИС-ийн дансаар дамжиж хэрэгжүүлсэн төслийн ажлууд*

Энэ хичээлийн жилд МУИС дээр хэрэгжүүлсэн төслүүдээс 14 удирдагч эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэхэд дэмжлэг болгож өөрийн удирдсан 14 төслөөс МУИС-ийн эрдэм шинжилгээ, инновацийн дансанд сайн дурын үндсэн дээр нийт 29.2 сая төгрөг орууллаа.

Хүснэгт 4.1.13

МУИС-ийн инновацийн дансанд оруулсан шимтгэлийн хэмжээ

/мянган төгрөгөөр/

№	Төслийн удирдагч	Бүрэлдэхүүн сургуулийн нэр	Төслийн дүн	МУИС-д төлсөн шимтгэлийн дүн
1	Ч.Энхбаяр	БС	39,850.0	1,992.5
2	С.Шаарийбуу	Захиргаа	39,600.0	642.0
3	П.Мягмарцэрэн	ШУС	89,427.2	3,181.5
4	Г.Баярмагнай	Захиргаа	40,590.0	10,000.0
5	Ц.Амартайван	ШУС	10,000.0	500.0
6	Т.Чулуун	ШУС	118,987.3	5,949.3
7	Д.Лхагвасүрэн	ШУС	6,810.0	340.5
8	Н.Батхүү	ХШУИС	33,485.7	1,674.2
9	Н.Сонинхишиг	ШУС	23,307.7	1,165.3
10	Р.Самъяа	ШУС	2,355.0	117.7
11	Д.Суран	ШУС	8,500.0	425.0
12	Л.Ариунцэцэг	ШУС	28,906.5	1,445.3
13	Н.Сонинтамир	БС	10,035.0	1,003.5
14	Ц.Болормаа	БС	8,000.0	800.0
	Шимтгэлийн орлогын нийт дүн		459,854.4	29,237.2

Тайлант хугацаанд нэгжүүдийн эрдэм шинжилгээний төслийн нийт орлого өмнөх оноос 926.8 сая төгрөгөөр буюу 69.2 хувиар өссөн байна. ШУТСангаас санхүүжүүлж байгаа төслийг хүрээлэн, төвүүдээр салгаж харуулбал:

Хүснэгт 4.1.14

ШУТС-ийн санхүүжилтээр гүйцэтгэсэн сэдэвт ажлуудын санхүүжилт

(сая төгрөг)

№	Нэгжийннэр	2014-2015 оны хичээлийн жил		2015-2016 Оны хичээлийн жил		Өөрчлөлт /өмнөх оноос/	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	ШУТСангийн төслүүд	435.1	52.6	695.8	26.3	260.7	(26.25)
2	Математикийн хүрээлэн	187.7	22.6	207.8	7.8	20.10	(14.73)
3	Цөмийн судалгааны төв	205.4	24.8	183.7	6.7	(21.7)	(18.11)
4	Эдийн засгийн хүрээлэн	-	-	26.9	1.0	26.9	1.02
5	ЭШТөсөл, бусад	1,344.7	61.9	1,526.9	57.81	182.2	(4.08)
	ДҮН	2,172.90	100.0	2,641.1	100.00	468.2	(62.15)
6	Азийн судалгааны төв	92.7	11.2	155.3	5.4	97.3	(5.83)
7	Монгол-Япон төв	-	-	97.3	3.4	62.6	3.36
	ДҮН	2,265.6	100.0	2,893.7	100.0	628.1	100.0

ЗАРЛАГА БА САНХҮҮЖИЛТИЙН БҮТЭЦ

Хичээлийн жилээс Е-номын сан, хичээлийн 4-р байрны өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлсэнтэй холбоотойгоор төлөвлөсөн зардлуудыг төсвөөс хэтрүүлэхгүй зарцуулах, орлого бүрдээгүй хэсгийн зардлыг санхүүжүүлэхгүй байх, төсөвт тусгагдаагүй зардлыг санхүүжүүлэхгүй байх, хязгаарлах, шаардлагагүй зардлыг тэвчих, санхүүгийн хүндрэл үүсгэхээс бологоомжилж, мөнгөний урсгалыг тухай бүр хянаж ажиллах удирдамж, чиглэл өгч ажилласан. Тайлант хугацаанд багш, ажилтны цалин, цагийн хөлс, илүү цагийн хөлс, сургалтын болон бусад төлөвлөгдсөн зардлуудыг цаг хугацаанд нь санхүүжүүлж ирсэн ба бүрэлдэхүүний сургуулиуд хичээлийн жилийн орлогоороо зардлаа бүрэн санхүүжүүлж ажиллалаа. Мөн барилгын гүйцэтгэлийг батлагдсан гэрээ, гэрээний хугацаа, ажлын гүйцэтгэл, гүйцэтгэлийн хяналтын тайлангийн дагуу цаг хугацаанд нь бүрэн санхүүжүүлж ирлээ.

2015-2016 оны хичээлийн жилд эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагааны зардалд нийт 46,727.7 сая төгрөг зарцуулсан нь өмнөх тайлангийн хугацаанаас 7,704.5 сая төгрөгөөр буюу 19.7 хувиар өссөн байгаагийн 27.1 хувь нь хөрөнгө оруулалтын зардал байна. Энэ хичээлийн жилд “МУИС-ийн Е-номын сан болон хичээлийн 4-р байрны өргөтгөлийн барилга” төслийн ажлыг эхлүүлсэнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын зардал өмнөх тайлангийн хугацаанаас эрс өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 4.1.15

Зардлын гүйцэтгэл /өмнөх тайлангийн хугацаатай зэрэгцүүлсэн/

(сая төгрөг)

№	Зарлагын нэр төрөл	2014-2015 оны хичээлийн жил		2015-2016 оны хичээлийн жил		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Цалин хөлс, НДШ	23,888.6	61.0	24,600.6	52.6	712.0	3.0
2	Бараа үйлчилгээ	2,396.3	6.1	2,196.2	4.7	(200.1)	(8.4)
3	Сургалтын үйлчилгээ	1,851.1	4.7	2,550.7	5.5	699.6	37.8
4	Эрдэм шинжилгээ	2,442.4	6.3	3,350.9	7.2	908.5	37.2
5	Ашиглалтын зардал	1,285.5	3.3	1,351.5	2.9	66.0	5.1

6	Хөрөнгө оруулалт	7,159.3	18.3	12,677.8	27.1	5,518.5	77.1
	ДҮН	39,023.2	100.0	46,727.7	100.0	7,704.5	19.7

Тайлант оны өмнөх үетэй харьцуулахад бараа үйлчилгээний нийтлэг зардал 200.1 сая төгрөгөөр буюу 8.4 хувиар буурсан, зардлын бусад төрөл 3.0-77.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал цалингийн зардал өмнөх оныхоос 712.0 сая төгрөгөөр буюу 3.0 хувиар, сургалтын үйлчилгээний зардал 699.6 сая төгрөг буюу 37.8 хувиар, эрдэм шинжилгээний зардал 908.5 сая төгрөгөөр буюу 37.2 хувиар, хөрөнгө оруулалтын зардал 5,518.5 сая төгрөгөөр буюу 77.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд “МУИС-ийн Е-номын сан болон хичээлийн 4-р байрны өргөтгөлийн барилга”-ын ажлын гүйцэтгэлээр өөрийн хөрөнгөөр 9,789.7 сая төгрөгийн санхүүжилт хийсэн нь өмнөх оныхоос 8,299.87 сая төгрөгөөр өссөн байна. Улсын төсвийн санхүүжилтээр 136.8 сая төгрөгийг татаж номын сангийн барилгад оруулжээ. Номын сангийн барилгын зургийн болон инженерийн шугамын нэмэлт ажлуудтай холбоотойгоор барилгын ажлын хүлээлгэж өгөх хугацаа тодорхой хугацаагаар хойшилсон. Тайлант хугацааны эцэст барилгын ажлын гүйцэтгэл 75 хувьд хүрээд байна.

Хүснэгт 4.2.16

Зардлын дэлгэрэнгүйг өмнөх тайлангийн хугацааны гүйцэтгэлтэй зэрэгцүүлбэл

(сая төгрөг)

Зарлагын нэр төрөл	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Нийт зардал	39,023.3	46,727.68	7,704.38	19.74
Цалин хөлс, НДШ	23,888.7	24,600.63	711.93	2.98
Цалин хөлс, урамшуулал	21,520.1	22,113.40	593.30	2.76
НДШ	2,368.6	2,487.23	118.63	5.01
Бараа үйлчилгээний зардал	2,304.9	2,196.16	(108.64)	(4.71)
Бичиг хэргийн зардал	105.7	39.51	(66.19)	(62.62)
Аж ахуйн зардал	151.2	447.57	296.37	196.01
Шуудан холбооны зардал	65.6	34.43	(31.17)	(47.51)
Шатахуун сэлбэгийн зардал	24.8	28.57	3.77	15.18
Албан томилолт	28.4	22.54	(5.86)	(20.63)
Шагналын зардал	75.7	38.42	(37.28)	(49.24)
Төвлөрсөн арга хэмжээний зардал	172.7	154.70	(18.00)	(10.42)
Гадаад арга хэмжээний зардал	53.4	61.81	8.41	15.74
Ойн арга хэмжээний зардал	92.8	183.93	91.13	98.20
Тусламж тэтгэлгийн зардал	42.5	58.97	16.47	38.76
Тэтгэвэр, тэтгэмжийн зардал	150.6	204.89	54.29	36.05
Урсгал засварын зардал	725.5	615.66	(109.84)	(15.14)
Төлбөр хураамжийн зардал	602.5	276.46	(326.04)	(54.11)
Хэвлэл сурталчилгааны зардал	13.4	28.71	15.31	114.23
Сургалтын үйлчилгээний зардал	1,851.1	2,550.70	699.50	37.79
Тогтмол хэвлэлийн зардал	51.0	32.57	(18.43)	(36.14)
Хичээл практикийн зардал	1,108.3	1,038.38	(69.92)	(6.31)
Интернетийн зардал	170.5	188.40	17.90	10.50
Оюутны үйлчилгээний зардал	123.0	150.50	27.50	22.36
Оюутны тэтгэлэг	-	309.11	309.11	100.00
Оюутны замын зардал	-	7.41	7.41	100.00
Уралдаан тэмцээний зардал	59.4	69.20	9.80	16.50
Мэргэжлийн олимпиадын зардал	40.8	82.73	41.93	102.76
Гадаад багшийн зардал	87.2	14.09	(73.11)	(83.84)
Багшийг дэмжих зардал	211.0	658.32	447.32	212.00
Эрдэм шинжилгээний зардал	2,533.8	3,350.86	817.06	32.25

ЭШ-ний зардал, төсөл хөтөлбөр, судалгааны зардал	2,533.8	3,350.86	817.06	32.25
Ашиглалтын зардал	1,285.5	1,351.51	66.01	5.13
Гэрэл цахилгаан	469.2	547.61	78.41	16.71
Халаалт	359.7	381.77	22.07	6.14
Цэвэр, бохир усны зардал	154.8	147.48	(7.32)	(4.73)
Харуул хамгаалалтын зардал	301.8	274.65	(27.15)	(9.00)
Хөрөнгө оруулалтын зардал	7,159.2	12,677.82	5,518.67	77.09
Барилга байгууламжийн их засварын зардал	1,895.5	1,010.70	(884.80)	(46.68)
СТТ худалдан авах зардал	1,322.2	827.47	(494.73)	(37.42)
Тавилга, эд хогшил худалдан авах зардал	471.8	282.29	(189.51)	(40.17)
Ном сурах бичиг худалдан авах зардал	162.0	199.28	37.28	23.01
Биет бус хөрөнгө	0.8	15.50	14.70	1,837.23
Улсын төсвийн ХӨ-лаборатори	1,817.1	416.09	1400.96	77.10
Хөрөнгө оруулалт /өөрийн хөрөнгөөр/	1,489.8	9,789.67	8,299.87	557.11
Хөрөнгө оруулалт /номын сан/	-	136.83	136.83	100.00

Зардлын өсөлтийн нийт дүнд хөрөнгө оруулалтын зардлын өсөлт 71.6 хувийг, цалин хөлсний зардлын өсөлт 9.2 хувийг, сургалтын үйлчилгээний зардлын өсөлт 9.1 хувийг, эрдэм шинжилгээний зардлын өсөлт 10.6 хувийг, тогтмол зардал буюу байр ашиглалтын зардлын өсөлт 0.9 хувийг эзэлж байна.

Тайлант хугацааны дундуур буюу 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн МУИС-ийн багш, ажилтан нарын үндсэн цалинг 10.0 хүртэл хувиар өсгөсөн.

Энэ хичээлийн жилд багш нарын цагийн гүйцэтгэлээр нормоос давсан нийт 3,158.54 /өмнөх тайлангийн хугацаанд 2,330.19/ багшийн багц илүү цагийн хөлс тооцож олгосон нь өмнөх хичээлийн жилтэй харьцуулбал 26.36 багшийн багц цагаар буурсан үзүүлэлттэй байна. Нормоос давсан багшийн нийт илүү цагийн 94.48 хувь буюу 2,984.04 багц цаг нь багшийн А цагийн нормоос давсан, 5.52 хувь буюу 174.5 багц цаг нь Б цагийн нормоос давсан багц цаг байна. Багшийн сургалтын ажлын (А) цагийн нормоос давуулан гүйцэтгэсэн нийт 2,984.04 багц цаг байгаа нь өмнөх хичээлийн жилийнхээс 142.56 багшийн багц цагаар буурсан, эрдэм шинжилгээний ажлын (Б цагийн) нормоос давуулан гүйцэтгэсэн 174.5 багц цаг байгаа нь өмнөх хичээлийн жилийнхээс 116.2 багц цагаар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд багшийн нормоос давсан цагийн хөлсөнд нийт 1,129.7 сая төгрөг олгосон байгаа нь өмнөх тайлангийн жилийн хэмжээнд байна. Нийт дүнгээр харахад багшийн А цагт олгосон илүү цагийн хөлс буурсан, Б цагт олгосон илүү цагийн хөлс өссөн харьцаатай байна.

Хүснэгт 4.2.17

Сүүлийн 2 жилийн багшийн илүү цагийн харьцуулалт

(Багшийн багц цагаар Ббц)

Үзүүлэлт	2014-2015		2015-2016		Өөрчлөлт өмнөх оноос
	Илүү цаг	Хувийн жин	Илүү цаг	Хувийн жин	
Нийт илүү цаг /Ббц/	3,184.90	100.00	3,158.54	100.00	(26.36)
Үүнээс: А цаг	3,126.60	98.17	2,984.04	94.48	(142.56)
Үүнээс: Б цаг	58.30	1.83	174.50	5.52	116.20
А цагийн					
Нормын 40 хүртэл	2,272.40	71.35	2,330.19	73.77	57.79
Нормын 40-с дээш	854.20	26.82	653.85	20.70	(200.35)

Хүснэгт 4.1.18

Хөлс тооцож олгосон багшийн илүү цагийг сургууль бүрээр харуулбал:

(сая төгрөг)

Бүрэлдэхүүн сургууль	Сургалтын "А"нормоос илүү цаг			ЭШ-ний "Б"нормоос илүү цагийн хөлс	Нормоос давсан нийт илүү цагийн хөлс	Хувийн жин
	Нормын давсан 40 хүртэл илүү цагийн хөлс	40-с дээш	нийт илүү цагийн хөлс			
ХШУИС	198.90	41.10	240.00	-	240.0	21.25
ШУС/бүгд/	375.50	196.54	572.04	9.29	581.33	51.46
ШУС-БУС	172.64	44.72	217.36	9.29	226.65	20.06
ШУС-НУС	49.17	120.20	169.37		169.37	14.99
ШУС-ХУС	153.69	31.62	185.31	-	185.31	16.40
БС	119.94	20.62	140.56	8.50	149.05	13.20
ХЗС	75.00	28.66	103.66	-	103.66	9.18
ОУХНУС	15.59	1.65	17.24	-	17.24	1.53
ЗАВХАН	7.06	-	7.06	-	7.06	0.62
ОРХОН	31.31	-	31.31	-	31.31	2.77
ДҮН	823.30	288.57	1,111.87	17.79	1,129.66	100.00

Хүснэгт 4.1.19

2015-2016 хичээлийн жилд олгосон тусламж тэтгэлгийн зардлыг бүрэлдэхүүн сургууль, нэгжээр харуулбал

/мянган төгрөгөөр/

№	БС, нэгжийн нэр	Тусламж, тэтгэлэгийн нийт дүн		Тэтгэвэрт гарахад олгосон тэтгэмж		Нэг удаагийн тэтгэмж		Үүнээс: Эмчилгээнд олгосон	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	ШУС-Захиргаа	1	600.00	-	-	1	600.0	-	-
2	ШУС-НУС	6	17,182.00	2	13,430.0	4	3,752.0	-	-
3	ШУС-БУС	18	12,833.7	-	-	18	12833.7	-	-
4	ШУС-ХУС	26	105,966.5	14	100,032.5	12	5,934.0	2	700.0
5	БС	7	17,726.2	2	10,224.0	5	7,502.2	4	2,000.0
6	ОУХНУС	11	25,828.3	4	23,106.0	7	2,722.3	1	500.0
7	ХЗС	10	20,948.0	2	13,248.0	9	7,700.0	4	4,000.0
8	ХШУИС	20	37,050.20	5	33,006.2	15	4,044.0	-	-
9	ОРХОН	14	4,227.50	2	2,427.5	12	1,800.0	1	90.0
10	ЗАВХАН	5	1,077.8	1	172.8	4	905.0	-	-
11	Төв.Сан	31	11,834.9	1	2,547.0	31	9,287.8	4	2,000.0
12	Оюутны байр	3	7,088.0	4	6,696.0	3	392.0	-	-
13	БЭЛАС	4	1,300.0			4	1,300.0	-	-
14	Мон-Япон төв	1	200.0	-	-	1	200.0	-	-
	Нийт дүн	158	263,863.0	32	204,890.0	126	58,973.0	16	9,290.0

2016 оны хичээлийн жилд олгосон судалгааны санхүүжилт
/бүрэлдэхүүн сургуулиар харуулбал/

/мянган төгрөгөөр/

№	БС нэр	Судалгааны суурь зардал		Залуу судлаачийн багийн грант		Өндөр түвшний судалгааны тэтгэлэг		Зочин судлаачдад судалгааны тэтгэлэг		ОУСудлаачдын хамтарсан төслийн санал боловсруулах ҮАД Санхүүжилт		БҮГД ДҮН	
		Хүн тоо	Мөнгөн дүн	Хүн тоо	Мөнгөн дүн	Хүн тоо	Мөнгөн дүн	Хүн тоо	Мөнгөн дүн	Хүн тоо	Мөнгөн дүн	Хүн тоо	Мөнгөн дүн
1	ШУС-БУС	63	79,000.0	4	32,000.0	10	121,000.0	1	40,000.0	-	-	78	272,000.0
2	ШУС-НУС	36	49,000.0	1	9,000.0	2	27,000.0	-	-	-	-	39	85,000.0
3	ШУС-ХУС	58	75,000.0	4	36,000.0	4	36,000.0	-	-	-	-	66	147,000.0
4	ХШУИС	43	58,000.0	5	45,000.0	5	57,000.0	1	35,000.0	1	5,000.0	55	200,000.0
5	БС	35	47,000.0	-	-	1	8,000.0	-	-	-	-	36	55,000.0
6	ХЗС	18	24,000.0	1	8,000.0	-	-	-	-	-	-	19	32,000.0
7	ОУХНУС	7	9,000.0	-	-	-	-	-	-	-	-	7	9,000.0
	Нийт дүн	260	341,000.0	15	130,000.0	22	249,000.0	2	75,000.0	1	5,000.0	300	800,000.0

Судалгааны зардал: Судалгааг дэмжих жилийн хүрээнд тайлант онд эрдэмтэн судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжихэд 800.0 сая төгрөгийг 300 багш, судлаач нарын судалгааны суурь зардал, өндөр түвшний судалгааны төсөл, залуу судлаачдын багийн грант, мэргэжлийн сэтгүүлийг дэмжих грант олголоо. Түүнчлэн зочин судлаачдын судалгааны тэтгэлэг, олон улсын судлаачдын хамтарсан төслийн санал боловсруулах үйл ажиллагааг дэмжих санхүүжилтийн зардалд олгосон байна. Дээрх зардлын 42.6 хувийг буюу 341.0 сая төгрөгийг судалгааны суурь зардлын санхүүжилтэнд, 16.3 хувь буюу 130.0 сая төгрөгийг залуу судлаачийн багийн грантад, 31.12 хувь буюу 249.0 сая төгрөгийг өндөр түвшний судалгаанд 9.4 хувь буюу 75.0 сая төгрөгийг зочин судлаачдад 0.6 хувь буюу 5.0 сая төгрөгийг олон улсын судлаачидтай хамтарсан төслийн санал боловсруулах үйл ажиллагааг дэмжихэд тус тус зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалт: Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын зардал 12.677,8 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 5.518.5 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 416.1 сая төгрөгийн лаборатори, тоног төхөөрөмжийн, 136.8 сая төгрөгийг шинээр баригдаж буй номын сангийн барилгын хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсэн байгаа ба үлдэх 12,124.9 төгрөгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна. Өөрийн хөрөнгийн санхүүжилтийн 78.2 хувь буюу 9,789.67 сая төгрөг нь шинээр баригдаж байгаа МУИС-ийн “Е”-номын сан болон хичээлийн 4-р байрны өргөтгөлийн барилга”-ын ажлын хөрөнгө оруулалт байна. Өөрийн хөрөнгөөр 1,010.7 сая төгрөгийн барилгын их засвар, хөрөнгө оруулалтын ажил хийж, 827.5 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, 282.3 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 199.2 сая төгрөгийн ном, сурах бичиг, 15.5 сая төгрөгийн биет бус хөрөнгө худалдан авсан. Тайлангийн хугацаанд Силк Роудын 100 сая вон, Монгол Улаанбаатар культур Е-Мартын 50.0 мянган америк долларын хандив тусламжийн орлогоор 97.3 сая төгрөгийн өртөг бүхий гадаад хэлний төвийн лаборатори шинээр байгуулсан ба 85.7 сая төгрөгийн өртөг бүхий номын сангийн тоног төхөөрөмж худалдан авлаа.

МУИС-ийн 2015 оны санхүүгийн тайлан, санхүүгийн ерөнхий дүр төрх

МУИС-ийн бүрэлдэхүүний болон салбар сургуулиуд, бусад нэгжүүд нь Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандарт, Сангийн яамнаас батлан мөрдүүлж байгаа аргачлал журам, МУИС-ийн захирлын 2015 оны А/165 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т тусгагдсан зарчим, шаардлагад нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэж, календарийн жилээр гаргаж байна.

МУИС-ийн төвлөрсөн сан, захиргаа, бүрэлдэхүүн, салбар сургууль болон бие даасан нэгж тус бүрээр санхүүгийн тайлан нь :

- Санхүүгийн байдлын тайлан (СТ-1А)
- Санхүүгийн үр дүнгийн тайлан (СТ-2А)
- Мөнгөн гүйлгээний тайлан (СТ-3А)
- Цэвэр мөнгөн хөрөнгө/Өмчийн өөрчлөлтийн тайлан (СТ-4А)
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан
- Санхүүгийн тайлангийн тодруулга (ТБСТТ-12)

гэсэн хэсгүүдтэйгээр бэлтгэгдэн гардаг бөгөөд тэдгээр санхүүгийн тусдаа тайлангуудыг МУИС-ийн санхүүгийн нэгдсэн тайланг санхүүгийн мэдээллийг боловсруулах “Поверсофт” программыг ашиглан нэгтгэн гаргаж байна

Сургуулийн хөрөнгө, эх үүсвэрийн бүрэлдэхүүн

2014 оны жилийн эцсийн тайлангаар 23.7 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 38.5 тэрбум төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө, нийт 62.2 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байсан бол 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 25.0 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 42.6 тэрбум төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө, нийт 67.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байна.

Хүснэгт 4.1.21

БАЛАНСЫН ЕРӨНХИЙ БҮТЭЦ

№	Утга	Балансын үлдэгдэл (сая.төг)		Өөрчлөлт /өмнөх оноос/	
		2014.12.31	2015.12.31	сая.төг	хувиар
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ					
1.1	Мөнгө	20,778.30	21,238.60	460.30	2.22%
1.2	Авлага ба бусад тооцоо	1,132.90	1,903.40	770.50	68.01%
	Үүнээс: төлбөрийн авлага	394.90	343.30	(51.60)	-13.07%
1.3	Бараа материалын нөөц	1,740.00	1,860.00	120.00	6.90%
	Үүнээс: хангамжийн материал	1,737.00	1,857.40	120.40	6.93%
1.4	Мал амьтад	3.10	3.10	-	0.00%
	Эргэлтийн хөрөнгийн дүн	23,654.30	25,005.10	1,350.80	5.71%
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ					
2.1	Үндсэн хөрөнгө	74,705.30	79,240.60	4,535.30	6.07%
	Хуримтлагдсан элэгдэл	(38,665.60)	(39,146.80)	(481.20)	1.24%
	ҮХ-ийн цэвэр дүн	36,039.70	40,093.80	4,054.10	11.25%
	Үүнээс: Барилга	29,992.30	32,774.60	2,782.30	9.28%
	Сургалтын машин, т/т	3,886.80	5,214.30	1,327.50	34.15%
	Тавилга, хэрэгсэл	2,160.60	2,104.90	(55.70)	-2.58%
2.2	Номын фонд	2,127.20	2,219.10	91.90	4.32%
2.3	Нийтийн тохижилт	143.20	117.20	(26.00)	-18.16%
2.4	Биет бус хөрөнгө, УХХО	207.70	205.40	(2.30)	-1.11%

Эргэлтийн бус хөрөнгийн дүн		38,517.80	42,635.50	4,117.70	10.69%
Нийт хөрөнгийн дүн		62,172.10	67,640.60	5,468.50	8.80%
3. ӨР ТӨЛБӨР					
3.1.	Бараа үйлчилгээний өглөг	377.50	294.70	(82.80)	-21.93%
3.2.	Ажиллагчдад өгөх өглөг	99.80	116.60	16.80	16.83%
3.3.	Бусад	213.90	113.10	(100.80)	-47.12%
3.4	Урьдчилж орсон орлого	4,384.70	5,927.50	1,542.80	35.19%
	БХӨ-ийн дүн	5,075.90	6,451.90	1,376.00	27.11%
Урт хугацаатай өр төлбөр					
Нийт өр төлбөрийн дүн		5,075.90	6,451.90	1,376.00	27.11%
4. ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ					
4	Засгийн газрын оролцоо	21,873.00	19,882.30	(1,990.70)	-9.10%
4.2	Хуримтлагдсан үр дүн	16,779.20	23,523.10	6,743.90	40.19%
	Үүнээс: тайлант оны	8,221.00	6,470.10	(1,750.90)	-21.30%
4.3	Дахин үнэлгээний нөөц	18,444.00	17,783.30	(660.70)	-3.58%
Өмчийн дүн		57,096.20	61,188.70	4,092.50	7.17%
Өр төлбөр ба өмчийн дүн		62,172.10	67,640.60	5,468.50	8.80%

МУИС-ийн нийт хөрөнгийн дүн 2015 оны тайлангаар 67,640.5 сая төгрөг болж 2013-2015 онд 13,626.9 сая төгрөгөөр буюу 25.2 хувиар, үүнээс 2014-2015 онд 5,468.4 сая төгрөгөөр (8.8 хувиар) нэмэгдсэн, хөрөнгийн нийт өсөлтийн 48.4 хувийг эргэлтийн хөрөнгийн (тэр дундаа мөнгөн хөрөнгийн), 51.6 хувийг эргэлтийн бус (сургалтын тоног төхөөрөмж болон дуусаагүй барилгын ажил зэрэг) хөрөнгийн өсөлт эзэлж байна.

Хүснэгт 4.1.22

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2015.12.31-ний байдлаар

Бүрэлдэхүүн сургууль, нэгжийн нэр	Бүгд дүн (сая ₮)
1.УБ хот дахь бүрэлдэхүүн сургууль	10,330.80
1.1 БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ	2,380.20
1.2 ОУХНУС	433.8
1.3 ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ	1,018.00
1.4 ХШУИС	1,644.20
1.5 ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ	4,854.50
Үүнээс: 1.5.1 ШУС ЗАХИРГАА	1,434.10
1.5.2 ШУС НУС	860.9
1.5.3 ШУС ХУС	1,374.20
1.5.4 ШУС БУС	1,185.30
2.Орон нутгийн салбар сургууль	1,238.30
3.Захиргаа, Төвлөрсөн сан	4,191.50
4.Бие даасан нэгж,бусад	5,478.00
Бүгд дүн (сая ₮)	21,238.60

2015 оны эцэст 21.2 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсны 8.5 тэрбум нь хугацаатай хадгаламж, 12.7 тэрбум төгрөг нь

харилцах дансны үлдэгдэл байлаа. Тайлангийн хугацааны эцэст Е-номын сангийн барилгын хуримтлалд зориулсан 7.0 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

6.2 СУРГАЛТЫН ОРЧИН, НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛАХ ТАЛААР

2015-2016 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу дараах засварын ажлууд дээр тендер зарлан, чиглэлийн дагуу үнэлгээний хороод ажиллан зохих болзол хангасан компаниудыг шалгаруулж, ажил гүйцэтгэж дууслаа. Үүнд:

- Хичээлийн 5-р байрны вакуум цонх солих болон засварлах
- Хичээлийн болон оюутны байруудын гадна болон дотор дулаан, цэвэр бохир усны шугам солих, хичээлийн 4-р байрны спорт заал, оюутны 6-р байрны холигч насосны үзель, халуун усны ялтсан бойлер шинээр солих
- Шинжлэх Ухааны Сургуулийн их болон урсгал засвар
- ХЗС-ийн их болон урсгал засвар
- Хичээлийн 5-р байрны 1,5,6 давхарын ариун цэврийн өрөөнүүдийн засвар
- Хичээлийн 1,2,4-р байруудад ХТП-145,149,538-с 0,4 кв-ийн кабель шугамуудыг шинэчлэн солих засвар
- ХШУИС-ийн их болон урсгал засвар
- БС-ийн их болон урсгал засвар
- Бизнесийн сургуулийн хичээлийн 8-р байрны спорт заалны дотор заслын засвар
- Хичээлийн болон оюутны байруудын хяналтын системийн тоног төхөөрөмж нийлүүлэх
- Е-номын сангийн барилгын дотоод интерьер дизайны зураг зуруулах
- Хичээлийн 6-р байртай холбоотой материалуудыг бэлдэн захирлуудад өгсөн

Захиргааны болон нэгдсэн үйлчилгээний чиглэлээр “Монголын эртний түүх 5 боть” зохиож хэвлүүлэх, “Юань улсын судар”-ын 7-18 дахь ботийг эмхэтгэн хэвлүүлэх” тендерүүдийг зохион байгууллаа. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлын хүрээнд үнийн судалгаа явуулан, ЭЗХБАЭ дэд захиралд танилцуулан, бага үнэ ирүүлсэн Бодь Ариусгал ХХК-тай гэрээ хийн, оюутны байрууд, зарим бүрэлдэхүүн сургуулиудад холбогдох ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийлгэсэн. Сургуулийн эмнэлэг нь Оюутны эрүүл мэндийг дэмжих аяны хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэгийг АШУҮИС-ийн харьяа Эрхэс поликлиниктэй хамтран өөрийн сургууль дээр явуулах, Хичээлийн байр болон оюутны байрны үйлчлэгч зохион байгуулагч нарт халдвар хамгаалал, цэвэрлэгээ үйлчилгээний талаар сургалт явуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ явуулахад зориулагдсан яаралтай тусламжийн эм тарианы хангалтыг зохих газруудтай гэрээ хийж татан авах, Хичээл болон оюутны байруудад тухайн өвчлөлтэй холбоотойгоор сургалт сурталчилгаа явуулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Захиргаа, төвлөрсөн сангийн ажилчдын нимгэн хувцсыг нормын дагуу жилд нэг удаа нийлүүлэх ажлыг хийж дуусган ажилтнуудад хүлээлгэн өгч, Хичээлийн байруудын сүлжээний зангилаанд засвар хийхтэй холбогдуулан шаардлагатай материалуудыг бэлдэн, МТА-нд хүлээлгэн өгч сургуулийн хэмжээнд интернетийн орчин тасалдалгүй ажиллах нөхцлийг бүрдүүлсэн. Автогражийн жолооч нар захиргаа, төвлөрсөн, БС, нэгжүүдэд машин техникээр үйлчилж ажиллаж байна.

Багш, ажилтны ахуй нөхцлийг сайжруулах чиглэлээр хийсэн ажил

- Багш ажилчдын 60 айлын орон сууцны хар цаасан дээврийн засвар, 4 орцын засвар

- Багш ажилчдын орон сууцны барилга ашиглалтанд орж зохих комисс хүлээн авч, айлууд орсон
- Өөрсдийн дотоодын нөөц бололцоон дээр тулгуурлан Сэлбэ зуслангийн нийт байшингуудад урсгал засварыг хийж, БС-иудын багш ажилтнуудыг хуваарийн дагуу гаргаж үйлчиллээ. Бүрэлдэхүүн сургуулиудын захиалгад үндэслэн багш, ажилтнуудад зуслангийн байрыг хуваарилж, түрээсийн гэрээг байгуулан ашиглуулж, ая тухтай байдлыг хангаж ажиллалаа.
- Оюутны 1, 2 дугаар байруудын 4 давхарт байрлах багш ажилчдын байрны давхрын ахлагчтай хамтран дээрх байруудад бүртгэл, үзлэг шалгалт хийж, Оюутны 2-р байрны 4 давхарт амьдарч байсан айлуудыг чөлөөлсөн.
- МУИС-ийн оюутны байруудын болон бусад газруудын төлбөр цаг хугацаанд нь хийлгэж, Түргэний гол дахь ногооны газрыг 50 багшид газар эзэмшүүлэх талаар ХУД-ийн газрын албанд албан тоотыг дахин хүргүүлсэн.

Оюутны байрны ахуй нөхцлийг сайжруулах чиглэлээр хийсэн ажил

- Хичээлийн болон оюутны байруудын гадна болон дотор дулаан, цэвэр бохир усны шугам солих, хичээлийн 4-р байрны спорт заал, оюутны 6-р байрны холигч насосны үзель, халуун усны ялтсан бойлерыг шинээр солив.
- Хичээлийн болон оюутны байруудын хяналтын системийн тоног төхөөрөмж нийлүүлэв.
- АСЕМ-ын хурлын үйл ажиллагаатай холбогдуулан бэлтгэлийг хангаж ажилласан бөгөөд Оюутны 4-р байран дээр 2 ширхэг, Оюутны 1-р байран дээр 1 ширхэг ус цэвэршүүлэгч, хөнжил, гудас, цагаан хэрэгслийг шинээр тавьсан.
- Нийт оюутны байрууд сар болгон гадна цэвэрлэгээний ажлыг тогтмол хийж байна.
- Хичээлийн байрны зохион байгуулагч нар ажилтнууддаа улиралд нэг удаа хөдөлмөр аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч ажиллаж байна.
- МУИСОК болон МУИС-ийн магистр докторын оюутны холбоодтой хамтран ажиллаж, хэрэгцээт бичиг хэргийн материалаар хангаж байна.
- Оюутны 5-р байрны 4 давхарын уншлагын заалыг засч тохижуулсан ба угаалтуур дутуу өрөөнд 2 тосгуур тавиулсан.
- Оюутны 3-р байранд шатны цонхнуудыг хуулгадаж, 2, 3 давхруудын бие засах газрын хаалгыг түгжээтэй болгосон. Мөн 3 давхрын угаалгын өрөөний угаалтуурыг шинээр сольж суурьлуулж, өрөө бүрийн хаалганы цоожыг засуулж, бүрэн бүтэн болгож, халуун усны өрөөний хаалга, салхивч эвдрэсэн байсныг засуулж, нийтийн эзэмшлийн өрөө тасалгаанд цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, өдөр тутам сантехникийн болон цахилгааны засвар үйлчилгээ хийж, дуудлага өгч ажиллаж, байрны бүх гал тогооны өрөөнүүдийг засварт оруулсан.

Байруудын хөрөнгийн ашиглалт бүртгэл, хяналтыг сайжруулах талаар

Эд хөрөнгийг актлах тайлан гаргах, БСШУЯ, ТӨХорооны хурлаар оруулж балансаас хасах шийдвэр гаргахад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж ажилласан. ТӨХ-ноос актлах хөрөнгийг шийдвэрлэсний дагуу хичээлийн, болон оюутны байрны зохион байгуулагч нарт зохих үүргийг өгч, хүн хүч, машины зохицуулалтыг цаг тухай бүрд нь хийж байна.

Сургалтын орчинг сайжруулах талаар

МУИС, Солонгос И март, Скай хайпермаркет ХХК, Монгол Улаанбаатар соёлын төв хамтран хичээлийн 2р байран дээр И март гадаад хэлний төвийг байгуулан зохих комисс хүлээн авч, ашиглалтанд оруулсан

Хичээлийн 4-р байрны заалны шалыг шинэ стандартын дагуу тавьж их засвар хийгдэж, шинээр хачин шат, сагсны шийд нийлүүлэгдсэн ба багш, оюутнууд нь таатай орчинд суралцаж байна.

Захиргаа, төвлөрсөн сан, хичээлийн болон оюутны байруудад холбогдох урсгал засварыг хийсэн.

2015-2016 оны хичээлийн жилд төгсөгчдөд дипломны хавтас, ромбо, ромбоны хайрцаг нийлүүлэх тендерийг зарлан, нийт төгсөгчдөд гардуулахад бэлэн болсон.

ЗХШҮА-нд хэрэгцээт баярын бичиг, хүндэт жуухын хавтас хийлгэн бэлэн болгосон.

СНА-нд хэрэгцээт оюутны үнэмлэх хэвлэхтэй холбогдуулан шаардлагатай бараа тоног төхөөрөмжийг нийлүүлж шинээр үнэмлэх авах болон үнэмлэхээ гээсэн оюутнууд цаг хугацаандаа үнэмлэхтэй болж байна.

Сургуулийн удирдлагын хэрэгцээнд шаардлагатай тавилга эд хогшил, бараа тоног төхөөрөмжийг цаг хугацаанд нь бэлэн болгон хүлээлгэн өгсөн.

Бусад ажлын талаар

Гүйцэтгэлийн аудитад хийсэн ажлын материал, тайланг танилцуулсан.

Сургуулийн худалдан авах ажиллагааны журмыг мөрдөн холбогдох тендерүүдийг гүйцэтгэсэн ба СЯ-ны ХХААБГ, ЗГ-ийг хэрэгжүүлэгч агенлаг ХААГ-тай хамтран ажиллаж байна.

МУИС-ийн хэмжээнд ХАА-ны АЗ гэрчилгээний сургалтанд багш, ажилтнуудыг хамруулан зохих тооцооллыг гарган ХҮХ-ийн дарга болон ЭЗХБАЭ дэд захиралд өгсөн.

Худалдан авах ажиллагааг ил тод, зохих хуулийн дагуу хэрэгжүүлэх зорилгоор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг сургуулийн вэб сайтад тавьсан. Нээлттэй болон харьцуулсан тендер шалгаруулалтыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл өдрийн сонин, ХАА-ны газрын e-procurement сайт дээр нийтлүүлэн хуулийн дагуу явуулах үйл ажиллагааны хүрээнд 2016 онд хийгдэх МУИС-ийн өөрийн хөрөнгөөр хийгдэх тендерүүдийг зарласан.

Барилгын инженер, техникч нарыг хариуцсан ажилтнуудыг ажлын байран дээр шууд удирдан ажиллаж ажлын үр дүн, хариуцлагыг нь сайжруулах чиглэлд удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлж ирлээ.

Сантехник, барилга, цахилгааны нэн яаралтай материалуудыг худалдан авах боломжийг судлан зохих компаниудтай гэрээ хийн ажиллаж байна. /Бага дүн бүхий худалдан авалтын босго үнэ даваагүй тохиолдолд/

Хичээлийн болон оюутны байрнаас ажилтан гарах болон түр чөлөө авах тохиолдолд судлан шалгаруулалтаар зохих ажилтанг шалгаруулж ажиллуулж байна.

Цаашдын зорилт

Хичээлийн болон оюутны байруудын сургалтын орчинг сайжруулах ажлыг тодорхой хэтийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, санхүүжилтын эх үүсвэрүүдийг

нэмэгдүүлэх, ялангуяа улсын төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд оршино.

Худалдан авалтын хууль эрх зүйн орчин шинэчлэгдэж байгаатай холбогдон сургуулийн худалдан авалтын журмыг гарган батлах /хууль эрх зүйн орчин шинэчлэгдснээс хойш/

Хичээлийн жилийн эхнээс өвөлжилтийн бэлтгэлд сургууль, тэнхим, багш, ажилтан, оюутны байгууллагууд нэгэн адил анхаарч аж ахуй, үйлчилгээний ажилтнуудтай нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

Бүрэлдэхүүн сургуулиуд, бие даасан нэгжүүд тухайн жилийн худалдан авалт болон их, урсгал засварын төлөвлөгөө, түүнээс гарсан ажлын үр дүнгийн тайлан мэдээгээ ХҮХ-т нэгтгэн ирүүлж байх, хийсэн ажлын гүйцэтгэл дээр хяналт тавих, зарим хэрэгжээгүй ажлуудын чиглэлээр холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай байна.

6.3 Мэдээллийн технологийг хөгжүүлэх чиглэлээр хийсэн ажил

2015-2016 оны хичээлийн жилд МТА нь 16 хүний бүрэлдэхүүнтэй ажлын байрны тодорхойлолтын дагуу ажиллалаа. Үйл ажиллагааны чиглэлээр сургалт, удирдлагын мэдээллийн системийн найдвартай ажиллагааг хангах, мэдээллийн технологи, мэдээллийн системийн ололтыг нэвтрүүлэх үүрэгтэй *Мэдээллийн системийн хөгжүүлэлтийн баг (7)*; сүлжээ, камер болон дотуур утасны найдвартай ажиллагааг хангаж ажиллах, шинэ технологийг нэвтрүүлэх үүрэгтэй *Сүлжээ, холбооны баг (3)*; багш, ажилчдад мэдээллийн систем, сүлжээ, холбоо ашиглах заавар зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, ажлын үүрэг, гүйцэтгэлийг хөтөлж, вебээр дамжуулан мэдээлэх үүрэгтэй *Хэрэглэгчид туслах баг (4)* гэсэн үндсэн 3 багийн бүрэлдэхүүнтэй ажиллалаа. Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлуудыг багцлан хүргэвэл:

МУИС-ийн сүлжээний дэд бүтэц, техник хангамжийг сайжруулах болон дотуур холбооны чиглэлээр хийгдсэн ажлууд:

- Сүлжээний гарцын төхөөрөмжийг Watchguard XTM 850 файрвол төхөөрөмжөөр шинэчлэн тухайн агшинд интернет холбогдох хандалтыг сайжруулсан. Төрөл бүрийн хортой код илрүүлэх IDS болон IPS системүүдийг ажиллуулж, төхөөрөмжийн логийг байнга бүртгэх боломж бүрдэж сүлжээний аюулгүй байдал сайжирсан. Серверүүдийн HTTPS протоколыг алба ёсны лицензээр лиценжүүлж сүлжээний нууцлалын протоколын аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн.
- Серверийн өрөө болон сүлжээний төхөөрөмжүүд засвар үйлчилгээг тухай бүр хийж сервер болон сүлжээний зангилааны төхөөрөмжийн хэвийн тогтвортой ажиллагааг хангаж ажилласан. Серверийн өрөөний хөргөлтийн системийг шинэчлэн сайжруулсан.
- Дотоод сүлжээний хүрээн ашиглаж байгаа утасгүй сүлжээний төхөөрөмжүүдийг бүртгэлжүүлж хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Шинээр утасгүй сүлжээний эрх авах хэрэглэгчид SISI мэдээллийн систем ашиглан сургуулийн утасгүй сүлжээнд бүртгүүлэх бүрэн боломжтой болсон.
- МУИС-ийн дотоод сүлжээгээр камер, медиа сервер, утастай болон утасгүй сүлжээ, дотуур холбоо хамааралтай тэдгээрийн хэрэглээ ихэссэнтэй холбогдон хичээлийн байр хоорондын дотоод сүлжээний холболтын шилэн кабелиар холбож хурдыг 1Gbps-с 10Gbps болгон нэмэгдүүлэх, зангилаа дээрх ракуудыг шинэчилж, тог

баригч тавьж ажиллуулахаар төлөвлөж шаардагдах техникийн худалдан авах ажиллагаа хийгдэж байна.

- Шинэ номын сангийн барилгын сүлжээний дэд бүтэц, холбоо дохиоллын системийн шаардлага гаргаж сүлжээ, дохиолол холбооны зурагт тусгууллаа. Тухайн барилгад байрлах серверийн өрөөний тоноглол, зураглалыг гаргасан.
- Интернетийн хурдыг нэмэгдүүлэх, давхар гарцтай болох ажлын хүрээнд интернетийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудаас техникийн болон үнийн судалгаа хийж сонгон шалгаруулалтыг үйл ажиллагааг эхлүүлэхэд бэлэн болгосон.
- Байгаль Эх лицей ахлах сургуулийн дотоод сүлжээнд 50 Mbps утасгүй сүлжээгээр холбогддог байсныг шинэчлэн шилэн кабелийн холболт хийж өндөр хурдаар сургуулийн сүлжээнд бүрэн холбогдсон. Тухай сургуулийн хичээлийн байрны хяналтын камерын сервер үйл ажиллагааг төв серверт шилжүүлэн найдвартай хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.
- Хяналтын камерын системийг сайжруулж, камерын тоог нэмэгдүүлж, техникийн үзүүлэлтийг сайжруулах ажлыг эхлүүлсэн. Хяналтын камерын системийг анх 2010 онд суурилуулалт хийгдсэн бөгөөд сүүлийн жилүүдэд төхөөрөмжийн эдэлгээ, цахилгааны хэлбэлзэл, техникийн насжилт зэргээс хамаарч хяналтын камерууд үйл ажиллагаа доголдож ирсэн. Хяналтын камерын системийг сайжруулах ажлын хүрээнд шаардагдах төхөөрөмж, камерын судалгаа тооцоог хийж хэвийн ажиллагаатай камерын тоог гаргасан; боломжтой камерыг сэлбэн засаж ажиллагаанд орууллаа; шинээр авах тоног төхөөрөмж, камер техникийн үзүүлэлт, тоог ширхэг, системийн үзүүлэлтйн тооцоог хийж хамаарах сургууль, алба хэлтсээр хянуулан батлуулж төсөв тусгуулсан. Шаардлагатай тоног төхөөрөмж, камер, техник хангамжийг худалдан авах саналаа Хангамж үйлчилгээний хэлтэс хүргүүлээд байна.
- Захиргааны ажилчдын компьютерийг лицензтэй үйлдлийн систем суулгаж нэгдсэн нэг домайны зохион байгуулалт хийсэн.
- МУИС дотоод сүлжээнд суурилсан дотуур холбооны системийг шинэчлэн сайжруулж дотуур холбооны утсанд ирсэн дуудлагыг өөрийн гар утсанд хүлээн авах системийг туршиж хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болгосон. Тухай систем нэвтэрснээр багш ажилчид дотоод сүлжээний хүрээнд өөр бүртгэлтэй дотуур утасны дуудлагыг гар утсанд хүлээн авах боломжтой болно.

Цахим хуудсыг сайжруулах ажлын хүрээнд хийгдсэн ажлууд:

- МУИС-ийн цахим хуудсыг шинэчлэн үндсэн болон мэдээний цахим хуудас болгон хувааж үйл ажиллагааг ангилан сайжрууллаа. Шинээр нийтлэгдсэн мэдээ, мэдээллийг сошайл медиагаар шууд түгээх, бүртгэлтэй цахим хаягаар хүлээн авах боломж бүрдүүлсэн. Цахим хуудсанд орох агуулгыг хамаарах алба, хэлтсүүдээр бэлтгүүлэн шинэчлэх ажил хийгдэж байна.
- Дотуур утасны дугаарыг албан тушаал, өрөө, хэрэглэгчдэд харьяалуулан холбох модулийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлж утасны жагсаалтыг цахим хуудсанд байршуулсан. Ингэснээр цахим хуудас дээр дотуур утасны жагсаалт шууд шинэчлэгдэж байхаас гадна утасны дугаар, хэрэглэгч, өрөөгөөр хайлт хийх боломж бүрдсэн.
- МУИС-ийн мобайл апплекэйшиныг үндсэн загварыг тодорхойлж кодын хөгжүүлэлтийг хийсэн. Мобайл апплекэйшиныг андройд, ios, виндоус мобайл

үйлдлийн систем дэмжихээр хөгжүүлж, апплекэйшинд орох агуулгыг цахим хуудаснаас шууд авч байхаар төлөвлөн ажиллаж байна.

“SIS” сургалт удирдлагын мэдээллийн системийг өргөтгөх, сайжруулалт, өөрчлөлтийн хүрээнд хийгдсэн ажлууд:

- Сургалтын журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан журамд тусгагдсан өөрчлөлтийн дагуу сургалт удирдлагын мэдээллийн системийн хөтөлбөр, оюутны бүртгэл болон төлөв, хичээл, хичээлд санал өгөх болон баталгаажуулах, суралцагчийг дүгнэх модулиудад өөрчлөлтийг хийсэн.
- Сургалтын журмын орсон хөтөлбөрийн агуулга, шаардлагын өөрчлөлтийг системд тусгаж дараах өөрчлөлтийг хийсэн.
 - Сургалтын төлөвлөгөөг багцуудаас бүрдэж байхаар задалсан. Сургалтын төлөвлөгөө багцуудаас бүрдэг болсноор сургалтын төлөвлөгөө бүрд байх ижил байх багцыг нэг удаа үүсгэж шаардлагатай төлөвлөгөөнд татаж оруулдаг болгон өөрчилсөн. Ингэснээ сургалтын төлөвлөгөөнд хичээл дутуу оруулах, нэг төрлийн хичээл олон дахин үүсгэх, систем ашиглахад хялбар бол нэг ижил үйлдлийг олон дахин давтан хийх ажиллаагүй болж төлөвлөгөө шинээр үүсгэх, хянах, засах ажиллагаа хялбар болсон. Багц бүрийн биелүүлэх багц цагийн тусад тодорхойлж, төлөвлөгөөнд татан оруулахдаа батлагдсан хэмжээгээр өөрчлөх боломжтой болсон.
 - Сургалтын төлөвлөгөөний батлагдсан эх хувийг файлаар системд байршуулж тухай төлөвлөгөөгөөр суралцагчдад харуулдаг болгосноор өөрийн төлөвлөгөө давхар хянах боломжтой болсон.
 - Сургалтын журмын дагуу сургалтын төлөвлөгөөнд чөлөөт сонгоны хэсгийг сайжруулан хөгжүүллээ. Ингэснээр суралцагч өөрийн төлөвлөгөөн бусад МУИС хэмжээнд дэх дурын төлөвлөгөөнд байгаа хичээлд санал өгч, сонгон судлах боломж бүрдсэн.
- Сургалтын төлөвлөгөөг шинэ бүтцийн дагуу өөрчлөлт хийж, хос болон хавсарга мэргэжлээр суралцах боломжид тааруулан өөрчилсөн. Үүнтэй уялдуулан суралцагчийн бүртгэлийн өөрчилж нэгдсэн нэг бүртгэлтэй байхаар өгөгдлийн сан болон хамаарах кодуудад өөрчлөлтийг хийсэн. Ингэснээр нэг бүртгэлтэй суралцагчдад нэг хөтөлбөр хамаарна гэсэн ойлголтыг өөрчилж оюутан хэд хэдэн хөтөлбөрт харьяалагдан суралцах боломж бүрдсэн.
- Сургалт удирдлагын мэдээллийн системийн үндсэн цэс, тайлангийн хэсгийг хэрэглэгчийн шаардлагын дагуу бүлэглэж шинэчлэн зохион байгуулсан. Системийн эрх зохицуулалтын модулийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Албан тушаалтны мэдээллийн систем ашиглах эрх зохицуулалтыг ЗХШҮАлбанас гаргуулж системд тусгасан.
- Статистик тайлангууд болох суралцагчдын мэргэжлийн тоон үзүүлэлт (ДБ-1), суралцагчдын насны тоон үзүүлэлт (ДБ-3), суралцагчдын орон нутгийн тоон үзүүлэлт (ДБ-7), ажилчдын тоон үзүүлэлт (ДБ-9) гэх мэт боломжид тайлангуудыг систем гарган авах боломжийг бүрдүүлсэн. Алба нэгжүүдэд шаардлагатай байгаа тайлангуудын тухайн бүрд системд тусган нэмж оруулсан.
- МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжсэн суралцагчийн хуучин төлөвлөгөөнд үзсэн боломжит хичээлийг шинэ төлөвлөгөөнд дүйцүүлэх тооцох хэсгийг нэмж хөгжүүлж систем байрлуулсан. Ингэснээр шилжин суралцан, хос болон хавсарга мэргэжлээр суралцагчийн өмнөх төлөвлөгөөнд үзсэн ижил хичээлийг шууд дүйцүүлэх, дүйцүүлж

болох бусад хичээлийг хамаарах нэгжүүд зөвшөөрөлтэй дүйцүүлэх боломжтой болсон.

- SISI мэдээллийн системийн сургалтын албаны хичээл оноох, хөтөлбөр, хичээл, хичээл бүлэглэх, оюутны төгсөх хүсэлт гаргах, хичээл санал өгөх баталгаажуулах хэсгийн кодыг олон хөтөч дэмжин ажиллах боломжтой болгон кодыг шинэчлэв.
- Сургалтын албаны хичээл хуваарь оруулах, хэрэглэгчид өөрийн болон бусад хуваарь харах хэсгийг хэрэглэгчийн шаардлагын дагуу шинэчлэн сайжрууллаа. Ингэснээр хичээлийн хуваарь ямар хөтөч ашиглан оруулах боломжтой болсноос гадна хуваарийг хичээл, багш, өрөөгөөр ангилан шүүж харах, өөрчлөлт оруулах боломж бүрдсэн.
- Хичээл адилтгалын модулийг хэрэглэгчийн хүсэлтийн дагуу шаардлага тодорхойлон хөгжүүлж систем орууллаа. Сургалтын төлөвлөгөөний өөрчлөлтөөс хамаарч агуулга ижилтэй хичээлийн нэр, индекс өөрчлөгдөх тохиолдол гардаг. Иймд хуучин төлөвлөгөөний хичээлийг шинэ төлөвлөгөөний хичээлтэй адилтгах боломжийг бүрдүүлж системд тусгасан.

Шинээр нэвтрүүлсэн мэдээллийн системүүд, хийгдсэн бусад ажлууд:

- SISI мэдээллийн систем мэдээ, мэдээлэл илгээх хэсгийг шинээр нэмж оруулсан. Мэдээ мэдээлэл илгээх хэсгийг ашиглан Захиргаа, СНА, Сургалтын албан, тэнхимээс багш, ажилчид, тухайлсан хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутанруу; Багш нар өөрийн зааж буй хичээлийг судалж байгаа оюутанруу мэдээлэл, зарлал, анхааруулга зэргийг илгээх боломж бүрдсэн.
- Бүртгэлийн системүүдийг нэгдсэн удирдлагын хэсгийг хөгжүүлсэн. Бүртгэлийн системүүдийн үйл ажиллагаа нэг стандарт болгох загварыг бэлтгэсэн, хураамж төлөх боломжийг нэмэгдүүлж шилжилтийг бүртгэлийн системд туршсан.
- Дотуур байрны бүртгэлийн системийг хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлсэн. Энэхүү системээр оюутан дотуур байранд орох хүсэлтээ системээр гаргах, зохих журмын дагуу жагсаалт үүсгэж байр, өрөөг сонгуулж төлбөрийг онлайнгаар төлөх боломж бүрдсэн.
- OAuth протокол ашиглан бусад системд API бэлтгэж өгснөөр хэрэглэгчид МУИС ашиглагдаж байгаа мэдээллийн системүүдэд нэг эрхээр бусад системд нэвтрэх боломжтой болсон. Мэдээллийн системүүд хооронд өгөгдөл солилцох боломж бүрдсэн.
- Төслийн бүртгэл, менежментийн мэдээллийн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Тухай системийг ЭШИХэлтэс ашиглан 2016 оны Профессор, дэд профессор, доктор багш нарын судалгааны суурь зардал, Залуу судлаачдын багийн грант, Өндөр түвшний судалгааны төслийн бүртгэл, шалгаруулалтыг үйл ажиллагаа явуулж туршсан.
- Бүтээлийн хулгайгаас сэргийлэх систем үндсэн суурийг тавьж үйл ажиллагаа туршин зүгшрүүлэхээр ТДС, номын санд хүлээлгэн өгсөн.
- Эрдэм шинжилгээний менежментийн систем, багшийн ажлын үнэлгээний системийн анхны хувилбарыг гаргаж туршилтаар ХШУИС 2015-2016 хичээлийн жилийн эрдэм шинжилгээний бүтээлийг бүртгэлжүүлж, багшийн ажлын үнэлгээг хийж туршсан.
- Мэдээллийн технологийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг хамаарах нэгж, мэдээллийн технологийн бодлогыг зөвлөл оролцоотойгоор боловсруулж захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн. МУИС 2024 хүртэлх

хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулж мэдээллийн технологийг 2016-2024 хөгжүүлэх үндсэн зорилгыг мэдээллийн нэгдсэн бааз бий болгох, мэдээллийн технологийн орчин үеийн техник, технологийн орчныг бий болгох, үүлэн технологид суурилсан бүрэн цахимжсан удирдлагын үйл ажиллагаа нэвтрүүлэхээр тодорхойлж тухай зорилгод хүрэхийн тулд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүнг тухай бодлогын баримт бичигт тусгасан.

- Мэдээллийн технологийн ашиглалт, үйл ажиллагаатай холбогдолтой дүрэм журмыг анхны драфтыг гарган хэлэлцүүлэгт бэлтгээд байна.
- Мэдээллийн технологийн албаны үндсэн үйл ажиллагааны таван (Мэдээллийн систем; сүлжээ, холбооны зохион байгуулалт; техник хангамж; цахим хуудас; салбарын үйлчилгээ) чиглэлээр тодорхойлж чиглэл бүр хамаарах 33 үйл явцын диаграммыг байгуулсан.

Мэдээллийн технологийн албанаас хэрэгжүүлж байгаа гадаад, дотоод төсөлт ажлууд:

- **DAAD төсөл:** МУИС-д хэрэгжиж буй DIES төслийн “Мэдээллийн Технологийн дэд бүтцийг хөгжүүлэх” дэд зорилтын хүрээнд Германы Martin-Luther-University Halle-Wittenberg (MLU) сургуулийн ITZ төвийн мэргэжилтнүүд 3 удаагийн уулзалт хэлэлцүүлэг 2016 оны 5-р сарын 29 өдрөөс 6-р сарын 3 хооронд МУИС дээр явагдлаа. Энэ удаагийн хэлэлцүүлгээр шинэ номын сангийн барилгын сүлжээний дэд бүтэц, серверийн өрөөний тоноглол, цахим сургалтын системийг хэрхэн нэвтрүүлэх, мэдээллийн технологийн үйл ажиллагааны бизнес процессыг тодорхойлох тал дээр санал солилцон, туршлага судаллаа. Төслийн хүрээнд МТА мэргэжилтэн нэг сарын хугацаатайгаар БНСУ-ийн Ханбат их сургуульд очиж их сургуулийн сүлжээний дэд бүтэц, техник технологийн шийдлийн талаар туршлага солилцон, зөвлөгөө авлаа.
- МУИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэстэй хамтран дотоод төслөөр хэрэгжүүлж байгаа төслийн бүртгэл, менежментийн мэдээллийн систем; эрдэм шинжилгээний менежментийн систем; багшийн ажлын үнэлгээний систем; бүтээлийн хулгайгаас сэргийлэх системүүдийн хэрэглээнд нэвтрүүлж туршилтын ажил хийгдлээ.

Мэдээллийн технологийн алба тайлант хугацаанд сүлжээний дэд бүтцийг сайжруулж, гарцын болон үндсэн зангилааны төхөөрөмжийг шинэчлэх аюулгүй ажиллагааг нэмэгдүүлэх, хяналтын камерийг системийг өргөтгөн сайжруулах, серверийн хэвийн ажиллагааг сайжруулах, сургалтын журмын өөрчлөлтийг SISi мэдээллийн системд тусгаж хэрэглэгчийн шаардлагын дагуу өөрчлөлт оруулах зэрэг ажлуудаас гадна шинээр оюутаны дотуур байрны бүртгэлийн систем; мэдээ мэдээлэл илгээх модуль; төслийн бүртгэл, менежментийн мэдээллийн систем; эрдэм шинжилгээний менежментийн систем; багшийн ажлын үнэлгээний систем; бүтээлийн хулгайгаас сэргийлэх системүүдийг туршилтаар хэрэглээнд нэвтрүүлсэн зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.